

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

**2018 №3 (65)
16 дахь жилдээ**

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ **ЭРХЛЭГЧ**

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батбуян БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун Бат-Эрдэнэ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Насанжаргал ГАНБАДРАЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Ганбат ЭРДЭНЭБАТ
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ШАДАР ЗӨВЛӨХ

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D)

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

Хүчитбаатар БАДНААЖОНОН

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого: Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх асуудал.....Б.Баяндүүрэн 5

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Өмчийн эсрэг ашиглан шамшигдуулах гэмт хэрэг: уламжлал, шинэчлэл, шийдвэрлэх асуудал.....С.Нарангэрэл 13

Дээрэмдэх гэмт хэргийн үндсэн шинж, зүйлчлэлийн асуудал.....Ж.Эрдэнэбулган 16

Өмчлөх эрхийг хамгаалах эрүүгийн эрх зүйн онолын зарим асуудал.....Ч.Нямсүрэн 20

Өмчлөх эрхийн эсрэг гэмт үйлдсэн хүнийг баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах үед анхаарах асуудал.....Л.Бат-Очир 25

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн зүйлчлэл ба ял /Хулгайлах гэмт хэргийн жишээн дээр/.....Б.Ганболд 29

Залилах гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхэд анхаарах асуудал.....Ц.Гантулгабат 36

Мөнгө угаах гэмт хэргийг гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдал, харьцуулсан судалгаа.....Т.Мөнхдалай, Б.Досжан 44

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Об основаниях ареста подозреваемого по УПК Монголии 2017 года.....Даш Тамир 52

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Цагдаагийн албан хаагчийн дундаж наслалт, түүнд хийсэн судалгаа.....Б.Энхболд, Э.Уянга 55

Цагдаагийн байгууллагаас хөтлөх зөрчлийн статистик, түүний онцлог.....Г.Гэрэлсүрэн 64

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Хорих байгууллагын аюулгүй байдал ба эрсдэлийг үнэлэх ажиллагааны харилцан хамаарал.....Ц.Очгэрэл 72

ШИНЖЛЭХ УХААНЫ СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Эрдэм шинжилгээний өгүүлэл бичихэд анхаарах асуудал.....С.Гантулга, Б.Энхболд 78

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ТӨРИЙН БОДЛОГО: ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АСУУДАЛ

Б.Баяндүүрэн

Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны мэргэжилтэн, хууль зүйн магистр


Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, түүний дотор хулгайлах гэмт хэргийн гаралт, түүнд холбогдогч, шүүхээр шийтгүүлэгчдийн статистикт тулгуурлан гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд баримтлах төрийн бодлогын талаар асуудал дэвшүүлсэн.

Төрийн үндсэн чиг үүргүүдийн нэг нь иргэдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аливаа хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлж хамгаалах, хууль зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх замаар нийгэмд шударга ёс, дэг журмыг тогтоох билээ.

Төрийн энэхүү үүргийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж, Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалтад: “эрүүл, аюулгүй орчинд амьдрах,... эрхтэй” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж тус тус заажээ.

Улмаар Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг байхаар заасан.

Монгол Улсын 1968 оноос хойшхи 49 жилийн гэмт үзэгдлийн төлөв байдал, хандлагыг авч үзье. Монгол Улсад гэмт хэргийн гаралт 1968 оноос 2017 он хүртэл 9.4 дахин өсчээ. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас өрсөлдөөнт зах зээлийн эдийн засгийн шинэ нийгэмд шилжсэн үе болох 1992 он 12.467 гарч байсан бол сүүлийн 25 жилийн хугацаанд 2017 он 32.259 болж, 2.6 дахин өссөн байна.



Монгол Улс дахь гэмт хэргийн төлөв байдал, чиг хандлагаас үзэхэд тухайн үеийн нийгэм, эдийн засгийн шалтгаан гэж шууд хэлэхээс илүүтэй Эрүүгийн хуультай шууд холбоотой гэсэн дүгнэлтийг ч хийж болохоор байна. Иймд тухайн нийгэм дэх сөрөг үзэгдэлтэй

тэмцэхийн тулд сөрөг гэж үзэж буй нийгмийн харилцаатай тэмцэх, арилгахын тулд Эрүүгийн хуулийг оновчтой болгох нь гэмт үзэгдлийн чиг хандлагад шууд хамааралтай байдал ажиглагдав.

Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсад 242,051 (жилд дунджаар 24,205) гэмт хэрэг бүртгэгдэж, нийт хэрэгт 207,843 хүн холбогдон шалгагдсан статистик мэдээлэл байна.

Хүснэгт 1. Гэмт хэргийн хөдөлгөөн


Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүртгэгдсэн гэмт хэрэг	20704	20373	19825	19197	22089	25362	27318	27757	27167	32259
Өсөлт, бууралт /хувиар/	-2.7	-1.6	-2.7	-3.2	15.1	14.8	7.7	1.6	-2.1	18.7
Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан хүн	18642	19612	19378	17982	19734	22286	23737	24857	23805	18131
Өсөлт, бууралт /хувиар/	4.7	5.2	-1.2	-7.2	9.7	12.9	6.5	4.7	-4.2	-23.8

Гэмт хэргийн гаралт 2008-2011, 2016 онд өмнөх оныхоос 1.6-3.2%-аар буурч, харин 2012-2015, 2017 онд өмнөх оныхоос 1.6-18.7%-аар тус тус өссөн байна. Сүүлийн 10 жилийн дунджаас харахад гэмт хэргийн гаралт жилд 1283 хэргээр нэмэгджээ.

Гэмт хэргийн төрөл.

Улсын хэмжээнд 2008-2017 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 31.7%-ийг хулгайлах, 29.0% нь бусдын бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учруулах, 6.0% нь залилан мэхэлж авах, 6.4% нь танхайрах, 5.5% нь ТХХАБАЖЭсрэг, 2.8% нь дээрэмдэх, 1.4% нь хүчиндэх, 1.3% нь завших, үрэгдүүлэх, 15.9% нь бусад төрлийн гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

График 1. 2008-2017 онд бүртгэгдсэн гэмт хэргийн төрөл (Эрүүгийн хуулийн зүйлээр)




Мөн 2008-2017 онд улсын хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 244368 хүн эрүүл мэнд, эд хөрөнгө, сэтгэл санаагаараа, 3135 байгууллага, аж ахуйн нэгжид 1039.1 тэрбум төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирчээ.

Сүүлийн 10 жилийн судалгаанаас үзвэл Эрүүгийн хуулийн тусгай ангийн бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг /хуучнаар/ нь Монгол Улс дахь гэмт хэргийн бүтцэд дангаараа

28-37%-ийг эзэлж, нийт хулгайлах гэмт хэргийн 60% нь Улаанбаатар хотод, 40 орчим хувь нь хөдөө орон нутагт үйлдэгдсэн байна.

Хулгайлах гэмт хэргийн улмаас иргэд, ААН, байгууллагад бий болсон хохирлын хэмжээ жилээс жилд нэмэгдэж, энэ нь шунахайн сэдэлтэй, нийтлэг үйлдэгддэг гэмт хэрэг болоод байна.

Нийт гэмт хэргийн бүтцэд хулгайлах хэргийн эзлэх хувийн жин



Судалгаагаар нийт бүртгэгдсэн гэмт хэргийн доторх эзэлж буй хувь хэмжээгээрээ Монгол Улс дахь гэмт хэргийн түвшин, хөдөлгөөн нь хулгайлах гэмт хэргийн түвшингээс хамааралтай байгааг харуулж байна. Тухайлбал, 1998 оноос бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг буурсан байдаг.

Тухайн үед Монгол Улсын эдийн засгийн өсөлт, иргэдийн амжиргааны болон боловсрол, соёлын түвшин дээшилсэн нь гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаанд эерэгээр нөлөөлсөн бол 2007 онд өссөн ч эргээд 2011 он хүртэл буурч, одоогийн хандлага өсөх төлөвтэй байна.

Дээрх нөхцөл байдлаас харахад энэ төрлийн гэмт хэргийн гаралт, хандлага улс орны эдийн засгийн нөхцөл байдалтай шууд хамааралтай гэсэн дүгнэлт гарч байна.



Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн түвшингээр үзвэл 2008-2011, 2016 онд 1.1-9.4 хувиар буурсан үзүүлэлттэй байх боловч 2012-2015, 2017 онд өмнөх оныхоос 6.8-29.2 хувиар тус тус өсчээ.

Хулгайлах гэмт хэрэг өсөх хандлагатай байгаа бол мал хулгайлах гэмт хэрэг буурах төлөв ажиглагдаж байна. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогыг сайжруулах, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутагт малчдын оролцоотойгоор оновчтой зохион байгуулж байгаа зэрэгтэй холбон тайлбарлаж болно. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуульд “Мал сүрэг бол үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэсэн заалтыг удирдлага болгон “Мал хулгайлахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай” хуулийг 2004 онд баталсан, мөн 2015 онд батлагдаж, 2017 онд нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 12-т мал хулгайлах үйлдлийг бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргээс ялгаж, бие даасан байдлаар

төрөлжүүлэн хуульчилж, оногдуулах ялын бодлогыг тодорхойлсон нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын илэрхийлэл юм.



Сүүлийн 10 жилийн байдлаар Хулгайлах гэмт хэрэг үйлдэн цагдаагийн байгууллагад шалгагдсан 60 орчим хувь нь 18-35 насныхан, 2 хүн тутмын нэг нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 3 хүн тутмын нэг нь бүлэглэн гүйцэтгэсэн, 11 хүн тутмын нэг нь урьд өмнө нь шүүхээр ял шийтгэгдсэн байгаагаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх арга, хэлбэр нь улам нарийсч байгаа нь зүй ёсоор анхаарал татаж байна.

Эрүүгийн хуульд заасан ялуудаас гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хор аюулын хэр хэмжээ, түүний хувийн байдалд нь тохирсон ялыг сонгон хэрэглэсэн тохиолдолд ялын үр нөлөө сайн байдаг гэж судлаачид үздэг билээ.

Шүүхээс бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт оногдуулсан ялын төрөл, хэмжээг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзлээ.

Монгол Улсын хэмжээнд 2011-2015 оны хооронд анхан шатны шүүхээр хулгайлах гэмт хэрэг 6600 шийдвэрлэгдсэн нь нийт хэргийн 21.5%-ийг эзэлж байна. Шүүхээр шийдвэрлэгдэж буй хулгайлах хэргийн тоо 2012 оноос жил дараалан өсч, 2015 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байсан нь өмнөх онтой харьцуулахад 82 хэрэг буюу 5.7%-аар өссөн байна.

Шийдвэрлэгдсэн хулгайлах гэмт хэргийг түүний бүрэлдэхүүний төрлөөр нь авч үзвэл нийт хулгайлах гэмт хэргийн 9.6% ердийн бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 1 дэх хэсэг), 87.3% хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 2, 3 дэх хэсэг), онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 4 дэх хэсэг) 2.9%-ийг эзэлж байна.

Хулгайлах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдлын судалгаа (2011-2015)

Жил	Хулгайлах хэрэг	Хөнгөн (145.1)	Хүндэвтэр (145.2)	Хүнд (145.3)	Онц хүнд (145.4)
2011	1282	146	1064	55	27
2012	1281	147	1070	20	50
2013	1283	98	1111	33	41
2014	1336	129	1114	53	38
2015	1418	117	1234	16	37
Нийт	6600	637	5593	177	193

Дээрх судалгаанаас үзвэл хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хулгайлах гэмт хэрэг тухайлбал, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 2 дах хэсгээр шийдвэрлэгдсэн хэрэг жил дараалан өсч байна. Энэ хэсэгт хулгайлах гэмт хэргийг түгээмэл үйлддэг арга, халдлагын зүйл, газар болох орон байр агуулах сав зэргийг тусгайлан (орон байр, агуулах саванд нэвтрэх, мал хулгайлах, бүлэглэн болон давтан үйлдэх гэх мэт) заасан, хохирлын хэмжээ нь ч гэсэн дундаж энэ зүйлчлэлд тохирч байгаатай холбоотой байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын тухайд

Монгол Улс нь Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа гэмт хэрэгтэй тэмцэх үзэл баримтлалаа тунхаглаж Эрүүгийн хуулиараа баталгаажуулан, шүүхийн болон прокурорын байгууллагын, цагдаагийн албаны зэрэг салбар хуулиудад гэмт хэрэгтэй тэмцэх үүргийг нарийвчлан тусгаж зохицуулсан байна.

Үүний зэрэгцээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт гэмт хэрэгтэй тэмцэх нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг ханган ажиллах, иргэдийн амгалан тайван, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх, үндэстэн дамнасан, зохион байгуулалттай, шинэ болон тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр дунд хугацаанд ажиллах үндэсний хөтөлбөр боловсруулан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, түүнд зарцуулах төсвийг нарийн тооцож, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж хэвшжээ.

Монгол Улсын Их Хурал 1992 оны намрын чуулганаараа “Монгол Улсын Үндсэн хуульд нийгмийн дэг журам хангах талаар хүлээлгэсэн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ төрт ёсны болон үндэсний уламжлал, зан заншлыг сэргээн хөгжүүлж, эдийн засаг, нийгэм, улс төрийн бүхий л хүрээнд хууль тогтоомжийг сахиулах, түүний дотор гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд чиглэсэн эдийн засаг, нийгэм, хууль зүйн цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэх явдал зайлшгүй шаардлагатай болж байгааг харгалзан дараах асуудлыг төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл болгон тодорхойлж байна.” хэмээн үндэслэл болгон “Монгол Улсад нийгмийн дэг журам хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл”-ийг баталжээ.

Энэхүү чиглэл нь нийгмийн дэг журам бэхжүүлэх агуулгын дор гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа, эрх зүйн орчныг боловсронгуй болгох томоохон ач холбогдолтой баримт бичиг юм.

НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас 2015 онд “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд “Амгалан тайван, бүх нийтийн оролцоог хангасан хууль ёст тогтвортой хөгжлийн нийгмийг бүрдүүлж, үр нөлөөтэй, хариуцлагатай, оролцоо бүхий чадварлаг институцийг бүх шатанд бий болгох” зорилтыг дэвшүүлж, “Олон улсын хамтын ажиллагааны шугамаар үндэсний, ялангуяа хөгжиж байгаа орнуудын холбогдох институцийн чадавхыг бүх түвшинд бэхжүүлэх, хүчирхийллээс сэргийлэх, терроризм, гэмт хэрэгтэй тэмцэх” үйл ажиллагааг тодорхойлсон.¹

Монгол Улс дээрх хөтөлбөртэй уялдуулан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” хөтөлбөрийг² баталж, “Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсөж байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно” хэмээн тодорхойлсон бөгөөд энэхүү хөтөлбөрийн агуулгад Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын шалгуур үзүүлэлт тэр дундаа хүний аюулгүй амьдрах баталгааг хангах асуудал баталгаажиж байж хөтөлбөр хэрэгжих нэг нөхцөл бүрдэнэ.

Дэлхийн улс орнуудын аюулгүй байдлын стратегид гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бодлого хамаардаг ба энэ нь төрийн байгууллагын оновчтой механизм, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, ял шийтгэл, бусад эрүүгийн эрх зүйн шинжтэй арга хэмжээг гүйцэтгэх, тэдгээрт хяналт тавих салбар дахь төрийн бодлогод суурилдаг болох нь Өмнөд Африкийн бүгд

¹ НҮБ-ын Ерөнхий ассамблейн 70 дугаар чуулган. Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой Хөгжлийн хөтөлбөр”. АНУ. Нью Йорк., 2015

² Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралт. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030

найрамдах улс 2013 онд батлан хэрэгжүүлж байгаа “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх стратеги”³, Их Британи Умард Ирландын нэгдсэн вант улсад 2015 оноос хэрэгжүүлж буй “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах тухай”⁴, Оросын холбооны улсын “Гэмт хэргийн талаар баримтлах төрийн бодлого”⁵ гэсэн баримт бичгүүдээс харж болох юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын⁶ 3.3 дахь хэсэгт “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, Үндсэн хуульт байгууллыг баталж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн” гэж тодорхойлсон.

Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтад цагдаагийн төв байгууллага нь агентлагийн нийтлэг чиг үүргийн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн талаар санал боловсруулах үүрэг гүйцэтгэхээр тусгагдсан.⁷

Улсын хэмжээнд 2014 онд нийт 681222 зөрчил, 2015 онд нийт 1423088 зөрчил, 2016 онд нийт 945877 зөрчил тус тус бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 33.5%-иар буурч байсан бол 2017 онд 1327017 зөрчил бүртгэгдсэн байгаа нь өмнөх оныхоос 288967 зөрчлөөр буюу 27.8%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэрэг, зөрчлийн тоон үзүүлэлтийг сүүлийн 8 жилээр хүснэгтлэн харуулбал,

Он	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Хэрэг	20373	19825	19197	22089	25362	27318	27757	27167	32259
Зөрчил	880988	550210	653619	795923	777793	681222	1423088	1038050	1327017

Улс орны хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн гаралт буурахгүй шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, хүний халдашгүй байдлыг бүрэн дүүрэн хамгаалж чадахгүй байгаа нь нэг талаас шинэчлэн батлагдсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой гэж дүгнэж үзэх боловч нөгөө талаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт, онцлогтой уялдахгүй, зарим тодорхой гэмт хэргийг байх ёстой зүйл юм шиг хүлээн зөвшөөрөх хандлага нэгэнт төлөвшсөн, дийлэнх иргэд гэмт хэрэг, зөрчилд дасан зохицох хэв маягтай болсон зэрэг байгаатай холбоотой гэжээ.⁸

Хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль зэрэг олон хуулиуд шинэчлэн батлагдсанаар гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах төрийн чиг үүргийн бодлого “гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрх, эрх чөлөөнд хуульд заасан үндэслэл журмаар халдах, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн нь тогтоогдсон үед шийтгэл оногдуулах” гэсэн үзэл баримтлалын томоохон шинэчлэл хийгдэж байна.

Энэ үед Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дагуу аюулгүй байдлыг хангаж, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэх нэг үндсэн нөхцөл болох ба зорилго, зорилтын хувьд:

- Хууль тогтоомж захиргааны хэм хэмжээ тогтоосон актын хэрэгжилтийг хангах, тэдгээрийг боловсронгуй болгох чиглэлээр,
- Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний талаар,

³ <https://www.saferspaces.org.za>

⁴ <https://www.parliament.uk>

⁵ <https://www.oprf.ru/about/>

⁶ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолын хавсралт. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.

⁷ Төрийн мэдээлэл 2017 он, №8

⁸ Гэмт хэргийн цагаан ном. УБ., 2017 он

- Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдыг чадавжуулах талаар,
- Орчин үеийн мөрдөн шалгах, хууль сахиулах техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх чиглэлээр,
- Төр, байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа эрчимжүүлэх чиглэлээр тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэл механизм, хэрэгжүүлэх арга хэмжээг нарийн тодорхойлсон Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих /2003-2012/, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх /2017-2019/, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр /2012-2016/, Хүн худалдаалахтай тэмцэх /2017-2021/, Авлигатай тэмцэх /2016-2023/, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх /2017-2021/, Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах /2010-2015/ Үндэсний хөтөлбөрүүд батлагдсан ба зарим хэрэгжилтийн хугацаа дууссан, зарим нь одоо хэрэгжиж байна.

Улс орон зах зээлийн өрсөлдөөнд эдийн засгийн тогтолцоонд шилжиж ардчилсан нийгмийг цогцлоон бүтээж эхэлснээс хойш гэмт хэрэгтэй тэмцэх ч гэхгүй нийгмийн тодорхой асуудлыг шийдвэрлэх, шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр томоохон агуулга бүхий хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байсан хэдий ч ихэвчлэн хэрэгжүүлэх арга зам нь тодорхой бус, төсөв санхүүжилт дутмаг байдлаас төдийлөн үр дүнд хүрч зорьсон зорилгодоо хүрэхгүй байх тохиолдол байлаа.

Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа нь үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөгөөр зохицуулагдахгүй ба хамгийн гол түлхэц өгөх эрх зүйн баримт бичиг нь Эрүүгийн хууль болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж юм.

Суут сэтгэгчид Аристотель, хожуу XVIII зууны үеийн соён гэгээрүүлэгчдийн гол төлөөлөгч Ш.Монтескье “Мэргэн хууль тогтоогч гэмт хэрэг гарсан хойно нь ял шийтгэхийн төлөө санаа тавихаасаа түүнийг урьдчилан сэргийлэхэд голлон анхаарах ёстой” гэж сургаж байсан нь одоо ч ач холбогдолтой хэвээр байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг урьдчилан сэргийлэх ажилгүйгээр авч үзэж болохгүй гарсан гэмт хэргийн араас хөөцөлдсөнөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах илүү үр дүнтэй гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрөөд багагүй хугацаа өнгөрлөө.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын⁹ “Эрх зүйн шинэтгэл 2007-2021” гэсэн 7.1 дэх хэсгийн 1 дэх стратегийн зорилгод “Дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцооны үнэт зүйл, эрх зүйн соёл, шинэ дэвшилтэт, түгээмэл ач холбогдол бүхий зохицуулалтын аргыг судалж нэвтрүүлэх”-ээр заасан байна.

Монгол Улсын эдийн засагт бий болсон хямралт байдал, төрийн байгууллагын үйл ажиллагааны тогтворгүй байдлыг гэтлэн давах шүүх засаглалын байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, боловсронгуй болгох талаар төр засгаас авч явуулж буй иж бүрэн арга хэмжээнүүд нь тойруу замаар хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой.

Өнөө үед иргэдийн өөрсдийнх нь сонор сэрэмж, аюулгүй байдлаа хангах хүсэл, зорилгоос гадна хөдөлмөр аюулгүй байдалтай адил болсон ба иргэдийн өөрсдийн боловсрол мэдлэг, санхүүгийн байдлаар энэхүү үйлдэл гарч байна гэж дүгнэгдэхээр байна.

Бидний өмнө техник, технологийн ололт дэвшлийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд өргөн ашиглах боломж нээлттэй байна. Жишээлбэл, АНУ-д гэмт хэргийн цахим хяналтын систем буюу COMPSTAT-ыг нэвтрүүлсэнээр гэмт хэргийн гаралтыг 60 хүртэл хувиар буурсан, Сингапурт цахилгаан бараандаа GPS буюу байршил тогтоогч суурилуулснаар хулгайлах гэмт хэргийн гаралт буурсан гээд гадаад орнуудын тэргүүн туршлагауд олон байна.

Манай Улсад цагдаагийн байгууллага нийслэлийн хэмжээнд АНУ-ын туршлагаар COMPSTAT системийн нэвтрүүлж эхэлсэн.

Үүний зэрэгцээ өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг тэр дундаа дээрэмдэх, хулгайлах гэмт хэргийн халдлагын зүйлийн дотор 50 орчим хувийг эзэлдэг иргэдийн гар утас, ухаалаг

⁹УИХ-ын тогтоол №12, 2008 он

төхөөрөмжийг алдагдсан үед тухайн гар утас, ухаалаг төхөөрөмжийг олох боломжийг нэмэгдүүлэхээр бүртгэлийн системийг боловсруулаад үйл ажиллагааг эхлүүлэхэд бэлэн болсон ба цаашид энэхүү системийг “Барьцаалдан зээлдүүлэх үйлчилгээний стандарт”-д заагдсан бүртгэлийн системээр хулгайн барааны зах зээлийг хумих ажлыг эхлүүлээд байна.

Дүгнэлт

1. Хулгайлах гэмт хэрэг нь манай улсын хувьд төрөөс тодорхой бодлого боловсруулж тэмцэл хийхийг шаардаж байгаа нийгмийн сөрөг үзэгдэл тул шалтгаан нөхцөлийг нь шинжлэх ухааны аргаар судалж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны онол, практикийн үндэслэлийг иж бүрэн боловсруулах,

2. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт заасан арга хэмжээг тодорхой үе шаттай, хөрөнгийн шаардагдах эх үүсвэртэйгээр хэрэгжүүлэх, хулгайлах гэмт хэргийн нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин 35 хувиас дээш байгааг хэдий ч энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэхгүй байна.

3. Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх дагнасан үүрэг бүхий цагдаагийн байгууллагын бүтцэд багтдаг мэргэшсэн алба ААН-ийг зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх, ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсрол, албаны тусгай бэлтгэлийн түвшинг дээшлүүлэх, ажил үүргээ гүйцэтгэх боломжоор хангах,

4. Гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг шинжлэх ухааны үндэстэй судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний арга зүйг онолын өндөр түвшинд боловсруулах үүрэг бүхий эрдэм шинжилгээний байгууллага бий болгох, хулгайн гэмт хэргийг судалж, эрдэм шинжилгээний ажил хийж байгаа ажилтнуудад дэмжлэг үзүүлэх,

Санал

Нэг.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд нийцүүлэн гэмт хэрэгтэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах шаардлага байна.

Энэ дашрамд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/65 дугаар тушаалаар “Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад төрөөс баримтлах бодлогын баримт бичиг” боловсруулах ажлын хэсгийг байгуулаад байна.

Энэхүү бодлогын баримт бичиг гэмт хэрэгтэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлогыг тусгайлан тусгаж өгөхийн зэрэгцээ олон батлагдсан үндэсний хөтөлбөрийг уг бодлогын баримт бичигт дэд хэсэг болгон боловсруулбал энэ үйл ажиллагаа нэгдсэн удирдлага зохион байгуулалтанд орно гэж харж байна.

Хоёр.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн шинэчилсэн найруулгад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд инновацийг нэвтрүүлсэн, техник, технологийн дэвшлийг ашигласан шинэлэг санал санаачлагыг хөхүүлэн дэмжих, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн, тэдний оролцоог нэмэгдүүлэх урамшлын системийг тусгуулах саналтай байна.

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ӨМЧИЙН ЭСРЭГ АШИГЛАН ШАМШИГДУУЛАХ ГЭМТ ХЭРЭГ: УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ, ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛ¹⁰

С.Нарангэрэл
Монгол Улсын Шинжлэх ухааны
гавьяат зүтгэлтэн, Академич

Суурийн Жанцан доктор маань цаашдаа Монголын эрүүгийн эрх зүйн тусгай ангийн онолыг бичих гэж байсан юм. Би энэ илтгэлийг тавих гол зорилго нь *нэгдүгээрт*, эрхэм андынхаа гэгээн дурсгалыг хүндэтгэж; *хоёрдугаарт*, өмчийн эсрэг ашиглан шамшигдуулах гэмт хэргийн тухай хэрвээ анд маань юу гэж бичих байсан бол, шинжлэх ухааны ямар гаргалгаа гаргах байсан бол гэдэг утгаар илтгэлээ бэлтгэсэн. Миний илтгэлийн сэдэвт уламжлал, шинэчлэл, шийдвэрлэх асуудал гэж байгаа. Энд 2002 оны Эрүүгийн хуулиас эхлээд Монгол Улсын Эрүүгийн хууль дахь өмчийн эсрэг ашиглан шамшигдуулах гэмт хэргийг үндсэнд нь шинжлэх ухааны хувьд үндэслэлгүй болгож, Монголын хуульчид энэ талын гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн найдвартай, баттай, шинжлэх ухааны үндэслэлтэй гаргалгаагүй болгосон түүх эхэлсэн.

Манай уламжлал ёсоор өмчийн эсрэг гэмт хэргийг хоёр гол үндсэн хэсэгт ангилдаг. Нэгдүгээрх нь өмчийн эсрэг ашиглан шамшигдуулах хэрэг, хоёрдугаарх нь өмчийн эсрэг ашиглан шамшигдуулахтай холбоогүй хэрэг. Тэгэхээр энд шинжлэх ухааны гаргалгаа нь миний ярих хэргийн хувьд хууль зүйн шинжлэх ухаанд ашиглан шамшигдуулах гэж ямар ойлголт байсан бэ? гэдгийг эхлээд гаргаж тавих ёстой. Энэ ойлголтыг 2002 оны Эрүүгийн хуулиас хасчихсан.

Ашиглан шамшигдуулах гэдгийг хууль зүйн шинжлэх ухааны хувьд заавал байх 4 үндсэн шинжийн нийлбэрээр өмчийн эсрэг хэрэг болно гэж үздэг. Одоо Ром-Германы эрх зүйн бүл бүхий улс орнуудын Эрүүгийн хуульд шинжлэх ухааны ийм үндэслэгээг заасан байгаа.

Нэгдүгээрт, сэдэлт нь шунахай, шунахай сэдэлт гэж юу вэ? гэвэл материалын ашиг өөртөө болон бусдад бий болгох; *хоёрдугаарт*, энэ хэрэг бол тухайн эд хөрөнгийг бүрэн мөсөн өөртөө шилжүүлж авсан, эргэж буцааж нөхөн төлөх юмуу, зээлээр авах зорилго байхгүй; *гуравдугаарт*, тухайн улсын өмч ч гэж үзэж болно эсхүл бусдын өмч, хувийн өмчийн бүрэн бүтэн байдалд бодитой хохирол учруулсан; *дөрөвдүгээрт*, ... эдгээр шинжийн нийлбэрээр ашиглан шамшигдуулах гэдэг ойлголт бүрддэг. Энэ хэрэгт ямар хэргүүдийг оруулж ирсэн бэ? гэхээр уламжлалт өмнөх Эрүүгийн хуулиудад *нэгдүгээрт*, хулгайлах; *хоёрдугаарт*, булаах; *гуравдугаарт*, дээрэмдэх; *дөрөвдүгээрт*, залилан мэхлэх; *тавдугаарт*, бусдын эд хөрөнгийг завших буюу үрэгдүүлэх эсхүл албан тушаалын байдлыг урвуулан ашиглаж шамшигдуулах; *зургаадугаарт*, далайлган сүрдүүлэх гэсэн зургаан төрлийн гэмт хэргийг Монгол Улс 2002 оноос өмнө ашиглан шамшигдуулах өмчийн эсрэг хэрэгт хамааруулж ирсэн.

Түүрүүн хурандаа Ө.Энхтөр “Өнөөдөр Монгол Улсад үйлдэгдэж буй гэмт хэргийн 50 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа” гэдгийг бидэнд тодорхой хэлж өгсөн. Энэ уламжлал руу халдсанаас болж бидэнд ямар үр дагавар гарсан бэ? гэвэл, нэгдүгээрт, булаах хэрэг гэж Монголын Эрүүгийн эрх зүйд олон зуун жилийн турш ямар хэргийг үздэг байсан бэ? гэхээр, Монголчууд энэ ёстой нэг луйварчин эр шүү, бүр улаан цайм луйварчин даа гэж ярьдаг, хүний эд хөрөнгийг ил авчихдаг, лангуун дээр байгаа зүйлийг авчихдаг, хүний өмсөж зүүж байгаа хувцас хэрэгслийг шүүрээд аваад явчина, энэ бол булаах хэрэг. Энэ хэргийг 2015 оны Эрүүгийн хуулиар байхгүй болгочихсон, заавал байх ёстой. Энэ хэргийг юу болгож хувиргасан

¹⁰ Монгол Улсын Гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, цагдаагийн хурандаа Суурийн Жанцан агсаны нэрэмжит “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг: тулгамдсан асуудал, урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн үндсэн илтгэл

бэ? гэвэл 2015 оны Эрүүгийн хуулиар дээрэмдэх гэмт хэрэг болгоод хувиргачихлаа. Дээрэмдэх гэмт хэрэг болоод ирэхээр, ялангуяа шударга ёсны үүднээс үзэхэд, булаах гэмт хэрэг ял, хариуцлагын хувьд хулгайлах гэмт хэрэгтэй харьцуулахад арай хүнд, дээрэмдэх гэмт хэрэгтэй харьцуулахад хөнгөвтөр ял оногдуулах ёстой. Гэтэл дээрэмдэх гэмт хэрэг рүү оруулсан учраас маш хүнд ял энэ гэмт хэргийг үйлдсэн хүнд заналхийлж эхэлсэн. Өвөл гэхэд хүний үнэ цэнэтэй малгайг шүүрээд булаагаад явчихдаг, энэ бол Монголын уламжлалт гэмт хэрэг, энэ нь одоо дээрэмдэх гэмт хэрэг болж хувирсан.

Дээр нь “Албан тушаалтан албан тушаалынхаа байдлыг урвуулан ашиглаж ашиглан шамшигдуулах” гэдэг гэмт хэрэг, албан тушаалын гэмт хэргийн бүлэгт байгаа албан тушаалтан албан тушаалын байдлаа урвуулах гэсэн хоёр төрлийн гэмт хэрэг байгаа, энэ хоёр төрлийн гэмт хэрэг шинжлэх ухааны хувьд юугаараа ялгагддаг байсан бэ? гэхээр, эхний гэмт хэрэг нь ашиглан шамшигдуулах шинжийг өөртөө агуулна, албан тушаалын гэмт хэрэг нь болохоор албан тушаалтан өөрийнхөө үйлдэлд санаатай хандаад байдаг, учруулах хор уршигтаа болгоомжгүй ханддаг, сүүлд нь үзсэн чинь хичнээн сая төгрөгийн хохирол учруулчихсан байдаг, үүгээрээ ялгагддаг. Гэтэл өнөөдөр 2002 оноос хойш Монголын хууль зүйн практикт энэ албан тушаалынхаа байдлыг урвуулан ашиглан шамшигдуулах гэмт хэрэг, албан тушаалын гэмт хэрэг буюу албан тушаалынхаа байдлыг урвуулах гэсэн хоёр төрлийн гэмт хэргээ ялгаж салгахад байсан, тийм учраас хэрэг буцдаг, шударга ял шийтгэл оногдуулж чадахгүй, гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг зөв тогтоож чадахгүй байдал үүнтэй холбоотой. Одоо Та бүхэн ажиглаад үзвэл, Эрүүгийн хуульд заасан тодорхой гэмт хэргийн бүтээцүүд маш зөв, оногдуулах хариуцлага нь зөв байж гэмээн тэндээс гарсан статистикийн мэдээ баримтууд ямар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх вэ? гэдэг чиг баримжааг бидэнд өгнө. Өөрөөр хэлбэл, 2015 оны Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш булаах, дээрэмдэх гэмт хэргүүд хоорондоо нэг зүйлчлэлтэй болсноос шалтгаалж Монголд дээрэмдэх гэмт хэргийн статистик маш их өснө. Мөн чанартаа дээрэмдэх гэмт хэрэг биш, булаах гэмт хэрэг байдаг, малгай шүүрэх, луйвардах үйлдэл л ихсээд байдаг! Ийм аюул цаана нь учирна гэдгийг анхаарах хэрэгтэй.

Ашиглан шамшигдуулах ойлголтыг Эрүүгийн хуулиас хассанаас шалтгаалж гэмт хэргийн системчлэлд их буруу, шинжлэх ухааны үндэслэлгүй өөрчлөлтүүд гарч ирсэн, жишээлбэл, “бусдын тээврийн хэрэгслийг авч зугтаах” гэсэн гэмт хэрэг байгаа, энэ хэрэг ямар гэмт хэрэг вэ? гэвэл, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, өөрөөр хэлбэл, зөвшөөрөлгүйгээр хөдөлгөөнд оролцоод, машиныг нь баахан унаж яваад, нэг газар орхичихоод явчихдаг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг биш байтал, 2015 оны Эрүүгийн хуулиар өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн ангиллын бүлэгт ороод ирсэн. Угтаа өмч нь бүрэн бүтнээрээ л байдаг, ийм ийм байдал руу оруулж байгаа учраас 2015 оны Эрүүгийн хуулийг дахин шинжлэх ухааны үндэслэлтэй, эргэж маш сайн авч үзэж, үндэснийхээ олон жилийн тогтсон уламжлалыг эргүүлж тусгахгүй бол дэндүү барууны, гадны улс орны хуулийг ойлгохгүйгээр, нэр томъёоны агуулга, бодит амьдралаа мэдрэхгүйгээр, ингэж хууль бичиж болохгүй. Барууны улс орны өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг гэдэг чинь газар тэнгэр шиг ялгаатай. Бидний амьдралын түвшин ямар билээ, наад зах нь барууны улс оронд мал хулгайлах гэмт хэрэг гэж байхгүй шүү дээ, тэгвэл Монголд мал хулгайлах гэмт хэрэг бол бидний үндэсний уламжлалтай, аж төрөх ёстой салшгүй холбоотой, түгээмэл гэмт хэрэг мөн.

Дээр нь 2015 оны Эрүүгийн хуулиар залилан мэхлэх гэж өмчлөх эрхийн эсрэг ашиглан шамшигдуулах гэмт хэргийн бүлэгт жинтэй хувь эзэлж байгаа гэмт хэрэг, өнөөдөр залилан мэхлэх гэмт хэргийг ердийн гэрээ, хэлцлийг биелүүлээгүй, түүний эрсдэлээс яаж ялгах вэ? гэдэг асуудал бол Монголын хувьд маш төвөгтэй асуудал болсон. Өнөөдөр залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байгаа ялтнуудын дийлэнх хувь нь зээлийн ч юмуу ердийн хэлцэл нь эрсдэлд ороод, зээлээ хугацаанд нь нөхөн төлж чадаагүй, нэхэмжлэгч тал нилээн хүчтэй, ялангуяа цагдаа, прокурор, шүүхэд нөлөөтэй байгаа нөхцөлд нөгөө талыг залилан мэхлэх гэмт хэрэгт буруутгаад, олон жил хорих ял шийтгүүлж, сүүд нь өөрөө ингэдэггүй байж, эрх чөлөөтэй байлгаж байгаад хэдэн төгрөгөө хугацаа, хуваарьтайгаар гаргуулж авсан бол бидэнд ашигтай байж гэж харуусаад, толгойгоо бариад сууж байгаа хохирогч олон байна. Хэрвээ, зээлээр авсан зүйлээ хүлээлцээд дуусвал аль аль талдаа ийм үр дагавар үүсэхгүй.

Гэтэл залилан мэхлэх гэмт хэргийн үндсэн шинж нь юу байдаг вэ? гэвэл, хоёр үндсэн аргаар илэрдэг уламжлалтай, *нэгдүгээрт*, хүнийг хуурч мэхэлнэ; *хоёрдугаарт*, итгэлийг

урвуулж ашиглана. Гэтэл 2015 оны Эрүүгийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр юу болгож хувиргасан бэ? гэхээр эд зүйл л гэнэ, баримт бичиг л гэнэ, цахим орчин ашиглаж л гэнэ, хүний шинэ хэрэглээ чинь янз бүрээр гарна шүү дээ, тэр болгоныг залилан мэхлэх гэмт хэргийн шинж гээд бичээд байж болохгүй. Өнөөдөр шинжлэх ухаан, техникийн дэвшил бидэнд цаг минут тутамд олон шинэ зүйлийг өгч байна, гар утасны хөгжил ямар байгаа билээ, гар утасны залилан.

Ийм учраас Монголын Эрүүгийн хуульд дахин шинэчлэл хийхгүй бол самарсан, Зөрчлийн тухай хууль ч Монголын нийгмийг самарсан, би ний нуугүй хэлэхэд хоолойгоо сөөтөл, хэвлэл мэдээллийн зарим хэрэгслээр шавь нараа эвгүй байдалд ортол хуулийн төслүүдийг шүүмжилсэн, нохой хуцаж байгаа юм шиг тоогоогүй! Зарим нь их эрх мэдэл, өндөр албан тушаалаараа “Нарангэрэл чи хоцрогдсон, та нар шиг Орост сургууль төгссөн хүмүүс эрх зүйн шинэчлэл хийж чадахгүй” гэж мэдэгдэл хийж байсан. Тэрний эцсийн үр дүн юу болсон бэ? гэвэл өнөөдөр Монголын нийгэм самрагдсан, бид байдгаараа л байна, багш хүнд цүнхээ үүрчихээд л Та нарынхаа нүд рүү ичиж зовохгүйгээр харах эрх байгаа, гэтэл өнөөдөр Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дүнд юу болов?! Монголд гэр бүлийн цуцлалт эдгээр хууль хэрэгжиж эхэлснээс хойш жигтэйхэн болсон, яагаад гэвэл, Монголын бичигдээгүй хуулиар “эр эмийн хооронд илжиг бүү жороол” гэдэг, хуулиараа баривчлах, хорогдох байр бий болгож аваад, эхнэр нь ч юмуу, хажуу айлын хүн нь мэдээлэл өгвөл, цагдаа хуулиа үзүүлээд 30 хоног баривчилж байна, 30 хоног баривчлуулсан эр нөхөр юу бодох вэ? гэхээр, миний амьдралын хань мөн үү, намайг баривчлуулдаг гэж бодон, суллагдаж гарч ирсэн хойноо гэрлэлтээ цуцлуулах нөхцөл байдал үүсгэж байна. Эндээс ойрхон газарт байгаа Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн шүүхээр ороод статистикийг нь аваад үзвэл, дандаа энэ нөхцөл байдлаас үүдэлтэй гэр бүл цуцлалтын хэрэг байгаа.

Ялимгүй жижиг захиргааны зөрчилд захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий субъектүүд хууль хэрэглэж чадахгүй болсон. Яагаад гэвэл, дандаа прокурорт шалгуулна, бүх зүйлээ үзүүлнэ, тэрний оронд торгохгүй өнгөрөөгөөд байя, арга хэмжээ авахгүй байсан нь зөв юм байна гэсэн бодол бий болсон.

Өнөөдөр Монголчуудын үр хүүхдээ, хойч үеэ хүмүүжүүлдэг арга бол олон мянган жил эцгийн таван салаа боов, ээжийн хүчтэйхэн нудралт, чимхэлт биднийг хүн болгосон шүү дээ. Гэтэл өнөөдөр бид Эрүүгийн хуульд насанд хүрсэн хүн насанд хүрээгүй хүнийг аливаа хэлбэрээр шийтгэвэл гэмт хэрэг гээд оруулцан, үүнээс болж Монголын уламжлалт гэр бүлийн боловсрол, хүмүүжил унаж байна.

Ийм учраас илтгэлийнхээ төгсгөлд миний хамгийн хэлэх гол санаа бол бид хууль тогтоомжоо үндэсний онцлог, эрх ашигтай нийцүүлэх, гадаадын улсын хаа хамаагүй амьдралын хэвшлийг хуулбарлаж, гадны хэдэн төгрөгөнд хууртахгүйгээр амар амгалан, аз жаргалтай, сэтгэл тэнүүн, аж төрмөөр байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ДЭЭРЭМДЭХ ГЭМТ ХЭРГИЙН ҮНДСЭН ШИНЖ, ЗҮЙЛЧЛЭЛИЙН АСУУДАЛ

Ж.Эрдэнэбулган
МУИС-ийн ХЗС-ийн захирал, доктор (Ph.D), профессор

Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн салбарт томоохон өөрчлөлт хийх асуудал нэлээд олон жилийн өмнөөс яригдан ардчилсан нийгмийн харилцааны өөрчлөлт, эрүүгийн эрх зүйн суурь зарчим, эрүүгийн хуулиар хамгаалагдах үнэт зүйлс, ерөнхий болон тусгай ангийн онолын зарим асуудлуудыг орчин үеийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага, Монгол улс нэгдэн орсон, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиа 2015 оны 12 сарын 3-ны өдөр батлан 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Аль ч улс орны Эрүүгийн хууль иргэдийн язгуур эрх ашиг, гол үнэт зүйлийг гэмт халдлагаас хамгаалахад чиглэсэн, гэмт хэрэг болон эрүүгийн хариуцлагын тодорхой болон тэнцвэрт байдал нь эрх зүйн зарчимдаа бүрэн нийцсэн, хийдэлгүй маш тодорхой зохицуулалт бүхий суурь хууль байдаг.

Шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн Хууль ёсны болон шударга ёсны зарчмуудад олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн “Nullum crimen sine lege”, “Ne bis in idem” гэсэн зарчмын агуулгыг хуульчилж өгсөн бөгөөд эдгээр зарчмын агуулга эрүүгийн хуулийн бусад хэм хэмжээнд тусгалаа олж байж сая бодитой хэрэгжих боломжтой болдог.

“Nullum crimen, nulla poena sine lege” буюу “хуульд заагаагүй бол гэмт хэрэг үгүй, гэмт хэрэг үгүй бол ял үгүй” гэсэн сонгодог зарчмын агуулга нь эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй, эрүүгийн хууль тодорхой байх, гэмт хэрэг, эрүүгийн ял, хариуцлагыг зөвхөн эрүүгийн хуулиар тодорхойлох гэсэн ойлголтуудыг илэрхийлж байдаг.

Өнөөдрийн энэхүү илтгэлээр одоо үйлчилж буй эрүүгийн хуульд хуульчлагдсан дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүн, түүний онцлог, уг гэмт хэргийг адил төсөөтэй бусад гэмт хэргээс ялган зүйлчлэх асуудал болон одоогийн хуульд байгаа зөрчилдөөнт зохицуулалт түүнийг боловсронгуй болгох арга замын талаар зарим асуудлыг хөндөх болно.

Дээрэмдэх гэмт хэрэг нь өмчлөх эрхийн эсрэг бусад гэмт хэргээс бүрэлдэхүүний шинжээрээ онцлог, хүний өмчлөх эрх төдийгүй амь нас, эрүүл мэндэд давхар халддаг нийгмийн хор аюулаар их, хүнд гэмт хэрэг тул энэхүү гэмт хэргийг эрүүгийн хуульд оновчтой тодорхойлох, зүйлчлэлийн асуудалд анхааралтай хандах хэрэгтэй. Аливаа үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцоход түүний бүх шинжийг хуульд тодорхой заасан байх ёстой бөгөөд энэ нь эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх хууль ёсны зарчмын гол илэрхийлэл болно.

Шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн зарим зүйлүүдийг судлан үзэхэд эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх боломжтой болсныг уг хуулийн “**Дээрэмдэх**” гэмт хэргийн бүрэлдэхүүнээс харж болно. Өмнө үйлчилж байсан эрүүгийн хуулиудад тус тусдаа зүйлээр зохицуулагдаж байсан булаалт болон дээрэмдэх гэмт хэргүүдийг 2017 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн тусгай ангид нэг зүйл болгон 17.2 нэг дэх хэсэгт “*бусдын эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан*” мөн зүйлийн 2 дах хэсэгт “*бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж авахаар довтолсон*” бол гэж хуульчилжээ.

Дээрэмдэх гэмт хэргийн объектив талын гол үндсэн шинж нь хүний амь нас, эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн довтолгоон бүхий үйлдлээр илэрдэг. Энэ гэмт хэргийг үйлдэх үед хийгддэг “*заналхийлэл*” нь гэмт этгээд хохирогчид шууд хүч хэрэглэх биеийн хүчний нөлөө үзүүлээгүй боловч түүний эрх чөлөө, эрүүл мэндэд нь халдаж, нэн даруй хор аюул учруулна гэсэн үг хэлээр айлган сүрдүүлж энэ нь биелэх боломжтой гэдгийг хохирогчид ойлгуулсан үйл ажиллагаа байдаг бол “*довтолгоон*” нь гэмт этгээд бусдын эд хөрөнгийг авах зорилгоор хүч хэрэглэж буюу хүч хэрэглэсэн хохирогчийн эсэргүүцэл үзүүлэх боломжийг алдагдуулсан хүчтэй, шууд санаатай идэвхтэй үйлдлээр илэрдэг.

Иймд дээрмийн гэмт хэрэг хүч хэрэглэхгүйгээр үйлдэгдэх үү? гэдэг асуулт гарч ирнэ. Шинэ хуулиар ингэж дээрэмдэх гэмт хэргийн “*хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж*

довтлох” гэсэн үндсэн шинжийг өөрчилж хүч хэрэглээгүй болон хүч хэрэглэсэн гэж үзэх болсон нь хэр оновчтой зохицуулалт болсныг цаг хугацааны шалгуур тодорхойлно.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2.1-д заасан бусдын эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан гэдэг нь үндсэндээ булаалтын гэмт хэргийг тодорхойлох шинж бөгөөд гэмт хэргийн үндсэн шинж, бүтцийн хувьд харилцан адилгүй, тэр дундаа гэмт үйлдлийн арга, нийгмийн аюулын шинж чанар, хор уршиг нь өөр хоорондоо эрс ялгаатай “булаах” болон “дээрэмдэх” гэмт хэргүүдийг нэг зүйл болгосон нь онол болон практикт ухралт болсон гэж үзэх үндэстэй. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан гэмт хэрэг нь материаллаг, 2 дах хэсэг нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй ба нэг гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн материаллаг болон хэлбэрийн бүрэлдэхүүнтэйгээр зэрэгцэн байх нь хууль зүйн техникийн хувьд байж болох эсэх нь маргаантай юм. Өмнө нь хүч хэрэглэсэн булаалт болон дээрмийн гэмт хэргийг ялган зүйлчлэх асуудал багагүй маргаан дагуулдаг байсан бөгөөд 2002 оны эрүүгийн хуулийн 146 дугаар зүйлийн 146.2 дах хэсэгт байсан “бусдын амь насанд аюулгүй хүч хэрэглэж” үйлдсэн гэсэн хүндрүүлэх нөхцлийг 2008 оны хуульд оруулсан өөрчлөлтөөр хасаж булаалтын гэмт хэргийн үндсэн шинжийг бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр авсан өөрөөр хэлбэл хохирогчийн эд зүйлс, өмч хөрөнгийг ил аргаар бусад хүмүүсийн болон хохирогчийн нүдэн дээр бие махбодийн болон сэтгэл санааны ямар нэг хүчирхийлэл, заналхийлэл үзүүлэлгүйгээр илээр авч тэр даруйдаа хохирогчоос зугтан зайлсхийсэн шинжтэй үйлдэл гэж тодорхойлсон.

Бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн нийтлэг хэлбэр бөгөөд дээрэмдэх гэмт хэрэг хамгийн ойролцоо, ижил төстэй гэмт хэрэгт тооцогддог.

Ингэж дээрэмдэх болон булаалтын гэмт хэргийг “дээрэмдэх” гэсэн нэг зүйлд нэгтгэсэнээр энэ гэмт хэргийн зүйлчлэлийг хэт хялбар аргаар шийдвэрлэх гарц болгох жишиг тогтох, эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглосон суурь зарчим алдагдахад хүргэж болзошгүй юм.

Иймд эрүүгийн хуулийн нэг зүйлд нэгтгэгдсэн дээрх хоёр гэмт хэргийг үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүнээр нь тусгай зүйл болгон хуульчлах шаардлагатай.

Сүүлийн үед тус улсад үйлдэгдэж буй өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн дотор дээрэмдэх гэмт хэргийн эзлэх жин буурахгүй байгаа бөгөөд шинэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн судалгаанаас үзэхэд дээрэмдэх гэмт хэрэг 20,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.¹¹ Энэ гэмт хэргийн өссөн тоон үзүүлэлтэд хуулийн дээрх хийдэл нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй.

Монгол хэл арвин баялаг үгсийн сантай иймд хууль зүйн нэр томъёог зөв оноох нь хууль хэрэглээний гол үндэс болно. Дээрэм болон булаалт нь нэр томъёоны хувьд ямар агуулгыг илэрхийлэх вэ гэдгийг үг зүйн болон гарвал зүйн (морфологи) талаас авч үзэх нь гноесологийн мөн чанарыг нээн илрүүлэхэд чухал ач холбогдолтой.

“Дээрэм” “болон “булаах” гэдэг үгийг хэл зүйн толь бичгүүдээс үзэхэд дараах агуулгыг илэрхийлсэн байдаг. Монгол хэлний товч тайлбар толь бичигт дээрмийг “илэрхийгээр хүчдэн уулгалан булааж авах, дээрэм хийх” булаалтыг “бусдын юмыг эзэрхэн авах; гараас нь булаан авах”¹² гэж тайлбарласан байна.

Латинаар “*robaria*” - тонон түрэмгийлэх, уулгалан дайрах, хүчээр булааж авах гэсэн утгатай бол оросын “*разбой*” –бусдын амь нас, эд хөрөнгөнд хүч хэрэглэж халдах, хүний амь нас, эрүүл мэндэд аюул заналхийлэл учруулах замаар довтлон халдах гэсэн утгаар илэрхийлэгддэг ажээ. Английн “*robbery*”-бусдад хүч хэрэглэн айлган сүрдүүлэх замаар халдан довтолж булааж авах гэсэн утгаар тус тус хэрэглэгддэг.

Германы “*rauberei*”- эрх чөлөөнд нь түрэмгийлэн хүч, зэвсэг хэрэглэж халдаж бусдын өмчлөлийн зүйлийг өөртөө эзэрхийлэн булааж авах гэсэн байна. Эдгээр үгийн язгуур утга, түүний илэрхийлэгдэх арга, хандлага нь өөр өөр боловч хэл зүйн толь бичгүүдэд¹³ тусгагдсан нийтлэг агуулгаараа адил төстэй утгыг илэрхийлснийг харж болно. Академич С.Нарангэрэл “Дээрэм (анг. Robbery, raiding, орос разбой) – эрүүгийн эрх зүй дэх өмчийн эсрэг хамгийн аюултай гэмт хэргийн нэг. “ Бусдын эд хөрөнгийг авах зорилгоор амь биед нь аюултайгаар хүч

¹¹ Монгол улсын шүүхийн тайлан. 2017 он, 211 дахь тал

¹² Цэвэл.Я. Монгол хэлний товч тайлбар толь бичиг. 1966 он

¹³ <http://dic.academic.ru/dic.net/lawer/17802>.

хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон үйлдэл". дээрмийг булаах гэмт хэргээс ялгах шаардлагатай. Булаалт гэдэг нь "бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр хууль бусаар улаан цайм авсан гэмт хэрэг. Булаалт нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт хамаарна"¹⁴ гэж тайлбарласан байна.

Зарим улсын эрүүгийн хуульд "булаалт" гэсэн тусгай зүйл байхгүй харин "хулгайлах" болон "дээрэмдэх" гэмт хэргүүдийг хуульчилсан байдаг.

Иймд гадаадын эрүүгийн хуулийн заалтыг шууд хуулбарлах, өмнөх уламжлалаа хэт үгүйсгэх, гэмт хэргийн объектив талыг хэт үнэлж бүрэлдэхүүний бусад шинжтэй харьцуулж үзэлгүй зөвхөн гэмт хэргийн үр дагавараар хэргийг зүйлчлэх гэсэн хандлагатай холбоотой дээр дурьдсан хүндрэл гарч болзошгүй байгаа тул үүнийг цаашид анхаарч шинжлэх ухааны зөв зохицуулалт хийх нь зүйтэй.

Дээрэмдэх гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал

"Гэмт хэргийн зүйлчлэл"¹⁵ (квалификация преступления, the qualification of crime) гэдэг ойлголт нь эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглодог буюу хязгаарладаг эх газрын системийн орнуудын хувьд тэр тусмаа постсоциалист орнуудын эрүүгийн эрх зүйд түгээмэл хэрэглэгддэг.

Аливаа этгээдийн үйлдсэн нийгэмд аюултай үйлдэл тухайн улсын эрүүгийн эрх зүйн эх сурвалжуудад хуульчлан тодорхойлсон гэмт хэргийн бүтэц, шинж, бүрэлдэхүүнтэй хэрхэн нийцэж, тохирч байгааг тогтооход чиглэгдсэн эрүүгийн эрх зүйн үнэлэлт өгөх (томьёолон тодорхойлох) явдлыг гэмт хэргийг зүйлчлэх гэж ойлгож болох бөгөөд энэ нь аксиологи-логикийн болоод арга зүй шийдлийн харилцан хамаарал бүхий үйл ажиллагаа болдог¹⁶.

Дээрмийн гэмт хэргийг адил төстэй бусад гэмт хэргээс ялган зааглаж авч үзэх нь тухайн гэмт хэргийн объектив, субъектив шинж ба хүндрүүлэх бүрэлдэхүүний элемент бүрийг задлан шинжилж энэ гэмт хэргийн зүйлчлэлийн үндэслэлийг боловсронгуй болгох шүүхийн практикт тохиолддог эрх зүйн хийдэл, зөрчлийг даван туулахад онцгой ач холбогдолтой юм.

Шинэчлэн найруулсан эрүүгийн хуульд дээрэмдэх гэмт хэргийн хүндрүүлэх нөхцлийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон; зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж үйлдсэн; зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол гэж заасан ба уг зүйлд өмнөх эрүүгийн хуульд байсан хэд хэдэн хүндрүүлэх нөхцлийг хассан. Жишээ нь: хохирлын хэмжээ, хүний биед хүнд гэмтэл учирах г.м

Хуулийн өөрчлөлттэй холбоотой дээрэмдэх гэмт хэргийн зүйлчлэлд дараах асуудлууд гарч ирнэ. Энэ зүйлийн "байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон" гэдэг нь шинээр хуульчлагдсан хүндрүүлэх нөхцөл тул өмнөх эрүүгийн хуулийн давтан үйлдэлтэй адилтган үзэж болохгүй. Учир нь ийм хүндрүүлэх нөхцөл өмнөх эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлд байгаагүй тул онолын хувьд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй байх мөн нэг хэрэгт нэг удаа ял шийтгэх буюу аливаа гэмт хэрэгт ял шийтгүүлж, эдэлсний дараа түүний үр дагаврыг хүндрүүлэн хэрэглэж байгааг өөрчилсөн хуулийн үзэл баримтлалын дагуу энэ нөхцөл байх ёстой юу хэрэв хэрэглэвэл хууль үйлчилж эхэлсэнээс хойшхи үйлдэлд хамрагдах ёстой. Мөн дээрмийн гэмт хэрэг үйлдсэний улмаас ямар ч хохирол учирсан бусад хүндрүүлэх нөхцөл байхгүй бол 17.2.2 зүйлчлэгдэх боломжтой тул хуульд хохирлын хэмжээг зааж өгөх нь зүйтэй.

Харин дээрмийн гэмт хэргийг үйлдэх явцад хүний биед хүнд хохирол санаатай учруулсан, хүнийг санаатай алсан тохиолдолд дээрэмдэх гэмт хэргийг давхар зүйлчлэхгүйгээр ЭХТА-ийн 10.1.2.5 болон 11.1.2.1 дэх хэсгээр зүйлчилнэ.

2002 оны Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.2 дахь хэсэгт "шунахай" сэдэлтээр, 91.2.7-д "уулгалан довтолох буюу дээрэмдэх" гэмт хэрэг үйлдэх явцад хүнийг санаатай алах гэж

¹⁴ Нарангэрэл.С. Эрх зүйн толь бичиг. 192 дахь тал. (2011).

¹⁵ Латини –gualis чанар, үнэлэх, ялган үнэлэх, тайлах гэсэн утгатай.

¹⁶ Толкаченко.А.А. Теоретическое основы квалификации преступлений. М. Юнити-Дана. 2004 г. С.11-12.

шинж чанарын хувьд адил нөхцлийг ялгаатай авч үзсэн нь онолын хувьд ойлгомжгүй, алдаатай байсан байна.

Энэ талаар профессор С.Жанцан "...Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.7-д уулгалан довтлох буюу дээрэмдэх гэмт хэргийг үйлдэхдээ хүн алсаныг онц хүндрүүлэх нөхцөл болгон хуульчилсан нь бүтцийн хувьд алдаатай, онцын шаардлагагүй зүйл бөгөөд зохиомлоор өрсөлдөх хэм хэмжээ бий болгож байгаа юм. Учир нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан "шунахай" сэдэлтээр алах гэсэн онц хүндрүүлэх нөхцөл байдал ийм сэдэлтэй байдаг гэж дүгнэсэн байдаг¹⁷. Шинэ эрүүгийн хуулиар өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүлэгт хулгайлах гэмт хэргийг халдлагын зүйлээр нь ялгаж бусдын эд хөрөнгийг хулгайлах, мал хулгайлах гэж 2 өөр зүйлд заасан. Бусдын малыг дээрэмдсэн бол дээрмийн хэргээр зүйлчлэгдэх нь ойлгомжтой боловч цаашид адил аргаар үйлдэгддэг гэмт хэргүүдийг халдлагын зүйлээс хамаарч өөр өөр зүйлээр зүйлчилдэг, өөр сэдэлт зорилгоор үйлдэгддэг гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлд дээрэмдэх үйлдлийг оруулах шаардлагатай эсэх нь асуудал дагуулсан хэвээр байна.

Аливаа зүйлийн нэрийг өөрчилсөн боловч агуулга хэвээр бол шинэчлэл биш харин ухрах, дордох, хийдэл их, амьд үйлчлэл дутуу болох учир Эрүүгийн хуульд шинэчлэл хийхэд эрүүгийн эрх зүйн онол, практикийн ул суурьтай судалгаа, нотолгоо зайлшгүй шаардлагатай.

Ингэснээр урт хугацаанд тогтвортой, амьд үйлчилж чадах Эрүүгийн хуультай болох боломжтой.

Хууль эмгэгтэй байна гэдэг хуулийн буруу биш. Хуулийн эмгэг гэдэг бол эсрэгээрээ төрийн ой санамж, хуулийн бодлого тодорхойлогч, хууль тогтоогчдын мэдлэг, чадвар, үнэт зүйлс, нийтлэг эрх ашгийг хамгаалах бодлогыг илтгэх шинж болно.

¹⁷Жанцан.С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх өрсөлдөх хэм хэмжээг хэрэглэхэд анхаарах зарим асуудал. Өмгөөлөгч. №09 (15). 2007 он, Жанцан.С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. Боть 1 /Гэмт хэргийн тухай сургаал/. УБ., 2009 он. 291 дэхь тал.

ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Ч.Нямсүрэн

*Хууль сахиулахын их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Цагдаа судлалын төвийн эрхлэгч, доктор, дэд профессор*

Хүмүүн биеийг олж эх дэлхийдээ өлгийдүүлэхдээ авч мэндэлдэг жам ёсны нэг эрх бол өмчлөх эрх мөн. “Хомо сапиенс” буюу ухаант хүмүүн олон зуун мянган жил өмч дээр суурилсан нийгэм эрх зүйн харилцаанд аж төрж, амьдарч ирсэн түүхтэй. Ийм ч учраас хүн төрөлхтний түүх бол өмчийн харилцааны түүх мөн.

Эрх зүйн онолын үүднээс хүний өмчлөх эрхийн хамгаалалтыг олон улсын эрх зүйн хамгаалалт; үндэсний эрх зүйн хамгаалалт гэсэн хоёр түвшинд авч үздэг.

1789 оны Францын Их хувьсгал өмчлөх эрхийн олон улсын эрх зүйн хамгаалалтын эх суурийг тавьж “Хүн ба Иргэний Эрхийн Тунхаглал”-ын Арван долоодугаар зүйлд “Өмч бол хэн ч халдашгүй, ариун эрх мөн”¹⁸ хэмээн хүний өмчтэй байх жам ёсны эрхийг анх зарлажээ.

1949 оны Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 7 дугаар зүйлд: “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр эд хөрөнгийг ганцаараа буюу бусадтай хамтарч өмчлөх эрхтэй. Хэний ч өмч хөрөнгийг дураар хураан авч болохгүй” гэж заажээ.

XXI зууны гарааны нэг онцлог болсон глобалчлах явц эрчимжиж буй орчин үеийн олон улсын эрх зүй ба дотоодын эрх зүйн уялдаа холбоо нь олон улсын эрх зүйн примат (primatus-тэргүүлэх, голлох, давамгайлах гэсэн латин үг) буюу голлох шинжээр тодорхойлогдож байна.¹⁹ Энэ байдлыг олон улсын эрх зүйн ноёрхол, үндэсний эрх зүйн дээрхи эрх зүй гэсэн монист утгаар бус харин энэ хоёр тогтолцооны уялдаа холбооны шинжээр нь ойлгох ёстой юм.

Олон улсын хувийн эрх зүй нь олон улсын эрх зүйн этгээдтэй холбоо бүхий иргэний, гэр бүлийн, хөдөлмөрийн, өмчлөх эрх зүйн зэрэг нэг улсын хүрээнээс хальсан харилцааг зохицуулах учраас улс бүрийн онцлогийг илэрхийлсэн үндэсний эрх зүйн тогтолцоонуудын зөрчилдөөнийг шийдвэрлэх, өмчлөгчийн эрхийг олон улсын болон бүс нутаг, гадаад улсад хамгаалах асуудлыг шийднэ.

Өмчлөх эрхийн үндэсний эрх зүйн хамгаалалт нь өөрийн нутаг дэвсгэр дотор дотоодын хууль тогтоомжоор өмчлөгчийн эрхийг хангахад чиглэнэ.

Монгол Улсад өмчлөгчийн эрхийг хамгаалах тогтолцоо Үндсэн хуулийн эрх зүйн хамгаалалт; иргэний эрх зүйн хамгаалалт; захиргааны эрх зүйн хамгаалалт; эрүүгийн эрх зүйн хамгаалалт зэргээс бүрдэж байна.

Монгол Улсын өмчлөх эрхийн эрүүгийн эрх зүйн хамгаалалтын онолын үндэс нь Монгол Улсын үндсэн хууль түүний дотор Үндсэн хуулийн оршил хэсэгт байгааг анхаарах хэрэгтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт: Хүний эрх, эрх чөлөө.. эрхэмлэн дээдэлж, эх орондоо.. иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэж тунхагласан.

Иргэний нийгмийн тухай төсөөллийг Г.Гегель “Эрх зүйн гүн ухаан” бүтээлдээ “Иргэний нийгэм бол тухайн бие хүний хувийн онцгой зорилго, ашиг сонирхол хэрэгжих хүрээ мөн. Хүн бүр өөртөө зорилготой, бусад хүмүүс түүний хувьд энэ зорилгодоо хүрэх арга хэрэгсэл болдог учраас иргэний нийгэм нь “онцгой” ба “нийтлэг” гэсэн хоёр үндсэн зарчмын харилцаагаар тодорхойлогдоно. Тухайн бие хүний “онцгой зорилго” хэрэгжих хэрэгцээ бусдынхаар хязгаарлагдаж байдаг учраас уг зорилгоо биелүүлэхийн тулд хүн бүр “нийтлэг зорилгын” төлөө тэмүүлдэг. Учир нь онцгой зорилгоо биелүүлэхдээ аргагүйн эрхэнд бусдын төлөө зүтгэх шаардлага гарна” гэжээ²⁰.

И.Кант: а) хүн бүр өөрийн хүчээр бүхнийг бүтээх ёстой бөгөөд бүтээсэн зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээх ёстой; б) хүмүүсийн ашиг сонирхол зөрчилдөх, түүнийг хамгаалах

¹⁸ Хрестоматия по истории государства и права зарубежных стран. М., 2000. С 41

²⁰ Г.Гегель. Философия права. М., 1990. С 227-228.

шаардлага нь хүмүүсийг хөгжүүлэх үндсэн шалтгаан мөн; в) эрх зүйгээр хуульчлан хамгаалагдсан иргэдийн эрх, эрх чөлөө бол хүний нэр төрийг дээдлэх, хамгаалах баталгаа, өөрийгөө хөгжүүлэх зайлшгүй нөхцөл мөн²¹ гэжээ. Энэ үзэл санаа нь иргэний нийгмийн тухай онолын нэг гол үндэслэл болсон юм.

Эдийн засгийн хүрэн дэх иргэний нийгмийн шинж нь хүн бүр оршин тогтнох, амьдрах үндэс болсон хувийн өмчтэй байх явдлаар илэрнэ. Иргэний нийгэм нь анх хувийн өмч дээр тулгуурлан үүсч хөгжсөн байна. Хувийн өмч нь хүмүүсийг өөр хооронд нь ялгаж салгаад зогсохгүй, түүнчлэн тэдний шунахай, хувиа хичээсэн, бялдууч зусарч болон бусад олиггүй олон тооны зөн билгийг сэргээсэн боловч, нөгөө талаас тэдний бүтээлч идэвх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх сонирхлыг урд үзэгдээгүй хэмжээгээр өрнүүлдэг. Үүнээс үзэхэд хувийн өмч нь иргэний нийгмийн гол цөмийг бүрдүүлж, төрийн засаглалаас хараат бус боломжийг олгоно. Иргэний нийгмийн гүнд бүрэлдэж байгаа эрх зүйт төрийн нэг урьдчилсан нөхцөл бол бие даасан үйлдвэрлэгч, хэнээс ч хараат бус хэрэглэгч, эрх чөлөөт иргэн байдаг²². Францын гүн ухаантан Жан Жак Руссо “өөрийн хэсэг газартаа хашаа хатгаж энэ миний гэж хэлсэн тэр хүн л иргэний нийгмийн жинхэнэ үндэслэгч” гэжээ. Одоо бидний нэрлэж заншсан “засгийн ордон тойрон гороолж байгаа” ашиг сонирхлын нэгдлүүд иргэний нийгмийн төлөөлөл яав чиг биш. Харин хөдөөний хот айл л иргэний нийгмийн анхдагч нэгж гэж харагдаад байгаа..

Иргэний нийгмийг орчин үеийн хөгжлийн хандлагаар нь тодорхойлбол, хүний эрх, эрх чөлөөг бүрэн дүүрэн хангах, тэдний бүтээлч, овсгоот үйл ажиллагааны эрх чөлөөг хангах үндсэн дээр элбэг хангалуун амьдрах боломжийг нь бүрдүүлж, хүмүүнлэг, шударга ёс, эрх зүйн уламжлал, хууль ёсны үзэл санааг дээдлэн хүндэтгэж, төрөөс хараат бус, хувь хүнийг хөгжүүлэхэд чиглэсэн чөлөөт, ардчилсан, эрх зүйт нийгэм мөн. Английн гүн ухаантан Жон Локк тухайн үедээ “засгийн газарт өмчлөх эрхийг хамгаалахаас өөр зорилго үгүй” гэсэн нь иргэний нийгмийн эрүүгийн эрх зүйн хамгаалалтын мөн чанарыг тодорхойлсон хэрэг.

Монгол Улсын Үндсэн хуульд: “Монгол Улс эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална. Өмчлөх эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан нь өмчлөх эрхийг баталгаажуулж эрүүгийн эрх зүйгээр хамгаалах эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг тодорхойлсон.

Өмчлөх эрхийн эрүүгийн эрх зүйн хамгаалалт нь Үндсэн хуулиар баталгаажуулсан өмч, өмчлөх эрхийг бүхэлд нь хамгаалах, тодруулбал өмч дээр суурилсан иргэний нийгмийг хамгаална гэсэн ойлголт мөн.

Хуулийн зорилго нь тухайн хуулиар зохицуулах, бэхжүүлэх, хамгаалах харилцааг тодорхойлдог журамтай.

Эрүүгийн эрх зүйгээр хамгаалах харилцааг Монгол Улсын Эрүүгийн 2015 оны хуулийн 1 дүгээр зүйлд: “Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино” гэжээ. Түүнээс гадна энэ хуулийн 17 дугаар бүлэгт тусгайлан хамгаалах харилцааг нарийвчлан тодорхойлсон.

Одоо Эрүүгийн 2002 оны хуулийн зорилттой харьцуулалт хийж үзье.

2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль	Харьцуулалт
“Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний	“Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний	Эерэг тал: -2015 оны хуульд “эрүүгийн эрх зүйн хамгаалалтын хүрээнд “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” зорилгыг тодорхойлсон нь төрийн эрүүгийн

²¹ И.Кант. Сочинения. Т 1. Трактаты и статьи.М., 1994. С 285.

²² Үэнэ үү.: Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал. Уб., 2017

<p>эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энхтайван, хүн төрөлхтөний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино”</p>	<p>ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино”</p>	<p>бодлогын нэг гол чиг хандлагыг бэхжүүлсэн нь маш оновчтой болсон (+).</p> <p>Сөрөг тал:</p> <p>-Нийтийн ба хувийн өмчийг гэмт халдлагаас хамгаалах зорилгыг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах хүрээнд далдалсан (+ -);</p> <p>-“үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам”, гэмт халдлагаас хамгаалах зорилгыг орхигдуулсан, эсхүл нийтийн болон үндэсний ашиг сонирхолын хүрээнд багтаасан (-);</p> <p>-Иргэний нийгмийн нэг үндсэн шинж болох хувийн ашиг сонирхол эрүүгийн эрх зүйн хамгаалалтын зорилгын хүрээнд хөндөгдөөгүй (-)</p>
---	---	---

Эрүүгийн хуулийн зорилго нь Үндсэн хуулиар бэхжүүлж, хамгаалж, зохицуулсан хамгийн амин чухал харилцааг хамгаалахад чиглэнэ. Харьцуулалтаас харахад хүний хувийн өмчид тулгуурласан иргэний нийгмийн хамгаалалт орхигдсон нь хууль тогтоогч, түүнийг төслөгчдөөс онолын суурь мэдлэг ямар түвшинд байгааг илэрхийлж байна. Эрүүгийн эрх зүйн зорилгыг тодорхойлох энэ оролдлого нь социологи онолыг социалист чиг баримжаагаар, өөрөөр хэлбэл эрүүгийн эрх зүйн хувийн ашиг сонирхлыг хамгаалахаас нийт нийгмийн ашиг сонирхол, хүн амын дийлэнх олонхын ашиг сонирлыг илүү хамгаалахад чиглэсэн, хувийн өмчийг орхигдуулсан хуучин номлол гэлтэй.

Хэрэв эрүүгийн эрх зүйгээр хамгаалбал зохих нийгмийн амин чухал харилцаа, зорилгыг тодорхойлж чадахгүй бол гадаадын улс орнуудын туршлагаар хууль зүйн өөр техникийг хүлээн авах нь зүйтэй мэт. Жишээ нь Герман улсын эрүүгийн хуулийн 1 дүгээр зүйл нь ердөө л “хуульгүй бол ялгүй” гэсэн зарчим буюу “хууль тогтоомжоор ял шийтгэхийг урьдчилан тогтоосон бол тухайн үйлдэлд ял шийтгэж болно” гэсэн зарчмаар л эхлэнэ. Гэхдээ эрүүгийн эрх зүйн зорилгогүй гэсэн үг биш, герман, францын шүүгчид эрүүгийн эрх зүйн номлол, эрдэмтдийн бүтээл нь сайн хуулиас ч илүү чухал гэдгийг цөөнгүй тэмдэглэдэг.

Эрүүгийн хуулийн зорилгоо эдгээр улс орнууд эрх зүйн номлол, төрийн бодлогоороо тодорхойлдог. Монгол Улсын эрүүгийн нэгдсэн бодлого томъёологдоогүй учраас хууль зүйн арга хэрэгслийг ашиглаж эрүүгийн хуульд хамгаалах харилцааг тодорхойлох гэж оролдоход хүргэж байна.

Эрүүгийн эрх зүйн номлол нь хууль тогтоомж болон хууль хэрэглээний практикт туйлын бага судлагдсан асуудлын нэг мөн. Эрх зүйн номлол гэдэг нь эрдэм шинжилгээ суурь судалгааны үндэслэсэн, албан ёсоор хүлээн зөвшөөрсөн сургааль буюу шинжлэх ухааны үзэл баримтлалыг хэлнэ. Энэ нь аливаа онол хөгжих тулгуур суурь мөн. Чухамдаа төрөөм албан ёсоор хүлээн зөвшөөрсөн номлол, эсхүл төрөөс эрдэмтэн судлаач, практик ажилтнуудын оролцоотойгоор боловсруулсан эрүүгийн бодлого, үзэл баримтлал ус агаар мэт хэрэгтэй байна.

Орчин үеийн эрүүгийн эрх зүйн нэг голч иг хандлага болох актуар номлол нь эрүүгийн эрх зүйн хориг зөрчсөн үйлдэл эс үйлдэхүй бус, харин нийгмийн аюулгүй байдалд хор уршиг учруулах далд шинж чанарыг илүүтэй тодорхойлоход оршиж байна²³.

²³ Freeley M., Simon J. Actuarial Justice the Emerging New Criminal Law // The Futures of Criminology. L.: Sage, 1994. P. 173—201.

Судалгаанаас үзэхэд өнөөдөр төрийн эрүүгийн бодлого боловсрогдоогүй, эрүүгийн эрх зүйн хамгаалалтын цогц тогтолцоо бүрдээгүй, ялангуяа өмчлөх эрхэд суурилсан иргэний нийгмийн хамгаалалт үгүйлэгдэж байна.

Бидний дагаж мөрдөж ирсэн эрүүгийн эрх зүйн номлол нь европын эрх зүйн сонгодог болон социализмаас өвлөж ирсэн гэмт хэрэг үйлдэх нь аливаа этгээдийн “аюултай байдлын” шинж (симптом) гэж үзэх социологи чиг хандлага, түүний дотор орос, германы нөлөөгөөр бүрэлдэн тогтсон, хамгийн түгээмэл шинжээрээ баруун европын номлолын рецепцийг нутагшуулсанд оршино.

2015 оны эрүүгийн хуулийн үзэл баримтлал нь энэ ягшмал догмаас салахын тулд эрэл хайгуул хийсэн боловч эрүүгийн бодлогын чиг хандлагаа ямар нэгэн эрдэм шинжилгээ судалгааны үндэслэлгүйгээр эрүүгийн эрх зүйн либерализмын онолын аболиционист урсгалыг буюу ямар нэгэн шүүлтүүргүйгээр эрүүгийн цээрлүүлэх бодлогоос ялыг хэт зөөлчисөн, гэмт хэрэгтэнд хэт энэрэнгүй хандсан “криминологийн романтизм”-д суурилсан бодлогыг нэвтрүүлсэн нь ихээхэн шүүмжлэлд өртөөд байна. Шоронжсон хэмээн цоллуулсан 2002 оны эрүүгийн хуулийн ялын бодлогод баримталж байсан социологи хандлагыг үгүйсгэснээр гяндан, чанга дэглэмд ял эдэлж байсан ялтнууд жирийн дэглэмд “султан хаан” шиг эрх ямбатай байгааг хуульчид шүүмжилдэг. Шоронжих ойлголт нь хоригдлын тоо нэмэгдсэнээр бус, харин шоронгийн гаж соёл, субкультур жирийн сул дэглэмээр дамжин ниймийн дунд түгэн дэлгэрэх боломж олгосон хуулийг л шоронжсон хууль гэмээр.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэл нь парламентын сонгууль, түүнээс байгуулсан засгийн газрын мөрийн хөтөлбөртэй уялдан байнга өөрчлөгдөж ирсэн нь мөн л төрийн нэгдсэн тогтвортой суурь бодлого үгүйлэгдэж буйн жишээ. Шинэ засгийн газар бүр л өөр өөрсдийн эрүүгийн бодлогыг тодорхойлж, өөрийн гэсэн халаасны “ажлын хэсэг” бүрдүүлж, гаднын аль таалагдсан зүйл заалт, рецепцийг шууд хуулбарлаж ирсэн нь туйлын эмгэнэлтэй. Иймд аль нэг эх баригч нам, тухайн үеийн засгийн газрын мөрийн хөтөлбөрт үл автах төрийн эрүүгийн “хар хайрцагны” бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх нь өнөөгийн тулгамдаж буй асуудлын нэг мөн.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлт нь хүний эрхийг хамгаалах талаарх олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг хэрэгжүүлэхийн хамт гадаад улс орнуудын хууль тогтоомжийг судалж нэвтрүүлэхдээ өөрийн орны эрх зүйн тогтолцооны уламжлалд суурилсан шинэчлэл үгүйлэгдэж байна.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд эрүүгийн бодлого, эрүүгийн хууль тогтоомжийг шинэтгэх арга зам төдийгүй, тухайн шинжлэх ухааны өнөөгийн статус, хөгжлийн чиг хандлага ч тодорхой бус байна.

Төрийн эрүүгийн бодлого нь гэмт явдлыг аль болох бууруулах, тогтоон барихад чиглэсэн төрийн үйл ажиллагааны стратегийн зорилт, чиглэлийг тодорхойлоход оршино. Эрүүгийн эрх зүй нь эрүүгийн хэрэг шийдвэрлэх ажиллагааг хангаж, хүн, хуулийн этгээдэд зан үйлийг гэмт хэрэгт тооцож ялтай болгосон эрх зүйн хэм хэмжээний тогтолцоо, эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл мөн.

Гадаад улс орнуудын туршлагаас үзэхэд эрүүгийн бодлого боловсруулах нийтлэг технологи, процедурыг баримталж байна:

- Эрүүгийн эрх зүйн онол номлолын үндэслэлийг боловсруулах (Энэ хүрээнд эрүүгийн эрх зүйн эрдэмтдийн хүчин чармайлтыг нэгтгэж, эрүүгийн эрх зүйн ямар онол, үзэл баримтлал, рецепцийг нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэнэ);
- Онолын үндэслэлд тулгуурлан эрүүгийн бодлогын талаарх төрийн үзэл баримтлалыг хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд боловсруулах (Энэ хүрээнд альч засгийн үед үл солигдох төрийн эрүүгийн хар хайрцагны бодлого боловсрогдоно);
- Эрүүгийн бодлогын эрх зүйн орчин, эрх зүйн үндсийг хөгжүүлэх (Эрүүгийн багц хуулийг номлол, үзэл баримтлал бодлогод нийцүүлэн боловсруулж, батлуулах, уг хуулийг хэрэгжүүлэх тогтолцоо, санхүү хөрөнгийн эх үүсвэрийг хамт шийдвэрлэх);
- Эрүүгийн бодлогыг улс даяар хэрэгжүүлэх;
- Эрүүгийн бодлогын дэд хөтөлбөрүүдийг (өмчлөх эрхийг хамгаалах гэх зэрэг) боловсруулж хэрэгжүүлэх;
- Эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд хууль хэрэглэх үйл ажиллагаа зэрэг.

Эрүүгийн бодлогын цогц тогтолцоо нь:

- Эрүүгийн болон эрүүгийн нөлөөллийн арга хэрэгслээр гэмт хэрэгтэй тэмцэх;
- Эрүүгийн процессын буюу гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, нотлох, албадлага хэрэглэх, хариуцлага хүлээлгэх;
- Эрүүгийн ял эдлүүлэх;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого (криминологи, виктимологи, деликтологи)
- Зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, гэмт хэргийн хохирол, хор уршгийг арилгах, нийгэмшүүлэх бодлого зэргээс бүрдэхээр төсөөлөгдөж байна.

Орчин үеийн эрүүгийн эрх зүй нь шинжлэх ухааны янз бүрийн чиг хандлагын нөлөөллийн үр дүн гэж үзэж болно. Хэрэв зонхилох чиг хандлагын хувьд авч үзвэл аль ч орны хууль тогтоогчид гэмт явдлын асуудалд хандахдаа хориотой үйлдлийн шинж чанарыг аль болох нарийн тодорхойлохын тулд эрүүгийн эрх зүйн сонгодог үндэслэлд, харин ялын асуудалд хандахдаа гэмт хэрэгтнийг залхаан цээрлүүлэх бус харин тэднийг нийгэмшүүлэх, хэрэв нийгэмд аюултайд тооцвол аюулгүй байдлын үүднээс найдвартай тусгаарлах асуудлаар эрүүгийн эрх зүйн социологи чиг хандлагад тулгуурлаж байна. Мөн орчин үеийн улс орнуудад гэмт явдлыг эрүүгийн эрх зүйн онолын үүднээс, харин тодорхой төрлийн ялын хэмжээг улс төрчдийн номлолын үндэслэлээр тогтоох хандлага зонхилж байна.

Иймд:

Нэгдүгээрт, төрийн эрүүгийн бодлогын онол, үзэл баримтлалын үндсийг тогтоож, төрийн эрүүгийн “хар хайрцаг”-ны бодлогын эрдэм шинжилгээ судалгаанд суурилсан үзэл баримтлалыг хууль тогтоогчоос боловсруулах;

Хоёрдугаарт, төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжих эрх зүйн цогц орчинг бүрдүүлэх (эрх зүйн үндэс, уялдаа холбоо бүхий тогтолцоо, санхүүгийн эх үүсвэр гэх зэрэг);

Гуравдугаарт, энэ үйл ажиллагаанд хууль зүйн болон бусад эрдэмтэн судлаачдын хүчийг нэгтгэх;

Дөрөвдүгээрт, Эрүүгийн хууль Үндсэн хуульд хэр нийцэж байгаа талаарх мониторинг хийх шаардлагатай.

ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ХҮНИЙГ БАРИВЧЛАХ, ТАСЛАН ЗОГСООХ ЗОРИЛГООР ХАЛДАХ ҮЕД АНХААРАХ АСУУДАЛ

Л.Бат-Очир

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад*

Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан нийгмийн үнэт зүйлсийг өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлага, олон улсын гэрээ конвенцийн үзэл баримтлалд нийцүүлэн өөрчлөх, хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдал, нийтийн эрх ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэх²⁴ зорилтын хүрээнд Эрүүгийн хуулийг шинэчлэн боловсруулж 2017 оноос хэрэгжүүлж эхэлснээс хойш багагүй хугацаа өнгөрөөд байна. Эдгээр шинэчлэл нь нэг талаас хувь хүний болон нийтийн, үндэсний ашиг сонирхлыг хамгаалахаас гадна төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагчдын хууль ёсны ажиллагааг зөвтгөх, хамгаалахад чиглэгдсэн төдийгүй дэлхийн улс орнуудын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны дэвшил, ололтыг нэвтрүүлэхэд чиглэгдсэн юм. Тухайлбал, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагчид хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт хохирол учруулах явдал цөөнгүй гарсаар байна. Энэ нь алба хаагчдын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ, хүний эрхийн талаарх мэдлэгийн түвшин, албан үүрэг гүйцэтгэх биеийн болон сэтгэл зүйн бэлтгэл, ур чадвараас ихээхэн хамааралтай юм.

Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлд **баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах ажиллагааны талаар** “Гэмт хэрэг үйлдэж оргосон хүнийг баривчлах, эрх бүхий байгууллагад хүргэх, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг таслан зогсоох зорилгоор энэ хуульд заасан үйлдлийг аргагүй байдалд хийж тухайн хүнд халдсан нь баривчлах, таслан зогсоох хэр хэмжээнээс хэтрээгүй бол гэмт хэрэгт тооцохгүй”, “Гэмт үйлдлийн шинж чанар, хэр хэмжээнд илт тохироогүй, зайлшгүй хохирол учруулж баривчлах шаардлагатай нөхцөл байдал үүсээгүй байхад, хууль сахиулагч хуульд заасан баривчлах, таслан зогсоох үндэслэл, журмыг зөрчин бусдад халдаж хохироосныг баривчлах, таслан зогсоох хэр хэмжээг хэтрүүлсэнд тооцно” гэж тус тус заажээ.

Цагдаагийн алба хаагч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх явцдаа гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүнийг баривчлах, тухайн хүнээс үзүүлж байгаа эсэргүүцлийг таслан зогсоох зорилгоор алба хаагчид албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлага тулгардаг ба хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэж баривчлах, төрийн байгууллагад албадан хүргэх ажиллагааны явцад хохирол, эрсдэл учруулахгүй байх, зайлшгүй шаардлага тулгарсан үед хамгийн бага эрсдэл учруулахыг эрмэлзэж, Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэж өөрийгөө болон бусдыг хамгаалах үүрэгтэй.

Гэмт хэрэг үйлдсэн хүнийг баривчлах, таслан зогсоох ажиллагааны үед гэмт хэрэг, зөрчил үйлдэж буй газар, цаг агаар, тухайн хүний сэтгэл зүйн байдал, хувийн байдлын онцлог, зэвсэг хэрэгсэл байгаа эсэх, хүч хэрэглэх шаардлага бий болсон нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүн болон бусад хүнд учирч болох эрсдэл, тухайн хүний үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн нийгмийн хор аюул, учруулсан хохирлын хэр хэмжээ, алба хаагч өөрийн туршлага, албаны бэлтгэл зэргийг харьцуулан дүгнэж ямар хүч хэрэглэх талаар шийдвэр гаргана.

Дээрх зүйлс нь алба хаагчдын хувьд нийтлэг асуудал бөгөөд зарим тодорхой гэмт хэргийн онцлог шинжээс хамааран өөр өөр нөхцөл байдалд байдаг тул тухайн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, бодитой үнэлэх нь баривчлах, таслан зогсоох ажиллагаа нь хууль ёсны байсан эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөхөд чухал ач холбогдолтой юм. Практикт үйлдэгдэж буй нийт гэмт хэргийн бүтэцээс үзэхэд дийлэнх нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг байдаг²⁵ бөгөөд энэ төрлийн гэмт хэргээс зарим онцлог гэмт хэрэг үйлдсэн хүнийг баривчлах таслан зогсоох зорилгоор халдах үед чухам ямар зүйлийг анхаарах талаар авч үзье.

²⁴ Гэмт хэргийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал.УБ.2015.1 дэх тал

²⁵ Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном.УБ., 2017.142-144 дэх тал

Хулгайлах гэмт хэргийг ихэвчлэн эрхэлсэн тодорхой ажилгүй, хүүхэд залуучууд үйлддэг ба энэ гэмт хэргийн объектив талын нэг онцлог шинж нь нууц далд аргаа үйлдэгддэг бөгөөд хулгайлах гэмт хэрэг үйлдэж байгаа хүн бусад хүмүүс намайг хараагүй гэдэгт бат итгэсэн үедээ хулгайлах үйлдэл хийдэг төдийгүй бусдын нүдэнд харагдахыг, илчлэгдэхийг хүсдэггүй тул баривчлах таслан зогсоох үед аль болох зугатаах, эсэргүүцэх, шаардлага биелүүлэхээс татгалзаж байдаг. Өөрөөр хэлбэл өөрийгөө илчлэхгүйн тулд юуч хийхээс буцахгүй байх тохиолдол байна. Тийм учраас цагдаагийн алба хаагч гэмт хэрэг үйлдэж буй хүний сэтгэл зүйн онцлогыг нэн тэргүүнд харгалзах нь чухал байдаг. Жишээ нь: Ховд аймгийн Булган суманд шөнийн цагаар дэлгүүрт хулгай хийж байсан хүмүүсийн талаар мэдээлэл авсан цагдаагийн алба хаагч нар, хэргийн газар яаравчлан ирж, дэлгүүрийн хаалгаар орох үед, нэг алба хаагч нь буудагдаж амь насаа алдсан харамсалтай хэрэг гарч байв.

Ийм үед хаалга, цонх, гарц, хонгил, дээвэр зэрэг тухайн объектын онцлогыг сайтар судлах, зугтаах боломжийг хаах, үйлдлийг нь хэдийд таслан зогсоох, хэрхэн яаж объект руу нэвтрэх, харилцан ярилцах, шаардлага тавих, гэмт хэрэг үйлдэж буй хүний онцлог, шинж, үйлдлийн арга, зэвсэг хэрэгсэлтэй эсэх талаар богино хугацаанд дүгнэлт хийж, баривчлах ажиллагааг зохион байгуулна.

Нийтийн тээврийн хэрэгсэл, олон хүн цугларсан арга хэмжээ, зах худалдааны төвүүд, автобусны зогсоол дээр, халаасны хулгай хийж буй хүн, бусдын мөнгө, эд зүйлийг авмагц богино хугацаанд бусад хамтран оролцогчдоо дамжуулдаг. Энэ үед гэмт хэрэг үйлдсэн хүний зугтаах боломжийг хааж, шаардлагатай үед иргэдийн туслалцаа авч, мөнгө, эд зүйл болон хууль бусаар авсан хүнийг яаравчлан баривчлах, бусад нотлох баримтаар үйлдлийг нь нотлох нь чухал юм. Ихэнх тохиолдолд хохирогчид цагдаагийн байгууллагад эд зүйлээ алдсаны дараа мэдээлэл өгдөг тул тухайн гэмт хэрэг үйлдсэн хүнийг олж илрүүлэн баривчлахын тулд сайтар судлах боломж бүрддэг. Бусдын орон байранд хууль бусаар нэвтэрсэн үед өмчлөгч, эзэмшигч нь орж ирэх тохиолдол байж болно. Ийм үед гэмт хэрэг үйлдэж буй хүнийг цагдаагийн байгууллагад дуудлага өгсөний дараа, алба хаагч ирэх хүртэл хориглон тогтоох, саатуулах үйлдлийг хэрэгжүүлэх шаардлага гарна. Дээрх тохиолдолд хэрхэн ямар үйлдлийг хэрэгжүүлэх, гарах үр дагаварын талаар эрүүгийн хуульд зохицуулаагүй байдаг.

Ийм учраас гэмт хэрэг үйлдсэн хүнийг баривчлах, таслан зогсоох ажиллагааг зөвхөн баривчлах, таслан зогсоох үйлдлээр хязгаарлаж болохгүй юм. Өөрөөр хэлбэл энэ ажиллагаа нь хүний халдашгүй эрхэд халддаг учраас, баривчлах, таслан зогсоох, хориглон тогтоох, саатуулах зэрэг түүнээс үүдэн гарах бүхий л эрүүгийн эрх зүйн үр дагаварыг цогц байдлаар нь харж зохицуулах ёстой. Эрүүгийн хуулийн тусгай ангид нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээгээр их гэмт хэргийн нэг нь дээрэмдэх гэмт хэрэг юм. Судалгаанаас үзэхэд²⁶ энэ төрлийн гэмт хэрэг Дархан-Уул аймаг, Баянгол дүүрэгт хамгийн их үйлдэгдсэн байна. Дээрэмдэх гэмт хэрэг үйлдсэн хүн хохирогчийн эд хөрөнгийг авахаас гадна, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах үйлдэл хийж болзошгүй тул, ихэвчлэн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, эсэргүүцэх, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зүйл хэрэглэн довтлох, зугтаах тохиолдол их байдаг. Ийм үед хэрэглэсэн зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл²⁷, нохой, бие бялдарын байдал, согтуурсан, мансуурсан эсэх, сэтгэл зүйн байдал, цаг агаар, зэргийг сайн анхаарч дүгнэн, тухайн нөхцөл байдалд нийцсэн арга, тактик биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэн баривчлах, таслан зогсоох ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хүч хэрэглэхгүй, хууль бусаар авсан үед ихэвчлэн зугтаах үйлдэл хийдэг бөгөөд хөөж барих үедээ бусдын аюулгүй байдлыг хангах, бэртэж гэмтэхээс урьдчилан сэргийлэх, орчин тойрноо бүрэн хяналтанд авах, хэт сэтгэл хөөрлийн байдалд орохоос сэргийлэх нь чухал юм. Айдас түрэмгийлэл, хүчирхийлэл нь мэдрэмжийг алдагдуулж, эргэцүүлэн бодох, шийдвэр гаргах мэдрэлийн төвийн үйл ажиллагааны хэвийн байдлыг алдагдуулж, мэдлэг, үр чадвараа

²⁶ Гэмт хэргийн цагаан ном.УБ.,2017.314-315 дугаар тал.

²⁷ “Зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл” гэж иж бүрдэл, бүтцийн хувьд аливаа биетийг устгах, гэмтээх, бие хамгаалах, дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгслийг хамааруулж ойлгоно. Зэвсэг нь галт, хүйтэн, хийн, үйлдвэрийн, гар хийцийн аль нь ч байж болно. “Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл” гэж хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулахаар тусгайлан бэлтгэсэн, засаж тохируулсан хүйтэн зэвсэг, галт зэвсэг, эд зүйл, хэрэгслийг ойлгоно.

ашиглахад саад учруулан хөдөлгөөнийг удаашруулж, эвсэлгүй болгодог. Цагдаагийн алба хаагч хурдацтай өрнөж байгаа нөхцөл байдлын үед ямар үед ямар үйлдэл хийхээ сайтар бодох, чөлөөтэй амьсгалах, тайван байх, гэмт хэрэг үйлдсэн хүний гар, нүд, түүний ар талын орон зайг ажиглах хэрэгтэй. Туршлага багатай алба хаагч аюултай нөхцөл байдлыг ч огт өөрөөр төсөөлж байдаг нь тэднийг эрсдэлд оруулхад нөлөөлдөг байна.

Залилах, хөрөнгө завших гэмт хэрэг үйлдэж буй хүнийг баривчлах, саатуулах явцад бүх үйлдлээ тооцоолсон, урьдчилан бэлтгэсэн, ов мэх ихтэй, сэтгэн бодох чадвар өндөр, нөхцөл байдлыг чадварлагаар ашиглах, нөхөрсөг харилцаа тогтоох сонирхолтой байдаг тул сэтгэл зүйн хувьд харьцангуй тайван нөхцөлд байдаг. Тийм учраас худал ярих, хууран мэхлэх, төөрөгдүүлэх, нотлох баримтыг устгах оролдлого хийж болно. Нөгөө талаар хохирогч хохирсоноо мэддэггүй ба бодитой эд зүйлийг залилах замаар авч байгаа тохиолдолд өөр байна.

Гэхдээ баривчлах, таслан зогсоох ажиллагааны үед зугтаах, хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, амиа хорлох үйлдэл хийж болзошгүй тул хэт тайван байдалд дасан зохицож, орчиндоо тавих хяналтыг сулруулж болохгүй. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан “Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших”, “Нотариатч, улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих” гэмт хэрэг үйлдсэн хүн, хууль сахиулагчыг эсэргүүцэх явдал харьцангуй бага ба сэтгэл зүйн хувьд тайван байдаг. “Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх” гэмт хэргийг урд нь ял шийтгүүлж байсан, урьдчилан төлөвлөсөн, зохион байгуулалтай, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүн үйлдэх магадлал өндөр байдаг учраас тухайн ажиллагааг баримтжуулах, эрсдэлийг тооцоолох нь зүйтэй. “Эд хөрөнгө, устгах гэмтээх”, “Автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах” гэмт хэрэг үйлдэж буй хүнийг баривчлах, таслан зогсоох явцад гэмт хэрэг үйлдсэн хүн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаас зайлсхийх, зам тээврийн осол гарахаас урьдчилан сэргийлэх, шаардлагатай бол нэмэлт хүч, шуурхай бүлэг, ойрын эргүүлийн тусалцааг авах, бусад алба хаагчдыг татан оролцуулах, тохиромжтой арга хэрэгсэл ашиглаж болно.

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан үнэт зүйлсийг хамгаалах, үндэсний баялаг уламжлалаа дээдлэх, хамгаалах зорилгоор “Мал хулгайлах” гэмт хэргийг 2015 оны эрүүгийн хуульд²⁸ шинээр хуульчилсан байна. Энэ төрлийн гэмт хэрэг үйлддэг хүн нь бие, сэтгэл зүйн хувьд урьдчилан сайтар бэлтгэсэн байдаг ба сүүлийн үед тээврийн хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх тохиолдол ихсэж байна. Ийм үед баривчлах, таслан зогсоох ажиллагааг хэрэгжүүлэхдээ дуудлага мэдээллийг хүлээн авмагц, хэргийн газарт богино хугацаанд очих²⁹, эрсдлээс урьдчилан сэргийлж, алба хаагчид болон бусад хүний аюулгүй байдлыг хангаж ажиллах шаардлагатай. Тээврийн хэрэгсэлд хийх үзлэг, шалгалтыг эрчимжүүлэх, сонор сэрэмжтэй, гярхай байх, тээврийн хэрэгсэл явж болох бүхий л зам, суваг, шуудуу, гуу, жалга, уулын ам, голын гарам зэргийг хяналтанд авах, хэдийд баривчлах, таслан зогсоох ажиллагааг хэрэгжүүлэх, ямар арга хэрэгсэл хэрэглэх талаар нарийн тооцоолж төлөвлөх шаардлагатай. Эрүүгийн эрх зүй дэх баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах ажиллагаа нь дан ганц эрүүгийн эрх зүйн судлагдахуун бус сэтгэл судлал, эрүүгийн процесс, иргэний эрх зүй, захиргааны эрх зүй, цагдаагийн эрх зүй, криминологи зэрэг олон шинжлэх ухааны уулзварт оршдог цогц ойлголт төдийгүй баривчлах, таслан зогсоох ажиллагааг хэрэгжүүлсний дараа, хориглон тогтоох, зарим эрхийг хязгаарлах, төрийн зохих байгуулагад хүргэх ажиллагаанаас үүсэх үр дагаварын талаарх зохицуулалтыг орхигдуулсан нь практикт эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх, хүний эрхийг зөрчих, алба хаагчын хууль ёсны үйл ажиллагааг буруутгах, ял оногдуулах зэрэг нөхцлийг бүрдүүлэхээр байна.

Хууль сахиулагч нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг баривчилж төрийн зохих байгууллагад тээврийн хэрэгсэл, явганаар хуяглан хүргэх бөгөөд хоёр ба түүнээс дээш алба хаагчын бүрэлдэхүүнтэй³⁰ гүйцэтгэнэ. Хуяглан хүргэх явцад шуурхай, богино хугацаанд хамтын

²⁸ Эрүүгийн хууль.УБ.2015.он.17.12 дугаар зүйл.

²⁹ АНУ, БНСУ зэрэг улсад цагдаагийн байгууллагад ирсэн дуудлага, мэдээллийг хүлээн авсанаас хойш 3 минутын хугацаанд хэргийн газарт ирэх журам байдаг ба сүүлийн үед иргэний байгууллагууд энэ хугацааг хэт их байгаа тул богиносгох ёстой гэж үзэж байна.

³⁰ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам.УБ.,2016.222.3 дугаар зүйл.

ажиллагаанд түшиглэн гүйцэтгэхээс гадна хүний эрх, эрх чөлөө, гэмт явдал үйлдсэн хүн, өөрийн болон хамтрагчын аюулгүй байдал, амиа хорлох, зугтаах боломжийг онцгой анхаарч ажиллах, басамжлан доромжлох, зүй бус үг хэрэглэхгүй байх, хүнлэг бус хэрцгий харьцахгүй байх, хувийн асуудлаар ярилцах, нийтийн тээврийн хэрэгсэл ашиглахгүй байх зэргийг анхаарах нь зүйтэй. Практикт гэмт хэрэг үйлдсэн хүнийг баривчилсаны дараа доромжлох, зүй бус үг хэллэг хэрэглэх, хүнлэг бус харьцах тохиолдол их байдаг учир сэтгэл хөдлөл өндөр алба хаагчыг гэмт хэрэг үйлдсэн хүнээс хол зайнд байлгах шаардлагатай.

Эрүүгийн эрх зүйн судлаачид³¹ баривчлах, таслан зогсоох ажиллагаа нь зөвхөн хууль сахиулагчид бус иргэдэд хамааралтай, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажиллагаанд тэдний оролцоог нэмэгдүүлэх сайн талтай гэх боловч одоогийн зохицуулалтаас үзэхэд тийм боломж байхгүй байна. Тухайлбал Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд³² зааснаар иргэд гэмт хэргийг таслан зогсоох талаар ямар нэгэн үүрэг хүлээхгүй учраас, хууль зүйн хариуцлага хүлээлгэхгүй. Эрх зүйн соёл, ухамсар төлөвшөөгүй одоогийн нийгэмд иргэд өөрийн хүсэл зоригт үндэслэн, гэмт явдлыг таслан зогсоох ажиллагаанд оролцох нь хомс болсоныг олон судалгааны үр дүнгээс харж болно.

Ийм учраас Эрүүгийн хуульд заасан “Баривчлах таслан зогсоох зорилгоор халдах” гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг өөрчлөн найруулах, бусад хууль тогтоомжийг Эрүүгийн хуульд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай.

³¹ С.Нарангэрэл.Монгол Улсын эрүүгийн эрх зүй ерөнхий анги.УБ.,2000.45 дахь тал, Г.Совд.Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар.УБ.,2002.56 дугаар тал.56 дахь тал, С.Жанцан.Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол.Нэгдүгээр боть.УБ.,2009. 294 дэх тал, Ж.Болдбаатар, З.Төрмандах. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тулгуур ойлголтууд.УБ.,2008.34 дэх тал, Ж.Авхиа, Б.Ганболд.Монгол Улсын эрүүгийн хуулийн ерөнхий ангийн тайлбар.УБ.,2002.135-136 дахь тал

³² Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль.УБ.1997 он.10 дугаар зүйл

ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ЗҮЙЛЧЛЭЛ БА ЯЛ /ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЖИШЭЭН ДЭЭР/

Б.Ганболд

Хуульч, өмгөөлөгч, эрүүгийн эрх зүй судлаач

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн ойлголт: Эрүүгийн эрх зүйн онол, практикт зонхилох байр суурийг эзэлдэг гэмт хэргийн бие даасан нэгэн төрөл нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг юм.

Нэрт эрдэмтэн С.Жанцан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг “бусдын эд хөрөнгийг хууль бусаар, үнэ төлбөргүйгээр, өөрийн болон бусдын эрхшээлд авах замаар өмчлөгчид эд хөрөнгийн хохирол учруулж буй үйлдэл, эс үйлдэхүй” хэмээн бүтээлдээ тодорхойлсон байдаг.³³

Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг хулгайлах, булаах, дээрэмдэх, залилах, завших, эд хөрөнгө устгах, гэмтээх зэргээр үйлдэгдэх арга хэлбэрээр нь, хууль зүйн шинж онцлогоор нь эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах шинжтэй болон ийм шинжгүй, сэдэлтээр нь шунахай сэдэлттэй ба шунахай сэдэлтгүй гэмт хэрэг гэж ангилан төрөлжүүлэн судлан үзэж ирсэн байна.³⁴

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүдийн дотор хулгайлах гэмт хэрэг хамгийн түгээмэл үйлдэгддэг бөгөөд онолыг төдийгүй практикт тулгамдсан олон асуудлыг ямагт дагуулж ирсэнээрээ онцлогтой учир илтгэлд тулгуур болгон жишээлсэн болно.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн /сэдвийн/ судлагдсан байдлын тойм: Нэрт хуульч Р.Гүнсэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг хэмээх энэхүү нэг сэдэвт бүлгийн эрүүгийн эрх зүй судлалаар манай улсын хууль зүйн шинжлэх ухааны хамгийн анхны эрдэмтэн болсон түүхтэй.³⁵

Энэ бүлэг сэдвээр Р.Гүнсэн. Хөрөнгөтний биш хөгжлийн замаар социализмд шилжихэд улс ба хоршооллын өмчийг хамгаалах асуудал. УБ., 1970., Р.Гүнсэн. Улс, хоршоолол, олон нийтийн өмчийг ашиглан шамшигдуулах гэмт хэрэгтэй хийх тэмцлийн эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал. УБ., 1989., Д.Адъяабазар, Л.Батжав. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг /сургалтын гарын авлага/. УБ., 2008 болон бусад нэг сэдэвт олон бүтээлүүд /онцлон жишээлвэл: С.Жанцан, Ж.Халиунсүрэн. Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлага, криминологийн асуудал. УБ., 2008/ хэвлэгдэн гарчээ.

Практик зүйн хувьд Эрүүгийн хуулийн 3 дугаар бүлгийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай /1997.06.23., №259/, Эрүүгийн хуулийн 123¹ дугаар зүйлийг тайлбарлах тухай /1997.02.26., №74/, Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай /2006.05.29., №28/, Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар /2006.12.21., №51/ гэх мэт Улсын дээд шүүхийн тогтоол, Мал хулгайлах гэмт хэргийг шийдвэрлэж байгаа шүүхийн практикийн тухай зөвлөмж /2004.03.25/ зэрэг бий.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан байдал: Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан байдлыг 2002 ба 2015 оны Эрүүгийн хуулийн харьцуулалтыг жишээлэн авч үзлээ.

Ерөнхий агуулгын хувьд судлахад ... өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг нь 2002 оны Эрүүгийн хуулиар Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг гэсэн 7-р хэсэгт хамаарч, тус хэсгийн Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг гэх 19-р бүлэгт багтаж байсан бөгөөд хууль зүйн хувьд энэ хэсгийг Өмчлөх эрхийн болон Аж ахуйн эсрэг гэмт хэрэг гэж дотор нь 2 бүлэгт хуваан хуульчлан заасан байв. Харин 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар Аж ахуйн эсрэг гэмт хэрэг гэсэн нэр бүхий бүлэг байхгүй байна.

³³ С.Жанцан. МУ-ын Эрүүгийн эрх зүй, тусгай анги /схемчилсэн тайлбар/. УБ., 2003., 144 дэх тал.

³⁴ Б.Ганболд. МУ-ын Эрүүгийн эрх зүй /ерөнхий ба тусгай анги/. УБ., 2006., 215 дахь тал.

³⁵ Б.Ганболд. Эрүүгийн номлол /зураглалт толь/. Тусгай анги. УБ., 2016., 39 дэх тал.

Явцуу хүрээнд 2002 болон 2015 оны Эрүүгийн хуулиудад тусгагдсан зарим гэмт хэргүүдийг харьцуулан үзүүлбэл:

Нэг. Хулгайлах. 2002 оны Эрүүгийн хуулийн 145-р зүйлийн 1 /бусдын эд хөрөнгийг хулгайлсан бол/, 2008.02.01-ний өдрийн Эрүүгийн хуулийн нэмэлт /бусдын эд хөрөнгийг хулгайлсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол/, 2015 оны Эрүүгийн хуулийн 17.1-р зүйлийн 1 дэх хэсэг /бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол/. 2017.05.11-ний өдрийн Эрүүгийн хуулийн нэмэлт /энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй/.

Хоёр. Булаах. 2002 оны Эрүүгийн хуулийн 146-р зүйлийн 1 /бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр булаасан бол/, 2008.02.01-ний өдрийн Эрүүгийн хуулийн нэмэлт /бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр булаасны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол/, 2015 оны Эрүүгийн хуулийн 17.2-р зүйлийн 1 /бусдын эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан бол/.

Гурав. Дээрэмдэх. 2002 оны Эрүүгийн хуулийн 147-р зүйлийн 1 /бусдын эд хөрөнгийг авах зорилгоор амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон бол/, 2015 оны Эрүүгийн хуулийн 17.2-р зүйлийн 2 /бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхээр заналхийлж авахаар довтолсон бол/.

Дөрөв. Мал хулгайлах. 2002 оны Эрүүгийн хуулийн 145-р зүйлээр бусдын эд хөрөнгө гэж үзэж адилтган зохицуулж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулийн 17.12-р зүйлээр /бусдын малыг хулгайлсан бол/ бие даасан байдлаар хуульчлан заасан.³⁶

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хуульчлагдсан байдлын хувьд мал хулгайлах гэмт хэргийг онцлон жишээлж болох юм. Хууль тогтоогч мал хулгайлах гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг гэж үзэхдээ “мал гэдэгт” зөвхөн 5 хошуу малыг багтааж, олон тооны мал гэдэгт 24 бог, 8 бод гэсэн тоо бүхий хуульчилсан тайлбар өгсөн.

Мал хулгайлсан этгээд бол тусгайлан зүйлчлэгдэх нь тодорхой ч үхсэн, амьд ямар мал хулгайлвал хэрхэх нь хуульчлагдсан гэдэг нь тодорхой бус байна. Жишээ нь: А гэдэг малчин эхнэр нь амаржих болсон тул 2 хонь гаргахаар болов. Ийнхүү 1 хонио гаргаж байтал эхнэр нь төрлөө гэхлээр нь яаран сандарч нөгөө хонио гаргалгүйгээр орхиод явжээ. Гэтэл малын хулгайч А энэ сиймхийг ашиглан 1 гаргасан /муулсан/, 1 гаргахаар хөлийг нь тушсан /амьд/ хонийг авч одов. Энэ жишээнээс үзвэл А-гийн хулгай хийсэн үйлдлийг мал хулгайлсан гэж хуульчилсан уу?, эсхүл эд хөрөнгө хулгайлсан гэж хуульчилсан уу, бүр аль аль нь уу. Манай хууль тогтоогчид ийм л хууль бүтээдэг.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн үзэл баримтлал: 2002 оны Эрүүгийн хуулийн тухайд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн хувьд “өмчлөх эрхэд халдсан гэмт хэргүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж ирсэн зүйл, заалтыг бүхэлд нь шинэчлэн найруулж, хүндрүүлэх, онц хүндрүүлэх нөхцөл байдалтай үйлдсэн бол хүлээлгэх хариуцлагыг чангатгасан болно” гэж энэхүү хуулийн голлох автор гэгддэг доктор /Sc.D/, профессор С.Жанцан өөрийн 2003 онд гаргасан Монгол Улсын Эрүүгийн эрх зүй, тусгай анги /схемчилсэн тайлбар, зүйлчлэл/ бүтээлдээ бичин тэмдэглэжээ.³⁷

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын концепци дараахь утга байлаа, үүнд /хууль зүйн яам – ажлын хэсэг – шинэ үзэл баримтлал/:

- шийдвэрлэхэд байнга бэрхшээл учруулж байдаг хулгай, дээрэм, булаалт зэрэг өдөр тутам гарч буй, хуулийн байгууллагын үйл ажиллагаа, ажлын ачаалалд нөлөөлж байдаг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хоёрдмол утгагүй, нарийвчлан, илүү тодорхой байдлаар хуулийн төсөлд тусгана.
- хуулийн төсөл боловсруулахдаа гэмт хэргийг зүйлчлэхэд хүндрэл учрахгүй байхад анхаарч ижил төрлийн харилцааг хамгаалсан, гэмт хэрэгт тооцож, ял оногдуулахаар заасан хэм хэмжээний давхардлыг арилгана.³⁸

³⁶ Төрийн мэдээлэл. 2016., №07/916/, УБ., 323 дахь тал

³⁷ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй, тусгай анги /схемчилсэн тайлбар, зүйлчлэл/. УБ., 2003., 3 дахь тал

³⁸ Хууль зүйн яам. Эрүүгийн хуулийн төсөл. УБ., 2015., 12 дахь тал

Дээрх үзэл баримтлалын дагуу 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар зарчмын шинжтэй дараах өөрчлөлт орсон болно, үүнд:

- хулгайлах гэмт хэргийг шинээр томъёолохдоо хохирлын хэмжээ шаардаагүй,
- мал хулгайлах гэмт хэргийг бусдын /өмч/ эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргээс тусгай зүйлд хуульчлан заан тусгаарлаж өгсөн,
- автотээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авч явах гэмт хэргийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг гэсэн 24-р бүлгийн 223-р зүйлд заагдсан байсныг өмчлөх эрхийн эсрэг энэ бүлэгт шилжүүлж оруулсан,
- 2002 оны Эрүүгийн хуулийн 146 /бусдын эд хөрөнгийг булаах/, 147 /бусдын эд хөрөнгийг дээрэмдэх/ -р зүйлүүдийг нэгтгэн дээрэмдэх гэж томъёолсон,
- залилахад “ашиглан шамшигдуулсан” байхыг шаардсан ба олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврыг хүндрүүлэхээр заасан,
- 2002 оны Эрүүгийн хуулийн 152 дугаар зүйл /хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн бусдын эд хөрөнгө завших/ -ийг завшихад нэгтгэсэн,
- зүйлүүдийн диспозицийг тодорхой болгосон /жишээ нь: нууцаар, хууль бусаар .../, хуульчилсан тайлбар хийсэн, жишээ нь: мал гэдэгт ...
- эд хөрөнгө устгах, гэмтээх үйлдлүүдийг нэгтгэсэн учир холбооны шугам хамгаалах журам зөрчих /ЭХ-242/ гэмт хэргийг багтсан тул хассан, харин энэ бүлэгт хуулийн этгээдэд ял оногдуулах зохицуулалт /гэмт хэрэг/ байхгүй болно.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн зүйлчлэл. Тухайн этгээдийн үйлдэл эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ямар гэмт хэргийн шинжтэй болохыг тогтоох ажиллагааг зүйлчлэл гэж нэрлэдэг.³⁹ Жишээ нь: бусдын зүүж явсан ээмгийг суга татан авч зугатаах үйлдэл нь булаах уу, эсхүл дээрэмдэх үү зэрэг /ЭХ-17.2 /1/, 17.2 /2/.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн зүйлчлэлийг хийхдээ гэмт хэргийн үйлдэгдсэн нөхцөл байдлыг тогтоох, эрүүгийн хуулийн хэм хэмжээг сонгон авах, харьцуулан үзэх /дээрх 2 элемент бүхий үе шатыг/ гэсэн үе шатаар хийнэ.

Ингэхдээ бодитой байх /фактад үндэслэх, нотолгоонд тулгуурлах/, хууль ёсны байх /хуульд үндэслэх, шударга ёсонд тулгуурлах/ шинж шаардлагыг хангасан байх учиртай.

Энэ төрлийн гэмт хэргийн зүйлчлэл нь албан ёсны болон албан ёсны бус төрөлтэй байна. Энэ 2 зүйлчлэлийн төрөл нь хийх субъект, тусгалаа олох эх сурвалж, хууль зүйн үр дагавар зэргээрээ өөр хоорондоо ялгагдана. Албан ёсны зүйлчлэлийг мөрдөгч, прокурор, шүүгч хийдэг бол албан ёсны бус зүйлчлэлийг эдгээрээс бусад субъект, тухайлбал: өмгөөлөгч, багш, оюутан, иргэд ч хийж болно.

Доктор /Sc.D/, проф. С.Жанцан өмгөөлөгчийн зүйлчлэлийг албан ёсны зүйлчлэлд хамаарна гэж үзсэн⁴⁰ бол судлаачийн хувьд эсрэг байр суурьтай байдаг. Учир нь өмгөөлөгч төрийг төлөөлөн эрүүгийн процесс ажиллагаанд оролцдоггүй бөгөөд түүнд хууль хэрэглэх эрх байдаггүй билээ.⁴¹

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн зүйлчлэлийн хувьд өмчлөх эрхэнд хэрхэн халдсан тэр үйлдэл тус бүр /өөрөөр хэлбэл гэмт үйлдэл бүр үйлдлийн илрэх аргаараа хулгайлах, дээрэмдэх, залилах гэх зэргээр/ бие даасан гэмт хэргийн шинжтэй байдгаараа нэн өвөрмөц шинжтэй.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн зүйлчлэл нь гэмт хэргийн өөр хоорондын ялгагдах шинжид тулгуурлаж эрүүгийн хуулийн тусгай ангийн аль зүйл, хэсэгт заасан, ямар гэмт хэргийн шинжтэй болохыг тогтоох оюуны логик үйл ажиллагаа байдгаараа эрүүгийн хуулийг зөв хэрэглэх үндсэн арга нь болж өгнө. Жишээ нь: нэгэн эмээ байрныхаа орцондоо ортол үл таних нэг залуу барьж аваад учиргүй үнсэлцэж байснаа орхиод гарчээ. Эмээ намайг найз бүсгүйтэйгээ андуурлаа гэж бодож, гэртээ ороод толиндоо хартал 2 алтан сүүжин ээмэг нь байхгүй болсон байв. Энэ нь уг залуу үнсэлцэж байхдаа ээмгийг нь мултлан авсан нь тэр аж. Энэ үйлдлийг хэрхэн зүйлчлэх вэ? Үүнд:

- хулгайлах /өөрийн үйлдлийг хэн ч мэдээгүй гэж ойлгодог/,

³⁹ Б.Ганболд. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй дэх гэмт хэрэг зүйлчлэлийн онол. УБ., 2001., 14 дэх тал

⁴⁰ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. I боть. УБ., 2009., 302 дахь тал

⁴¹ Б.Ганболд. Эрүүгийн эрх зүйд нэвтрэхүй. УБ., 2012., 145 дахь тал

- булаах /амь биед аюулгүй хүч хэрэглэж авах/,
- дээрэмдэх /амь биед аюултай хүч хэрэглэж бусдын эд хөрөнгийг авах үйлдэл буюу довтолгоон/.

Зарим төрлийн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүд зүйлчлэлийн хувьд маргаан дагуулдаг ба энэ маргааныг хууль гаргах замаар шийдвэрлэх гэж оролдож ирсэн ч бий. Жишээлбэл, булаах ба дээрэмдэх гэмт хэрэг.

2002 оны Эрүүгийн хуульд хүртэл энэ 2 гэмт хэргийг бие даасан байдлаар 146, 147 гэхчлэн зүйлчлэн зааж ирсэн уламжлалтай. Үүнд:⁴²

- 146 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг булаах /бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр булаасан бол/,

- 147 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх /бусдын эд хөрөнгийг авах зорилгоор амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон бол/.

Шүүхийн практикт булаах, дээрэмдэх гэмт хэргүүдийг ялган зүйлчлэхэд ихээхэн алдаа гардаг учир энэ байдлыг өөрчлөх үүднээс 2015 оны Эрүүгийн хуулиар нэгтгэн зүйлчлэн заасан билээ.

Одоо дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн “дээрэмдэх” гэсэн 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “бусдын эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан бол”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж авахаар довтолсон бол” гэж тус тус заасан нь 2002 оны Эрүүгийн хуулийн 146 дугаар зүйл буюу булаах гэмт хэрэгтэй 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь, харин 17.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь 2002 оны Эрүүгийн хуулийн 147 дугаар зүйлд заасан дээрэмдэх гэмт хэрэгтэй тус тус агуулгын хувьд ижил байгаа болно.

Ийнхүү утга агуулга нь ижил учраас хуулиар нэгтгэсэн ч гэсэн өнөөх “хүч хэрэглэсэн, хүч хэрэглээгүй” гэх маргаан нь тасраагүй бөгөөд булаах, дээрэмдэх гэдэг шигээ л 17.2-р зүйлийн 1 ба, 2-ийн аль уу гэсэн зүйлчлэлийн асуудал үргэлжилсээр л. Энэ байдал эрх зүйн сургалтанд ч хүртэл хэрүүлийн алим тарьсаар. Жишээ нь: бага насны 2 хүүхдийг Олз гэгч хуурч гэрт нь ороод тэднийг ариун цэврийн өрөөнд хийж түгжиж, их хэмжээний эд зүйл гэрээс авч явжээ гэх энэ бодлого хуульчийн сонгон шалгаруулалтын сорилын номонд багтсан байдаг ба анхны зөв хариулт нь Булаалтын гэмт хэрэг.⁴³ Гэтэл шинээр хууль гарсантай холбоотойгоор хариулт нь Дээрэмдэх болсон.

Үүнээс үзвэл “булаах” гэдэг нэрийг л өөрчилсөн болохоос өөр агуулга буюу зарчмын шинжтэй өөрчлөлт шинэчлэл мэдрэгдэхгүй бөгөөд өнөөх булаах, дээрмийн ялгаатай шинж маргаантай байсаар байгааг бодолцох учиртай. Иймд гарах гарцын хувьд хууль хэрэглээг хялбар болгох үүднээс санхүүгийн хувьд ижил зохицуулалтыг зөв интервалдаж хийчихвэл болох мэт. Тухайлбал: бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр болон хүч хэрэглэж авсан бол 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заачихвал булаах, дээрэмдэх гэсэн маргаан хүссэн хүсээгүй гарахгүй, харин санхүүгийн хувьд мэтгэлцээн үүсч хэргийн онцлог, агуулга руу яллах, өмгөөлөх тал илүүтэй орох боломжтой юм.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг ба шударга ёс /бусдын эд хөрөнгийг хулгайлах болон мал хулгайлах гэмт хэргүүдийн харьцуулалт/: Одоо дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулиар өмчийн ба малын хулгайн гэмт хэргүүд бие даасан зүйл ангиар зохицуулагдаж байна. Үүнд дараах 2 тайлбарыг хариу болгон авч үзлээ.

- УИХ-ын гишүүн Н.Батбаяр мал хулгайлах гэмт хэрэг нь ердийн хулгайн гэмт хэрэгтэй харьцуулахад малчныг ажлын байргүй болгож, улмаар амжиргааны гол эх үүсвэргүй, амьдрах боломжгүй болгож байдаг ноцтой хор уршиг бүхий гэмт хэрэг тул Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ын төслийн 17 дугаар бүлэгт "Мал хулгайлах" гэсэн зүйл нэмэх нь зүйтэй гэсэн санал гаргасныг чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул⁴⁴ ийнхүү тусгайлан зүйлчлэгджээ.

⁴² 2002 оны Эрүүгийн хууль Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт хэвлэгдсэн болно.

⁴³ Хуульчдын сорилгын хураамж /4 дэх хэвлэл/. УБ., 2007., 428 дахь тал

⁴⁴ Улсын Их Хурлын 2015 оны намрын ээлжит чуулганы 2015.12.03-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдааны тэмдэглэл.

- 1996 онд малчдын хүсэлт, сонирхлыг харгалзан үзэж Мал хулгайлах гэмт хэргийг өмч хулгайлахаас тусад нь хуульчилж, илүү хүнд ял оногдуулахаар болсон боловч энэ байдал нь иргэд хуулиар адил тэгш хамгаалуулах шударга ёсны /зарчим/ агуулгатай илт зөрчилдсөн учир хүчингүй болгосон юм⁴⁵ гэж доктор /Sc.D/, профессор С.Жанцан жишээ татан өгүүлсэн байдаг.

Судлаачийн хувьд мал хулгайлах гэмт хэргийг өмч хулгайлах гэмт хэрэгтэй нэгэн ижил гэж ойлгодог бөгөөд ингэж ялгамжлах нь шударга бус хэмээн үздэг.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг ба ял: Зарим нэгэн гэмт хэргийг жишээлэн авч үзвэл ялын бодлого дараахь утгатай ажээ, үүнд:

- Эрүүгийн хуулийн 17.1 буюу хулгайлах гэмт хэрэгт 6 сараас 5 жил /17.1 /1/, 2-8 жил /17.1 /2/, 5-12 жил /17.1 /3/ гэсэн хорих ял заасан байна. Үүнээс үзвэл үндсэн, хүндрүүлэх болон онцлон хүндрүүлэх ямар ч шинж /бүрэлдэхүүнтэй/ хулгайлах гэмт хэрэг үйлдсэн бай ялгаагүй 5 жилийн хорих ял шийтгэгдэхээр хуульчлагдсан байна.

- Гэмт хэрэг үйлдсэн хүнийг 6 сараас 20 жил хүртэл хугацаатай хорих ялыг эдлүүлнэ гэж Эрүүгийн хуулийн 5.6-р зүйлийн 3 дахь хэсэгт заасан бол 8.5-р зүйлийн 1 дэх хэсэгт “өсвөр насны хүний эдлэх хорих ялыг 2 дахин багасгана” гэж тус тус заасан. Гэтэл шүүх практикт хулгай хийсэн хүүхдэд “хорих ялын доод хэмжээ 6 сар учир 3 сарын хорих ял оногдуулж болохгүй” гэж үзэж, энэ үндсэн дээр хуулийг механик замаар хэрэглэж байна. Жишээ нь: автоматаар 2 жилийн хорих ял оногдуулж, улмаар 1 жил болгох зэрэг.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тодорхойлолт: /хулгайлах гэмт хэргийн шинж ба үзэл баримтлалын жишээн дээр/. Эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн тухай 2 янзын тодорхойлолт байдаг. Үүнд:

Нэг. Материаллаг /гэмт хэргийн нийгэмд аюултай байдал, гэм буруу, хор уршиг зэргийг тодорхойлон заасан байдаг. Жишээ нь: 2002 оны Эрүүгийн хуулийн 16-р зүйлийн 2 дахь хэсэг ... хэлбэрийн төдий байвал гэмт хэрэгт тооцоггүй гэх зэрэг/.

Хоёр. Формаль /хуулиар гэмт хэрэгт тооцож заасан байх, жишээ нь: 2015.12.03-ны өдрийн шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 2.1-р зүйлийн 1 дэх хэсэг /нэмэлт өөрчлөлт ороогүй хэсэг/.

Дээрх гэмт хэргийн тодорхойлолт хулгайлах гэмт хэргийн хувьд хэрхэн эрүүгийн хуульд тусгалаа олж буйг авч үзвэл:

Жишээ – 1. 2015.012.03-ны өдрийн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1-р зүйлийн 1 дэх хэсэгт “бусдын эд хөрөнгийг хулгайлсан бол” гэж хуульчлан заасан нь формаль гэх тодорхойлолтонд хамаарч байна. Үзэл баримтлал нь хулгайч бол хулгайч. 1 төгрөг ч бай, 1 сая төгрөг ч бай хулгайлсан л бол хулгайч гэж үзэж, яллана гэсэн санаа юм.

Улс төрийн шинэ хүчин /нам, засаг/ солигдож ... өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого хэт сул байгааг дурьдаад ... гэмт хэргийн тодорхойлолтод гэмт хэргийн салшгүй, заавал байх, бусад зөрчлөөс ялгагдах шинж болох нийгэмд аюултай шинжийг хассан нь ямар ч төрлийн зөрчлийг Эрүүгийн хуульд заасан л бол гэмт хэрэг гэж үзэх буруу чиг хандлагыг тогтоосон байх тул Эрүүгийн хуулийн 2.1-р зүйлд “нийгэмд аюултай” гэсэн гэмт хэргийн шинжийг нэмж тусгав.⁴⁶

Ингэхдээ 2002 онд батлагдсан Эрүүгийн хуульд байсан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхгүй гэмт хэрэгт тооцоггүй байх эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг хасч, Эрүүгийн хуулиар урьд өмнө аливаа хууль бус үйлдлийг хохирлын хэмжээгээр нь зааглаж захиргааны зөрчил болон эрүүгийн гэмт хэргийг ялган заагладаг зохицуулалтыг халж хохирлын хэмжээгээр бус нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйн шинж чанараар нь зааглан гэмт хэрэгт тооцохоор заасан нь эрүүгийн эрх зүйгээр хамгаалагдсан эрх ашигт ялимгүй хохирол учруулсан гэмт хэргийн шинжийг “хэлбэрийн” төдий агуулсан бүхий л үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор байгаа нь гэмт хэргийн тоог хиймлээр өсгөх, ялимгүй үйлдлийг ч гэмт хэрэгт тооцон эрүүгийн хэрэг үүсгэн шалгах нөхцөлийг үүсгэсэн байна. Иймд гэмт хэрэг болон зөрчлийг ялгамжтай авч үзэх, гэмт хэргийн зайлшгүй чухал “нийгэмд аюултай” шинж чанараар нь үнэлэх зорилгоор гэмт хэргийн

⁴⁵ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. Боть-1., УБ., 2009., 34 дэх тал.

⁴⁶ Үз. Танилцуулга. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Монгол Улсын Засгийн газар. parliament.mn/law/project/1029/category/1.

шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүйн учир нийгэмд аюулгүй үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй байх зохицуулалтыг Эрүүгийн хуульд нэмэхээр тусгалаа гэжээ.

Жишээ – 2. 2017.05.11-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “энэ /17.1-р/ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний “хохирол” учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй.”⁴⁷ Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэсэн хуульчилсан тайлбар хийсэн нь хулгайлах гэмт хэргийг материаллаг тодорхойлолттой болгож шинжийг нь өөрчлөв. Ингэснээр үзэл баримтлал мөн өөрчлөгдөж “хулгайч бол хулгайч биш”. Хулгайч нар дотроо Зөрчлийн хулгайч. Эрүүгийн хулгайч. Өмд, гутлын хулгайч гэх мэтээр салбарлагдах болсон байна.

Дээрх байдлаас үзвэл хууль зүйн үр дагавар болон хууль хэрэглэх тухайд дараахь асуудал урган гарч байгааг тохиолдлоор жишээлбэл:

Эхний тохиолдолд: А-гийн цүнхнээс 300 мянган төгрөг хулгайлсан /Б/, хоёрдахь тохиолдолд: А-гийн гэрээс 30 мянган төгрөг хулгайлсан /В/ гэж үзвэл Б, В нарын хэн хэн нь хулгайч мөн үү, аль нэг этгээд нь ял шийтгэгдэхгүй үлдэх үү гэсэн асуулт тавьж хариулт ирвэл: В бол хулгайч /Эрүүгийн хуулийн 17.1-р зүйлийн тайлбар/.

Харин Б бол зөрчил гаргагч субъект болж таарах /Зөрчлийн тухай хуулийн 8.6-р зүйл. Хулгайлах. Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна/ агаад Б ийнхүү эрүүгийн хариуцлагаас мултарч байна.⁴⁸

Одоо бид бүхэнд эрүүгийн эрх зүйн онол ба практикийн дахин нэгэн маргаан бий болох нь дамжиггүй боллоо, үүнд:

-Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэсэн Үндсэн хуулийн 14-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэм хэмжээ, зарчимтай нийцэж буй эсэх. Адилхан хулгайч мөртлөө 30 мянган төгрөг хулгайлсан нь эрүүгийн ял шийтгэгдэж байхад 300 мянган төгрөг хулгай хийсэн этгээд сургалтанд суугаад ... дээд тал нь 30 хоног баривчлагдаад захиргааны арга хэмжээнд хамаарч байгааг юу гэх вэ?.

-Эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг үндсэн, хүндрүүлэх, онц хүндрүүлэх зэргээр тайлбарлан хэрэглэж ирсэн байдаг ба үндсэн бүрэлдэхүүний шинжгүй нөхцөлд дараахь хүндрүүлэх болон онцлон хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж бий болохгүй гэсэн үзэл хэвшин тогтсон ойлголт. Гэтэл үндсэн бүрэлдэхүүний шинжгүй байхад /тохиолдол - 1/ шууд хүндрүүлэх бүрэлдэхүүнээр /тохиолдол -2 /ЭХ-17.1 /2/ буюу орон байранд хууль бусаар нэвтэрсэн гэж үзэж/ гэмт хэрэгт тооцох нь хэр зохистой вэ?.

Дүгнэлт, санал

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн зүйлчлэл ба ялын асуудлыг авч үзэж судласны үндсэн дээр судлаачийн хувиар, дараахь дүгнэлт хийж, зарим нэгэн санал дэвшүүлэхийг оролдлоо. Үүнд:

Нэг.Мал хулгайлах, дээрэмдэх гэх зэрэг зарим гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын бодлогыг бусад гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын бодлоготой уялдуулах бус харин ч утгагүй болгосон байх тул хулгайлах /ЭХ-17.1/, мал хулгайлах /ЭХ-17.12/, булаах /17.2 /1/, дээрэмдэх /17.2 /2/ гэмт хэргүүдийн зүйлчлэлийг нэгтгэж, санкцийг зөв томъёолох. Жишээ нь: бусдын эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэхгүйгээр буюу хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж авсан буюу авахаар довтолсон бол 8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хоёр. Хулгайлах гэмт хэрэгт хийсэн УИХ-ын хуульчилсан тайлбар нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх Үндсэн хуулийн эрх болон шударга ёсны зарчимтай илт зөрчилдөж байгаа учир бүхэлд нь эсхүл “2,3 дахь хэсэгт хамаарахгүй” гэсэн хэсгийг нь хүчингүй болгох.

Гурав. Хүүхдэд хорих ялыг эцсийн арга хэмжээ болгож хэрэглэнэ гэсэн олон улсын жишиг хандлага нэвтэрсэн хэдий ч шүүхийн практикт нэг мөр болж чадаагүй байгаа нь хүүхдэд

⁴⁷ УИХ-ын албан хэвлэл. Төрийн мэдээлэл. УБ., 2017.06.07., №21 /978./, 846 дахь тал.

⁴⁸ Үз. Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль. 2017.05.11., ТМ., 2017., №24.

ээлтэй эрүүгийн эрх зүй бүрэлдэн тогтох үндсийг устгаж, тунхаг шинжтэй заалт болон мөнхөрч байна. Иймд энэ заалтыг амь оруулах шаардлагын үүднээс Улсын дээд шүүх “өсвөр насны хүнд хорих ялын доод хэмжээ 6 сар байна гэсэн заалт хамаарахгүй” байх агуулга бүхий шинэ практик буюу казуль тайлбар хийх замаар эрүүгийн хэргийг шийдвэрлэх, эсхүл ийм заалтыг Эрүүгийн хуульд шууд нэмэлтээр оруулах.

Дөрөв. Эрүүгийн эрх зүйд гэмт хэргээс гадна ял буюу санкц гэдэг ойлголт байдгийг бид мартсан бололтой. Үүний тод жишээ нь: хулгайлах гэмт хэрэг 5 жилийн хорих ялтай байна гэсэн дүгнэлт. Эрүүгийн хуулийн 17.2-р зүйлийн 1, 2, 3-ийн аль ч зүйл, хэсгээр зүйлчлэгдсэн бай ялгаагүй 5 жилийн л хорих ял шийтгэгдэхээр байна. Иймд ял үйлдсэн гэмт хэрэгтээ тохирсон байж чадахгүй байгаа бөгөөд тохируулах ч аргагүй учир үйлдсэн гэмт хэрэгтээ тохирсон байх зарчмаас татгалзаж, ял эзнээ олсон, гэмт хэрэгтэнд нөлөө үзүүлэхүйц байхаар оногдуулдаг болох нь зохимжтой гэж үзэж байна.

ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХҮНДРҮҮЛЭХ ШИНЖИЙГ ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН МАРГААНААС ЯЛГАН ЗҮЙЛЧЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

*Ц.Гантулгабат
Баянзүрх дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор,
Хууль цаазын дэд зөвлөх*

1.Үндэслэл

Монгол Улсын Үндсэн хууль⁴⁹ д тодорхойлсон хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэх дээдлэх зорилгын хүрээнд Монгол Улсын иргэн бүрд хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өв залгамжлуулах эрхийг баталгаажуулж улмаар тэрхүү эрхийг нь хангах, хамгаалах үүднээс Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” хэмээн зарлан тунхаглажээ.

Гэвч энэхүү Үндсэн хуулиар хамгаалагдсан иргэний эрх болон түүнийг хамгаалах төрийн үүрэгт хамгийн ихээр харшилж буй өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, тэр дундаа залилах гэмт хэргийн гаралт, түүнээс улбаатай хохирол, хор уршиг сүүлийн жилүүдэд асар хурдацтай нэмэгдэж, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчдийн башир арга барил улам нарийсч буй нь манай улсын эрүүгийн эрх зүйн салбарын нэн тулгамдсан асуудлын нэг яах аргагүй мөн билээ.

Хүн амын өсөлт түүнийг дагаж нийгэм эдийн засгийн даац, хүчин чадал, улс төрийн зохисгүй шийдвэр, төрийн муу бодлогоос үүдэлтэй ажилгүйдэлт, ядуурал, иргэдийн амжиргааны түвшингийн бууралт зэрэг маш олон хүчин зүйлийн улмаас иргэд амар хялбар аргаар мөнгөтэй болох, бусдыг хууран мэхэлж улмаар өөрийн ахуйгаа шийдэх хүсэл эрмэлзэл ихээр бий болж байгаа нь залилах гэмт хэрэг үйлдэгдэх шууд шалтгаант холбоо болж байна.

Залилах гэмт хэргийн үйлдэгдэж буй байдлыг бүртгэгдсэн гэмт хэргийн түвшинд сүүлийн 5 жилийн байдлаар авч үзвэл 2013 оны 1231, 2014 онд 1843, 2015 онд 2067, 2016 онд 2165, 2017 онд 2996 гэмт хэрэг бүртгэгдэж, 2018 оны эхний улирлын байдлаар 10753 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3884 (56.5%)-гаар өсөж, тэр дундаа залилах гэмт хэрэг 1367 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 804-өөр буюу 2.4 дахин нэмэгдсэн⁵⁰ нь энэ төрлийн гэмт хэргийн гаралт хэрхэн нэмэгдэж, түүний нийгмийн хор аюул төдий хэмжээгээр ихэсч байгааг илтгэнэ.

Залилах гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж байгаа байдлыг авч үзвэл 2016 онд 143 хэрэг, 2017 онд 273 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн нь 90.9% өсөлттэй байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн улмаас 2016 онд 137 хүн, 2017 онд 237 хүн ял шийтгүүлж, 2017 онд 37 хүнийг тэнсэн харгалзаж шийдвэрлэсэн нь 73 хувийн өсөлттэй байна. Өөрөөр хэлбэл залилах гэмт хэргийн гаралт, түүнд ял шийтгэгдэж байгаа иргэдийн тоо жил ирэх тусам огцом хурдтайгаар өсөж байна.

Аль ч улсын ямар ч нийгэмд гэмт хэргийн гол уршиг нь хэн нэгний эрх, эрх чөлөөг зөрчиж, хохирол, хор уршиг учруулах замаар тухайн нийгэмд тогтсон зөв зан үйл, дадал зуршил, иргэдийн төрдөө итгэх итгэлээс үүдэлтэй аюулгүй бөгөөд амар амгалан амьдрах бололцоо, бусдын эрхийг хүндлэх сэтгэхүйд хор хөнөөл учруулж байдаг оршино.

Эрүүгийн эрх зүйн онолд гэмт хэргийн нийгмийн хор аюулыг тухайн гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрх, ашиг сонирхол, харилцааны үнэлэмж, гэмт үйлдлийн арга, хэлбэр, ашигласан зэвсэг, хэрэгсэл, түүнийг хэрэглэсэн арга, хувилбар, гэмт хэргийн улмаас учирсан хохирол /гэм хор/⁵¹, гэмт хэрэг үйлдэхэд өдөөсөн гэмт сэдэлт, удирдлага болгосон зорилго, гэм буруугийн хэлбэр, гэмт хэрэг үйлдэж буй этгээдийн хувийн байдал зэргийг харгалзан тодорхойлдог.

⁴⁹ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ., №1

⁵⁰ www.nso.mn. Үндэсний статистикийн газрын нэгтгэн боловсруулсан гэмт хэргийн статистик судалгааны тайлан.

⁵¹ С.Жанцан. БНМАУ-ын эрүүгийн эрх зүйн тусгай ангийг судлах бүдүүвч, тойм. УБ. 1990. 70-71 дэх тал

Залилан мэхлэх гэмт хэргийн нийгмийн хор аюул нь гэмт этгээд бусдын өмчлөх эрхэд тэднийг хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар халдаж, эд хөрөнгө эсхүл түүнийг өмчлөх эрхийг хууль бусаар олж авч байгаагаар тайлбарлагдана.⁵² Тодруулбал, энэ төрлийн гэмт хэрэг нь аливаа иргэний Үндсэн хуулиар баталгаажиг, салбар хуулиар хамгаалагдсан өмчлөх эрхэд шууд халдаж, түүнд хохирол, хор уршиг учруулахын сацуу хүн хүндээ итгэл итгэлцэлийг үгүй хийж улмаар хүйтэн хөндий, хахир төвөгтэй нийгмийг бий болгодоороо хамгийн их хор уршигийг дагуулдаг гэмт явдал билээ.

2.Эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн “Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” 120 дугаар тогтоолын 5 дахь бүлгийн 293 дахь хэсэгт⁵³ “Ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, авлига, албан тушаалын болон шинэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхитай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох” ажлын хүрээнд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлыг төлөвлөсөн нь манай улсын тухайд эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн гол ажлын нэг болсон билээ. Энэхүү ажлын хүрээнд холбогдох хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Эрүүгийн хуулийг баталж, хуулийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөөд эдүгээ 10 дахь сартайгаа бид золгож байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн⁵⁴ 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн 1 дэх заалтад “Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” хэмээн хуульчилсан. Мөн дээрх гэмт хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж, бусдад ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учруулж үйлдсэн, байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон, олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар үйлдсэн, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөл байдал болгохоор тусгажээ.

Дээрх хуулийн зохицуулалтаас үзэхэд залилах гэмт хэргийн үйлдлийн аргыг

1. Хуурах,
2. Баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглах,
3. Зохиомол байдлыг зориудаар бий болгох,
4. Сүсэг бишрэлийг далимдуулах,
5. Бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулах,
6. Нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглах зэргээр тодорхойлж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авах боломжийг хуулиар хязгаарлажээ.

Харин өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан 2002 оны Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд “Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.” хэмээн заасан бөгөөд мөн дээрх гэмт хэргийг үйлдсэн

⁵² Б.Адъяабазар. Монгол Улсад залилан мэхлэх гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тулгамдсан асуудал сэдэвт диссертаци. УБ.2004 он. 64 дэх тал

⁵³ Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн “Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” 120 дугаар тогтоол.

⁵⁴ Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр.

арга хэлбэр, тухайн гэмт хэргийг үйлдсэн субъект, гэмт хэрэг хамтран үйлдсэн байдал, хохирлын хэмжээ зэргийг харгалзан хүндрүүлэх нөхцөл байдал гэж авч үзэхээр хуульчилсан байв.

2002 оны Эрүүгийн хуулиар “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх” гэмт хэрэг үйлдэх арга барилыг “хуурч мэхлэх”, “итгэл эвдэх” гэсэн 2 агуулгаар авч үзэж, Улсын Дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн “Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар”⁵⁵ 51 дүгээр тогтоолын хүрээнд тайлбарлаж, иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчилж байсан.

Харин 2015 оны эрүүгийн хуулиар залилах гэмт хэрэг үйлдэгчийн гэмт хэрэг үйлдсэн арга барилыг илүү дэлгэрэнгүй, тодорхой байдлаар тусгасан нь энэ төрлийн гэмт хэргийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхэд дөхөм болсон байна.

3.Залилах гэмт хэргийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхэд анхаарах асуудал

Залилах гэмт хэргийн гаралт ихээр нэмэгдэхийн хэрээр түүнийг дагаж энэ гэмт хэргийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэх асуудал нь тухайн хуульчаас ихээхэн онолын мэдлэг, хууль хэрэглэх ур чадвар, хууль зүйн техник, хэргийн бодит үнэнг тогтоосон нотолгоо баримт шаардсан нарийн төвөгтэй ажил болоод байна. Академич С.Нарангэрэл “Гэмт хэргийг зүйлчлэх ойлголт нь тодорхой гэмт хэргийн шинж эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжтэй нийцэн тохирч байгааг тогтоох логик үйл ажиллагаа бөгөөд тодорхой этгээдийн үйлдсэн нийгэмд аюултай хэрэгт өгч байгаа эрх зүйн үнэлэлт”⁵⁶ гэсэн утгаар ойлгох нь зүйтэйг тэмдэглэсэн байна.

Практикт залилах гэмт хэргийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхэд онол, арга зүйн болоод хууль хэрэглээний бэрхшээл тулгарч Цагдаагийн байгууллага гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг хүлээн авах, иргэний хэргийн анхан шатны шүүх нэхэмжлэл хүлээн авах зэрэгт дээрх 2 салбар эрх зүйн алинд нь хамаарч хэрэг маргааны эцэслэн шийдвэрлэх ёстойг ялган зааглахад багагүй хүндрэл учирдаг.

Бусдын эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг заль хэрэглэх байдлаар өөртөө шилжүүлэн авч буй үндсэн хэлбэр нь эрүүгийн залилах гэмт хэрэг болоод иргэний эрх зүйн гэрээнээс үүдэлтэй маргааны аль алинд нь илэрдэг. Өөрөөр хэлбэл иргэний эрх зүйн ч бай эрүүгийн эрх зүйн ч бай аль ч тохиолдолд бусдын эд хөрөнгө өмчлөх эрх нь ямар нэг байдлаар хөндөгдөж, түүнийг сэргээх, хамгаалах шаардлага зүй ёсоор урган гарч ирдэгээс үзвэл ялган зааглахад хүндрэлтэй байдгийн учир шалтгаан эндээс эхлэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэн өмчтэй байх, түүнийг эзэмших, захиран зарцуулах, хувь заяаг нь шийдэх эрхийг иргэндээ өгч, төр тэрхүү эрхийг нь хамгаалах үүргийг төрд хүлээлгэсэн бөгөөд Иргэний хуулиар⁵⁷ ч энэхүү харилцааг нарийвчлан зохицуулжээ.

Иргэний хуулийн 101 дүгээр зүйлд “Өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр хуулиар тогтоосон хэмжээ хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаа хамгаалах эрхтэй” гэж заажээ. Өөрөөр хэлбэл өмч гэдэг нь материаллаг болон материаллаг бус хөрөнгийг хамгийн өргөн цар хүрээнд эрхшээлдээ байлгах эрх юм. Хуулиар энэхүү туйлын эрхийг позитив болон негатив байдлаар зохицуулжээ.

Зэрэг: Өмчлөгч нь өөрийн материаллаг болон материаллаг бус хөрөнгөө чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй байна.

Сөрөг: Өмчлөгч нь өөрийн хөрөнгийг аливаа этгээдээс хамгаалах, хэн нэгэн өөр этгээд хөрөнгийг нь ашиглахыг таслан зогсоох эрхтэй байна.⁵⁸

⁵⁵ Улсын Дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн “Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар”⁵⁵ 51 дүгээр тогтоол

⁵⁶ С.Нарангэрэл. Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс /онол, практик/. УБ. 1988. 7 дахь тал

⁵⁷ Монгол Улсын Иргэний хууль. 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр. Төрийн мэдээлэл, 2002 он, №7

⁵⁸ Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. УБ. 2010 он. 176 дахь тал

Мөн доктор /ScD/, профессор Г.Совд “Өмч бол нийгмийн үйлдвэрлэл явуулж, материал баялгийг ашиглах, захиран зарцуулахад чиглэгдсэн хүмүүсийн хоорондын харилцаа” гэж тодорхойлсон байна.

Өмнө дурдсанчлан залилах гэмт хэргийн тухайд ч, иргэний эрх зүйн гэрээнээс үүссэн маргааны тухайд ч бусдын өмчлөх эрх зөрчигддөг хэдий ч залилах гэмт хэргийн үед гэмт этгээд бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг эзэмших эрхийг хууль бусаар олж авахаас өмнө хохирогчийг хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж, энэхүү үйлдлээ шунахайн сэдэлтээр анхнаасаа зориуд хэрэгжүүлдэг нь иргэний эрх зүйн маргаанаас ялгах гол нөхцөл юм.

Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг эзэмших, өмчлөх эрхийг буцааж өгөхгүй, хариу төлбөр огт хийхгүй, эсхүл хагасыг нь хийнэ гэсэн субъектив санаа зорилго гэмт этгээдийн хувьд гэмт үйлдлээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө бий болсон байдгаараа залилан мэхлэх гэмт хэрэг нь гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгагдана.⁵⁹ Иргэний эрх зүйн маргаан нь талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хүндэтгэн үзэх шалтгааны улмаас биелүүлээгүй байдаг бөгөөд нэхэмжлэгчийг хуурч мэхлэх, итгэл эвдсэний үндсэн дээр түүний эд хөрөнгө, эсхүл түүнийг эзэмших эрхийг нь хууль бусаар олж авах гэсэн шунахайн санаа зорилго байдаггүй. Харин тухайн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломж, цаг хугацаа олдсон даруйд тэрхүү үүргээ биелүүлэх хүсэл эрмэлзэлтэй байдгаараа залилах гэмт хэргээс ялгагдаж байдаг.

Иргэний хуулийн 56, 57, 58, 59, 60 дугаар зүйл заасан зохицуулалт нь тухайн тохиолдолд иргэний эрх зүйн гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэл болохоос биш залилах гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал ерөөсөө биш гэж үзэхээр байна. Ялангуяа практикт түгээмэл тохиолддог иргэний эрх зүйн харилцаанд үүсдэг хууран мэхэлж хийсэн хэлцлийн тухайд Иргэний хуулийн 59-р зүйлийн 59.1-д “Хэлцэл хийх зорилгоор бусдыг хууран мэхэлсэн бол мэхлэгдсэн этгээд уг хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шаардах эрхтэй. Энэ тохиолдолд хууран мэхэлсэн этгээд ашиг хонжоо олох, эсхүл мэхлэгдсэн этгээдэд гэм хор учруулах зорилготой байсан эсэх нь хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцоход нөлөөлөхгүй.” гэж заасан бөгөөд дээрх хуулийн зохицуулалтаас авч үзвэл хууран мэхэлж гэрээ байгуулагдсан байх нь тэрхүү үүссэн харилцааг эрүүгийн залилах гэмт хэргээр шалгах боломжийг огтоос хязгаарлахгүй бөгөөд гагцхүү тухайн гэрээг хүчин төгөлдөр бус болгох л хууль зүйн үндэслэл юм. Өөрөөр хэлбэл хууран мэхлэгч этгээд ашиг хонжоо олох, баяжих, эсхүл мэхлэгдсэн этгээдийн өмчид гэм хор учруулах зорилготой байсан эсэх нь онцын ач холбогдолгүй. 59-р зүйл нь хохирогчийн өмчийг бус харин хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөг хамгаалдаг. Энэ нь залилангийн гэмт хэргээс ялгагдах чухал мөн чанар болно.⁶⁰

Хууран мэхлэгдсэн этгээд хууран мэхлэгчийн субъектив санаа зорилго болоод хэрэглэсэн шунахайн арга барилд нь нийгмийн хор аюул илэрсэн гэж үзвэл эрүүгийн журмаар шалган шийдвэрлүүлэх эрхтэй бөгөөд хууран мэхэлсэн этгээдэд ч шүүх эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй юм. Нөгөө талаасаа хууран мэхэлж хийсэн гэрээг хүчингүй болгуулахаар сонирхогч этгээд нэхэмжлэл гаргаж гэрээг хүчин төгөлдөр болгуулах эрхтэй бөгөөд энэ нь тухайн хууран мэхэлсэн үйлдлийг эрүүгийн залилах гэмт хэргээр шалгуулах хэн нэгний эрхийг зөрчихгүй гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна. Өөрөөр хэлбэл залилах гэмт хэрэг болоод иргэний эрх зүйн хууран мэхэлсэн гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл хэмээх 2 ойлголт нь харилцан нэг нэгнээ хаацайлах, үгүйсгэх үндэслэл огтоос биш бөгөөд залилах гэмт хэрэг шалгах нь тухайн харилцааны нийгмийн хор аюулыг тогтоох, харин иргэний журмаар гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох нь иргэд хоорондын гэрээг чөлөөтэй байгуулах, харилцан ашигтай гэрээг байгуулах, гэрээнээс 2 тал үр өгөөжөө хүртэж байх зэрэг эрхийг хамгаалахад чиглэгдсэн байна.

⁵⁹ Улсын Дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн “Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар” 51 дүгээр тогтоол

⁶⁰ Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. УБ. 2010 он. 110 дахь тал

Гэрээний харилцаа нь Иргэний хууль тогтоомжийн дагуу үүсч, гэрээний биелэлтийн талаар мэдээлэл солилцож, харилцан гомдлын шаардлага гаргаж, гэрээгээ дүгнэж байсны эцэст эрсдэлд орсны улмаас үүссэн маргааныг, өөрөөр хэлбэл, гэрээний эрсдэлийг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй. Харин гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг бүгдийг буюу заримыг шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго төрж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх, тодорхой үйлдэл хийсэн нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад тогтоогдвол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.⁶¹ Практикт иргэд хоорондын гэрээнээс үүссэн харилцааны явцад гэрээний нэг тал нь хүлээсэн үүргээ биелүүлэх хөрөнгө, санхүүгийн болон үүрэг хариуцлагын хувьд боломжгүй болсон хэдий ийнхүү нөхцөл байдлаа нуун дарагдуулах, бодит байдлаа үгүйсгэх, цаашид гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх ямар ч боломжгүй болсон хэдий ч биелүүлж чадна гэж хоосон таамаглах, нөгөө талд худал нөхцөл байдлыг бий болгон ярьж итгүүлэн үнэмшүүлэх, төөрөгдүүлэх, нэмж шунахайн сэдэлтээр эд хөрөнгө түүний эрхийг өөртөө шилжүүлэн авах явдал нэн түгээмэл болж байна.

Зарим тохиолдолд иргэний эрх зүйн гэрээний харилцаа үүсэж, тэрхүү харилцаанаас хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад буюу тухайн иргэний эрх зүйн харилцаа, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдал бий болонгуут залилах луйврын санаа зорилго төрж бусдыг зориуд хохироох гэмт шунахайн зорилго бий болж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээнээс үүдэлтэй маргаанаас ялган зүйлчлэхэд төвөгтэй байдлыг үүсгэдэг. Энэ төрлийн маргааныг хянаж шийдвэрлэхдээ гэрээ, хэлцэл эхэлж хэрхэн хийгдсэнээс хамаарахгүйгээр гэмт этгээд чухам хэдий үеэс залилах гэмт хэргийн санаа зорилго төрж, шунахайн үйлдлээ хэрхэн хэрэгжүүлсэн байдлыг зөв тогтоох нь дээрх асуудлыг ялган зааглаж, шийдвэрлэхэд дөхөм болно. Жишээлбэл, Төрийн байгууллагад ажилладаг иргэн А байгууллагын барьж буй ажилтнуудын орон сууцнаас өөрийн нэр дээр 2 өрөө байр авах бодит боломжтой болж захиалга өгсөн бөгөөд тэрхүү байраа худалдахаар иргэн Т-тэй худалдах худалдан авах гэрээг байгуулсан байна. Гэрээний дагуу нэг талаас орон сууц ашиглалтад ороход Т-д хүлээлгэж өгөх нөгөө талаас хэлэлцэн тохирсон байрны үнийг төлөх үүргийг талууд хүлээжээ. Гэрээний дагуу Т нь байрны урьдчилгааг төлсөн бөгөөд тогтоосон хугацаанд А нь орон сууц хүлээлгэн өгөх байсан боловч хэсэг хугацааны дараа байгууллагын орон сууцны захиалгаас иргэн А нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хасагдсан байна. Гэтэл иргэн А иргэн Т-н өгсөн урьдчилгаа мөнгийг ахуйдаа зарцуулж үрж дуусгасан байсан бөгөөд нэмж өөрөө банкинд өртэй байсан тул иргэн Т-гээс “байр удахгүй ашиглалтад орох гэж байна”, “нэмээд 10 сая төгрөг өгчихвөл 3 өрөө болгох боломжтой боллоо” гэх мэтээр худал хэлж, төөрөгдүүлэн үргэлжлүүлэн мөнгө авсаар иргэн А-г хохироосон.” бодит хэрэг практикт нэг биш удаа гарч байсан. Дээрх тохиолдолд талуудын хооронд иргэний эрх зүйн харилцаа анх үүсэж, иргэн А анх залилах шунахайн сэдэлт, зорилгогүй байсан боловч гэрээ биелэгдэх явц дунд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох үед тэрхүү боломжгүй байдлаа нөгөө талаасаа нуун дарагдуулах, цаашид биелэгдэх боломжтой мэтээр хуурч мэхэлсэн нь залилах гэмт хэргийн шинжийг бүрэн хангаж байна. Дээрх нөхцөл байдлыг тогтоохдоо нотлох баримтыг бүрэн цуглуулж, тухайн нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдэгчийн хувийн байдал, гэмт хэрэгтээ хандсан сэтгэлзүйн байдлыг хөдөлбөргүй тогтоох шаардлагатай.

Залилах гэмт хэргийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхдээ дээрх 2 харилцааны төсөөтэй бөгөөд ялгаатай талыг эрх зүйн онол, хууль хэрэглэх ур чадварын түвшинд нарийн тодорхой зааглан мэдсэн байх нь хэргийг шийдвэрлэхэд нэн чухал ач холбогдолтой билээ.

Залилах гэмт хэрэг ба иргэний эрх зүйн гэрээнээс үүссэн маргааны төсөөтэй болон ялгаатай талын тухайд:

⁶¹ Улсын Дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн “Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар” 51 дүгээр тогтоол

Төсөөтэй тал:

1. Бусдын Үндсэн хууль болон салбар хуулиар хамгаалагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг өмчлөх эрхийг хөндөж, хохирол, хор уршиг учруулдаг,
2. Хуурах, итгэл эвдэх гэсэн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрдэг,
3. Зарим тохиолдолд харилцан үүрэг хүлээх хэлцэл байгуулагдсан байдаг,
4. Өмчлөх эрх хууль бусаар бусдад шилжсэн байдаг.

Ялгаатай тал:

1. Иргэний эрх зүйн маргаан нь нийгмийн хор аюул яригддаггүй бөгөөд залилах гэмт хэргийн тухайд нийгэмд учруулж буй хор аюул нь их байдаг,
2. Залилах гэмт хэргийн хуурч, болон итгэл эвдэх үйлдэл нь илт шунахайн шинжтэй байдаг. Иргэний эрх зүйн харилцаа нь харилцан үүрэг хүлээж, тухайн гэрээний биелэлт, явц байдлын талаар мэдээлэл солилцож, харилцан шаардлага тавьж, гэрээний үр дүнг дүгнэж байсны эцэст эрсдэлд орсны улмаас үүссэн маргаан байдаг онцлогтой.
3. Залилах гэмт хэрэг үйлдэгч нь анхнаасаа болон явц дунд шунахай сэдэлт төрсний үндсэн дээр бусдыг залилах, башир хуурмаг арга хэрэглэх замаар бусдад хохирол, хор уршиг учруулдаг бол иргэний эрх зүйн гэрээний маргаан нь хөндлөнгийн нөхцөл байдлаас болж гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсдэгээрээ ялгагдана.

Ялангуяа манай улсад түгээмэл үйлдэгддэг зээлийн гэрээнээс үүдэлтэй залилах гэмт хэргийн тухайд тухайн зээлийг буцаан төлөх бодит боломжгүй, барьцаа хөрөнгөгүй, барьцаа хөрөнгө байгаа хэдий тэрхүү хөрөнгө нь эрхийн зөрчилтэй, мөн эргүүлэн төлөх гэсэн чин эрмэлзэл санаа зорилго анхнаасаа байхгүй харин хууран мэхэлж, итгэл эвдэж амар хялбар аргаар мөнгөтэй болох атгаг башир шунахайн сэдэлттэй байдгаараа иргэний эрх зүйн харилцаанаас мөн ялгагдаж байдаг.

Гэтэл иргэний эрх зүйн гэрээний хувьд аль нэг талд дээрх гэмт санаа бодол төрөөгүй байдаг бөгөөд хөрөнгө, санхүүгийн болоод бусад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжтой нөхцөл бүрдсэн үед гэрээний нөгөө талаа хохиролгүй болгох хүсэл эрмэлзлэлтэй байдаг. Мөн гэрээ нь аль аль талуудын сайн дурын үндсэн дээр, эрх тэгш, чөлөөтэй байгуулснаар хүсэл зориг, ашиг сонирхол нь хангагдаж, эрх үүрэг, үр дагавар үүсч байдаг⁶². Иргэний эрх зүйн гэрээнээс үүссэн харилцааны явцад бий болсон эрсдэл буюу байгалийн давагдашгүй хүч, нийгэм эдийн засгийн харилцааны зохицуулалтын өөрчлөлт, гэнэтийн осол, өвчин эмгэг, хорио цээр зэрэг талуудаа үл шалтгаалах хүчин зүйл буюу нөхцөл байдал урьдчилан тооцоолох боломжгүйгээр гэнэт өөрчлөгдсөний улмаас гэрээний үүрэг биелэгдээгүйг залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэхгүй⁶³, ялангуяа урдчилан тооцоолох боломжгүйгээр нөхцөл байдал гэнэт өөрчлөгдсөний улмаас гэрээний үүрэг биелэгдээгүй эсэхийг мөрдөгч, прокурор, шүүгч хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой шалгасны үндсэн дээр тогтоох ёстой.

Мөн залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэхдээ иргэний гэрээ, хэлцлийг ашиглах явдал нь дээрх гэмт хэргийн нэг арга барил болсон нь хууль ёсны мэт харагддаг нуугдмал байдлыг бий болгож байна. Гэвч бодит байдалд гэмт этгээд хохирогчийн эд хөрөнгө, түүнийг эзэмших эрхийг буцааж өгөлгүй, үнэ төлбөргүй авах гэсэн санаа, зорилгыг анхнаасаа агуулсан байдаг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад түүнийг бүрэн тогтоож чаддаггүй зэрэг төвөгтэй байдал ихээр бий болдог. Залилан мэхлэх гэмт хэргийн субъектив гол шинж буюу гэмт этгээдээс гаргаж буй санаа зорилгыг хөдөлбөргүй тогтоох нь онцгой чухал. Энэхүү нөхцөл байдлыг тогтоохдоо ялангуяа хохирогчийн итгэл үнэмшлийг олж авсан арга, гэмт этгээдийн амласан, болзол болгосон зүйл, ажил үйлчилгээ нь бодит байдал дээр биелэгдэх, хэрэгжих боломжтой эсэх, тохиолдлын чанартай бэрхшээл тулгарсан нь үнэн эсэх, уг этгээд урьд нь тухайн төрлийн болон өөр төрлийн гэмт хэрэг үйлдэж байсан эсэхийг тогтоох шаардлагатай⁶⁴.

⁶² Ц.Цолмон “Гэрээний эрх зүй”. УБ. 2009 он

⁶³ Б.Галдаа “Монгол Улсын Эрүүгийн хууль ба гэмт хэргийн зүйлчлэл”. УБ. 2012 он. 142 дахь тал

⁶⁴ “Криминалистикийн тактик” ред. Ж.Болдбаатар, УБ. 2001 он. 252 дахь тал

Дараагийн дугаарт, Иргэний хуулийн 56.1.1-т “Хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцэл”-ийг хүчин төгөлдөр бус байхаар тодорхойлсон. Дээрх харшилсан хэлцлийг хийж байгаа нь өөрөө залилах гэмт хэргийн шинжийг бий болдог. Энэхүү зохицуулалт нь иргэний эрх зүйн гэрээнээс үүдэлтэй маргааныг зохицуулдаг боловч хууль тогтоогчийн зүгээс хүчин төгөлдөр бусад тооцох үндэслэлд оруулсан байгаагаас үзвэл өмнө дурдсанчлан эл зохицуулалт нь гагцхүү иргэний гэрээг цуцлах буюу гэрээнд оролцогч талын хүсэл зоригийн илэрхийллийг хамгаалах үндэслэл болохоос биш залилах гэмт хэргийг үгүйсгэх, зөвхөн иргэний журмаар хэргийг хянан шийдвэрлэх ёстой гэсэн шийдэл хэрхэвч биш болох нь давхар нотлогдоно.

4.Санал, дүгнэлт

Судлаачид гэмт явдлыг аль улсын ямар ч нийгэмд байдаг нийгмийн үзэгдэл гэж үздэг. Гагцхүү тэрхүү үзэгдлийг аль болох бага түвшинд байлгах, гэмт хэрэг үйлдэгчийг нээн илрүүлэх, түүнийг нийгэмшүүлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, эрх ашгийг нөхөн төлүүлэх, сэргээх, цаашид гэмт зан үйл хийхэд саад учруулах, тухайн бодгаль хүнийг гэмт хэрэг үйлдэхээс татгалзах сэтгэхүйн төлөвшлийг бий болгох нь төрийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн бодлого байх учиртай. Хүний гэмт зан үйл бүрийг Эрүүгийн хуульд нэг бүрчлэн тусгах боломжгүй учраас практикт янз бүрийн арга, үйлдлийн хэлбэрээр үйлдэгдсэн аливаа хэргийг зөв оновчтой зүйлчлэх шаардлага тулгардаг.

Энэ нь Эрүүгийн хуулийн холбогдох хэм хэмжээг зөв ойлгож хэрэглэхээс эхэлдэг ба хууль эрх зүйн хэм хэмжээг практикт зөв хэрэглэх хууль нэг мөр хэрэгжих, хууль ёс нийгэмд дээдлэгдэх, улмаар хууль хүчтэйгээр биелэгдэх үндэс болдог.

Практикт залилах гэмт хэргийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэх тухай асуудал нэн тулгамдсан асуудал бөгөөд ихэвчлэн мөрдөгч, прокурорын үзэмжээр хэрэг бүртгэлийн хэрэг нээх болон хэрэг бүртгэлийн хэргийг хааж шийдвэрлэж байна. Ялангуяа гэрээгээр халхавчилсан залилах үйлдэл байхад цагдаагийн байгууллагаас гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл хүлээн авч бүртгэхдээ гэрээ байгуулсан л бол гэмт хэргийн шинжгүй иргэний журмаар шийдвэрлүүлэх маргаан байна хэмээн тухайн иргэдийн гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авахаас цааргалж, шалгахаас аль болох татгалзах эрсдэлтэй байгаа нь энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдэх гол шалтгааны нэг болж байна.

Мөн хохирогчийн зүгээс иргэний эрх зүйн харилцаанаас үүдэлтэй маргааныг цагдаагийн байгууллагаар шалгаж шийдвэрлүүлэх сонирхол ихтэй байдгаас энэ төрлийн маргаан иргэний журмаар шийдвэрлэгдэхгүй цагдаагийн байгууллагад ачаалал болж шалгагдаж байгаа нь ажиглагдаж байна. Учир нь иргэдийн дунд цагдаагийн байгууллагад шалгагдах нь айдас бий болгодог тул тухайн хэрэг маргааныг хурдан шийдвэрлүүлэх хөшүүрэг болдог. Мөн иргэний журмаар тухайн маргааныг шийдвэрлүүлэх боломжтой талаар иргэдийн мэдлэг хомс, мөн иргэний журмаар хэргийг хянан шийдвэрлүүлэхэд улсын тэмдэгтийн хураамж төлдөг, иргэний хэргийн шүүх асуудлыг шуурхай шийдвэрлэж чаддаггүй, жил тойрон сунжирдаг, иргэний хэргийн шүүхийн шийдвэр биелэгдэх чадвар муутай, ихэвчлэн хоосон шийдвэртэй хоцордог зэрэг байдал нөлөөлдөг.

Практикт иргэд бие биенээ залилах, мэхлэх, луйвардах үйлдэл ихээр нэмэгдэж байгаа хэдий ч иргэний эрх зүйн гэрээнээс үүдэлтэй маргаанаас ялган зүйлчлэхэд нэгдмэл ойлголт байдаггүй, шууд нарийн тогтоож ялган зааглах боломжгүй, заавал шалгаж тогтоох шаардлагатай байдаг зэрэг нь энэ төрлийн гэмт хэргийг иргэний эрх зүйн маргаанаас ялган зүйлчлэхэд ихээхэн саад бэрхшээл тулгарч байна.

Мөн практикт түгээмэл тохиолддог асуудал болох аливаа маргааныг нэг бол эрүүгийн журмаар нэг бол иргэний журмаар л шийдэгдэн гэж ханддаг нь буруу хэвшил юм. Иргэний эрх зүйн хууран мэхэлсэн гэрээ нь үүссэн харилцааг эрүүгийн залилах гэмт хэргээр шалгах боломжийг огтоос хязгаарлахгүй бөгөөд гагцхүү тухайн гэрээг хүчин төгөлдөр бус болгох л хууль зүйн үндэслэл юм. Энэ тохиолдолд хууран мэхлэгдсэн этгээд эрүүгийн журмаар шалган шийдвэрлүүлэх эрхтэй бөгөөд хууран мэхэлсэн этгээдийн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй. Нөгөө талаасаа хууран мэхэлж хийсэн гэрээг хүчингүй болгуулахаар

сонирхогч этгээд нэхэмжлэл гаргаж гэрээг хүчин төгөлдөр болгуулах эрхтэй бөгөөд энэ нь тухайн хууран мэхэлсэн үйлдлийг эрүүгийн залилах гэмт хэргээр шалгуулах хэн нэгний эрхийг хаахгүй гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна. Өөрөөр хэлбэл залилах гэмт хэргийн болоод иргэний эрх зүйн хууран мэхэлсэн гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл хэмээх 2 ойлголт нь харилцан нэг нэгнээ хаацайлах, үгүйсгэх үндэслэл огтоос биш бөгөөд залилах гэмт хэрэг шалгах нь тухайн харилцааны нийгмийн хор аюулыг тогтоох, иргэний журмаар гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох нь иргэний гэрээг чөлөөтэй байгуулах, харилцан ашигтай гэрээг байгуулах, гэрээнээс 2 тал үр өгөөжөө хүртэж байх зэрэг эрхийг хамгаалахад чиглэгдсэн байна. Иймд хэрэг бүртгэлтийн хэргийг иргэний журмаар хянан шийдвэрлэх маргаан байна гэж хаах, иргэний хэргийг зөвхөн нэхэмжлэлийг хангах байдлаар шийдвэрлэх нь учир дутагдалтай бөгөөд харин тухайн үйлдэлд нь залилах, луйвардах гэх мэт нийгэмд аюултай үйлдэл эс үйлдэхүй байгаа эсэхийг нарийн шалгаж тогтооход анхаарах шаардлагатай байна.

Ашигласан эх сурвалж:

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль.
- Монгол Улсын Эрүүгийн хууль. 2002 он
- Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. 2015 он
- Монгол Улсын Иргэний хууль. 2002 он.
- Монгол Улсын Дээд шүүхийн 51 дүгээр тогтоол. “Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар”. 2006 он.
- Монгол Улсын Засгийн газрын 120 дугаар тогтоол. “Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” 2012 он.

Ном, сэтгүүл:

- Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. 2010 он
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016. 2017 он
- Залилан мэхлэх гэмт хэрэг. Сургалтын гарын авлага. 2008 он
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг. Сургалтын гарын авлага. 2008 он
- Д.Адъяабазар. Монгол Улсад залилан мэхлэх гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тулгамдсан асуудал сэдэвт диссертаци. 2004 он
- С.Жанцан. БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн тусгай ангийг судлах бүдүүвч, тойм. 1990 он.
- С.Нарангэрэл. “Гэмт хэрэг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс”. 1988 он.
- Ц.Цолмон “Гэрээний эрх зүй”. 2009 он
- Б.Галдаа “Монгол Улсын Эрүүгийн хууль ба гэмт хэргийн зүйлчлэл”. 2012 он.
- Ж.Болдбаатар. “Криминалистикийн тактик”. 2001 он

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙГ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Т.Мөнхдалай

Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн ахлах багш

Б.Досжан

Мөн сургуулийн багш

Товч агуулга. Монгол улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцож шинэчлэн найруулсан 2015 оны эрүүгийн хуулиндаа тусган хуульчилсан ба уг хуулийн мөнгө угаах гэсэн зүйл заалтыг зөв хэрэглэх нь хууль ёс, шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болох бөгөөд энэ нь нь хүний эрх, эрх чөлөөг хангахад онолын болон практикийн чухал ач холбогдолтой асуудал болно.

Түлхүүр үг. Бохир мөнгө, мөнгө угаах гэмт хэрэг

Даяаршиж буй нийгэмд дэлхийн улс орнууд жижиг хот улсын зохион байгуулалтанд орж улмаар тусгаар улсуудын ёс заншил, соёл, эдийн засаг, улсын хилийн халдашгүй байдал зэрэг ойлголт аажмаар нэгдэн нийлэх хандлагыг бий болгосон.

Улс орны нийгэм соёлын амьдралын бүхий л хүрээнд либерал үзэл суртал хөндөгдөж техник, технологийн хөгжил дэвшил хурдацтай явагдснаар нийгэм эдийн засаг, соёл боловсрол, шинжлэх ухаан технологийн үйл ажиллагаа нь хил хязгаарыг үл харгалзан шинэчлэгдэн өөрчлөгдөж байна.

Сайн сайхан хөгжил дэвшилтэй зэрэгцэн гэмт хэрэг үйлдэгдэх арга, хэлбэр гэмт хэргийн нөхцөл байдал мөн өөрчлөгдөн хөгжиж байна. Тухайлбал зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд орлого эдийн засгийн чадавхиа дээшлүүлэх зорилгоор хилийн чанад дахь ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гэмт бүлэглэлүүдтэй холбоо харилцаа тогтоон, хууль бус зэвсгийн, түүхийн үнэт олдворын, хүний эд, эрхтний наймаа, хүн худалдаалах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт хийх зэрэг гэмт хэргийг үйлдэн бохир мөнгө, орлогыг ихээр бий болгох болсон.

Амар хялбар аргаар их хэмжээний мөнгө олохыг зорилгоо болгосон гэмт бүлэглэлүүд нэгдэн тодорхой зохион байгуулалтанд орж бохир мөнгийг ихээр олох буюу мөнгө угааж эхэлсэн.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэл нь дээр дурдсан гэмт хэргийг үйлдэж бий болгосон мөнгөн хөрөнгө буюу бохир мөнгийг хууль ёсны үндсэн дээр бий болсон орлого мэт харуулахын тулд эдийн засгийн тодорхой эргэлтэнд оруулдаг. Өөрөөр хэлбэл гэмт этгээд гэмт хэрэг үйлдэх замаар бий болгосон эд хөрөнгө, мөнгөн хөрөнгийг ашиглах, хэрэглэхдээ уг хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдалж тухайн мөнгөн хөрөнгийг хууль ёсны эх үүсвэртэй мэт харагдуулахыг гол зорилгоо болгодог.

Мөнгө угаах үйл ажиллагаа нь гол төлөв олон улсын хүрээнд үйлдэгддэг тул уг гэмт хэрэгтэй хийх тэмцэлд улс орнуудын хамтын шуурхай ажиллагаа чухал бөгөөд уг үйл ажиллагааг зохицуулсан гэрээ конвенцуудыг батлан гаргаж мөрдөн ажиллах зайлшгүй шаардлагатай.

Одоогийн байдлаар олон улсад мөнгө угаах гэмт хэргийн 180 төрөл⁶⁵ бүртгэгдээд байгаа бөгөөд энэ хэргийн улмаас дэлхий дээр бий болсон бохир мөнгөний эргэлт 2 их наяд доллар байх магадлалтай гэсэн таамаг байдаг ба энэ нь Франц улсын жилийн төсвөөс 3 дахин их тоо юм. АНУ-д жилд дунджаар 500 тэрбум доллар⁶⁶ угаагддаг байна.

Уг сэдвийг сонгох судлах болсон гол үндэслэл нь гадаадын зарим улс оронд мөнгө угаах гэмт хэргийн шинжийг хэрхэн тодорхойлж үздэг, гэмт хэрэг үйлдсэн хүнд хүлээлгэж буй эрүүгийн хариуцлагыг судлах, мөн түүнчлэн 2015 оны Монгол Улсын эрүүгийн хуулинд дээрхи гэмт хэргийн шинжийг хэрхэн хуульчилсан, түүнд хүлээлгэх ял, хариуцлагын асуудлыг харьцуулан үзэхийг эрмэлзсэн болно.

⁶⁵ Syleyman Aydın. Karapara Aklama İle Mьcadelede Uluslararası Boyut Suzu. Ankara. 2008 он. 2-р тал.

⁶⁶ Syleyman Aydın. Karapara Aklama İle Mьcadelede Uluslararası Boyut Suzu. Ankara. 2008 он. 2-р тал

Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг тодорхойлон тайлбарлахын өмнө бохир мөнгө гэж юу болох тухай ойлголтыг эхлэн авч үзэх нь зүйтэй.

Олон улсын хүрээнд мөнгөн тэмдэгтийг өнгөнийх нь хувьд хар мөнгө буюу бохир мөнгө, саарал мөнгө, цагаан мөнгө буюу цэвэр мөнгө гэж ангилдаг байна.

Хууль зүйн хүрээнд эдийн засгийн үйл ажиллагааг хэрэгжүүлж татварын байгууллагад тодорхой хэсэг нь татвар болон суутгагдсан орлого, мөнгийг цагаан мөнгө буюу цэвэр мөнгө гэдэг бол эдийн засгийн бүхий л үйл ажиллагааг явуулж олсон орлого нь татварын байгууллагад тодорхой хэмжээг нь суутгалгүйгээр татвараас зайлсхийсэн тохиолдолд саарал мөнгө гэсэн ойлголт бий болдог.

Харин хар мөнгө буюу бохир мөнгө нь хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн үндсэн дээр бий болсон орлого мөнгөн хөрөнгө ба энэ нь татварын байгууллагад тодорхой хэмжээ нь суутгагдаагүй байдаг⁶⁷ байна.

Улс орон бүрт бохир мөнгөтэй холбоотой ойлголт, тодорхойлолт байдаг хэдий ч мөнгө угаах гэмт хэргийн шинжийн талаар нэгдсэн нэг тодорхойлолт байхгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд хүндрэл учруулж байдаг.

Бохир мөнгө хэмээх ойлголтыг нийгэм, эдийн засаг, ёс суртахуун, хууль зүйн гэх мэт олон салбарын хүрээнд тодорхойлон авч үзэж болох боловч бидний зүгээс хууль зүйн хувьд тодорхойлон харьцуулан судлахыг хичээсэн болно.

Хууль зүйн хувьд бохир мөнгө гэдэг нь тухайн улс орны дотоодын хууль тогтоомжид зааснаар гэмт хэрэгт тооцогдох үйлдэл, эс үйлдэхүйн үндсэн дээр бий болсон мөнгөн хөрөнгө, орлого байна.

Бохир мөнгөний талаарх ойлголт улс орнуудын хувьд харилцан адилгүй боловч мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлт, зэвсэг наймаалцах, түүхийн үнэт олдворыг хулгайлах зэрэг гэмт үйлдлийн улмаас бий болсон мөнгөн хөрөнгө, орлого нь бохир мөнгө болдог гэсэн шинжээрээ нэгдсэн нэг ойлголтыг бий болдог.

Бохир мөнгөтэй холбоотой асуудлыг эрдэмтэн судлаач нар анхлан мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлтийн үндсэн дээр бий болсон мөнгөн хөрөнгө орлого гэх байдлаар тодорхойлон судлаж эхэлсэн⁶⁸. бөгөөд улмаар гэмт бүлэглэлүүдээс эдийн засгийн ашиг орлого олж болохуйц олон төрлийн хүнд гэмт хэргүүдийг үйлдэх явдал нь бохир мөнгөтэй холбоотой байдаг хэмээн хамаатуулан судлаж, тэмцэх болсон ба үүнийг 1988 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенцын үзэл баримтлалаас харж болно⁶⁹.

Бохир мөнгийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбон авч үзэх тухай асуудлыг 1994 оны Страсбургийн⁷⁰ бага хурлаар хэлэлцэн “Бүх төрлийн гэмт хэргийн үйл ажиллагааны үндсэн дээр бий болсон мөнгө, мөнгөн хөрөнгө”⁷¹-ийг бохир мөнгө гэж үзэхээр тодорхойлсон нь бүтэц, агуулгын хувьд өргөн утгатай болгож өгсөн байна.

Бохир мөнгийг хууль ёсны эх үүсвэртэй мэт харагдуулах үйл явц нь мөнгө угаах гэмт хэргийн үндсэн шинж гэж судлаачид үздэг бөгөөд энэ талаар дараах үзэл санааг дэвшүүлдэг юм.

Мөнгө угаах гэдэг нь хууль бус үйл ажиллагааны үндсэн дээр бий болсон мөнгөн хөрөнгийн үнэ цэнийг алдагдуулалгүйгээр холбогдох хууль шүүхийн байгууллагын анхаарлын төвөөс холуур ашиглан хууль ёсны хөрөнгө болгох үйл явц⁷² гэж судлаач нар тайлбарладаг бол Монгол хэлний их тайлбар толинд хууль зөрчиж олсон бохир мөнгийг гүйлгээнд оруулж өөрийн болгон аривуулах⁷³ явдал хэмээн тусгажээ. Үүнээс үзэхэд мөнгө угаах гэмт хэрэг гэдэг

⁶⁷ Ergyl Ergin. Karapara Ekonomi ve Aklama Suzu, Ankara. Adalet yayinevi. 2005 он. 1,2-р тал.

⁶⁸ Ergyl Ergin. Karapara Ekonomi ve Aklama Suzu, Ankara. Adalet yayinevi. 2001 он. 2-р тал.

⁶⁹ 1988 оны Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц, Дэлгэрэнгүйг: <http://www.legalinfo.mn/law/details/1239?lawid=1239>

⁷⁰ Дэлгэрэнгүйг: <https://en.wikipedia.org/wiki/Strasbourg>

⁷¹ Başak Ramazan, 50 Soruda Karapara ve Karaparanın Aklanmasının Çnlenmesi, Ankara, Türkiye Bankalar Birliği yayını, 2000 он, 23-р тал.

⁷² Financial Supervisory Agency, Дэлгэрэнгүйг: http://www.fin-fsa.fi/en/Supervision/Money_laundering/Pages/Definitions.aspx.

⁷³ Монгол улсын ШУА, 2016.

нь хууль бус үйл ажиллагааны үндсэн дээр бий болсон мөнгө, мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг нуух зорилгоор өөр хөрөнгө болгох, өөр хөрөнгөөр солих үйл явцыг хэлнэ гэж тодорхойлж болно.

Монгол Улсын “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн 3.1.1 дэх хэсэгт “мөнгө угаах” гэж илт хууль бусаар олсон хөрөнгийг мэдсээр байж олж авсан, хувиргасан, шилжүүлсэн, эсхүл хууль ёсны байдалтай болгохын тулд эх үүсвэрийг нь халхавчилсан, нуун далдалсан, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн, бодит шинж чанар, хэлбэр, байршлыг нь өөрчилснийг хэлнэ...⁷⁴ гэж тодорхойлжээ.

НҮБ-ын 2000 оны Палермогийн конвенцид “мөнгө угаах гэж тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл үндсэн гэмт хэргийг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд өөрийн үйлдлийн төлөө хүлээх хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх; тухайн эд хөрөнгө нь гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмшигч буюу эд хөрөнгийн эрхийг нуух буюу далдлах; тухайн эд хөрөнгийг олж авах үед түүнийг гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгийг олж авах, эзэмших буюу ашиглах; мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, үгсэн тохиролцох, үйлдэхийг завдах болон хамжих, хатгах, туслах болон зөвлөх” үйлдэл юм хэмээн тодорхойлсон байдаг.

Дээрх тодорхойлолтуудаас үзвэл, мөнгө угаах гэдэг нь гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлс, ашиг, орлогын эх үүсвэрийг нуун далдалж, тэдгээрийг хууль ёсны мэтээр харагдуулах халхавчтайгаар эдийн засгийн эргэлтэнд оруулах, хэлбэр дүрсийг хувиргах бүхий л үйлдэл болон түүнд хамтран оролцохыг ойлгоно.

Мөнгө угаах буюу “Money Laundering” хэмээх нэршил анх АНУ-аас гаралтай бөгөөд АНУ-д архи хэрэглэхийг хориглосон “хуурай хууль”-тай болсон үеэс эхлэлтэй гэж үздэг. 1928 онд АНУ-ын Чикагогийн мафийн толгойлогч Ал Капоне гэгч нь бэлэн мөнгөөр төлбөр хийгддэг хувцас угаалгын сүлжээ газруудыг нээн гэмт хэргийн улмаас буюу мансууруулах бодис, архи согтууруулах ундаа зарж олсон орлогоо уг угаалгын газрын ашиг мэт харуулж байсныг тухайн үед “Express” сонинд “Хувцас биш мөнгө угааж байна” гэж бичиж тэмдэглэснээр мөнгө угаах гэж нэрлэгдэх болсон байна⁷⁵.

Үүний дараагаар гарч ирсэн мафийн толгойлогч Лаки Луцианогийн баруун гар болох Мейр Лански гэгч нь гэмт хэрэг үйлдэн олж авсан бохир мөнгөө хилийн чанадад гарган “off shore” данс болон Швейцарь дахь зарим банкны нэргүй данснуудад байршуулан буцаан АНУ-руу гадаад орнуудын үндэстэн дамнасан компанийн буцалтгүй тусламж эсхүл зээл олгож байгаа мэт оруулж мөнгө угаах үйл явцаа хэрэгжүүлж байв. Энэхүү мөнгө угаалтын үндсэн дээр бий болгосон мөнгөн хөрөнгөөрөө Лас Вегасыг байгуулсан гэж үздэг байна⁷⁶.

Мөнгө угаах гэмт хэрэг зөвхөн өндөр хөгжилтэй гэгдэх улс орнуудад үйлдэгдээд зогсохгүй хөгжиж буй болон буурай хөгжилтэй орнуудад тодорхой үе шат, дэс дараалалтай үйлдэгддэг гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Барууны судлаачид мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгддэг үе шатуудыг байршуулах, үечлэх, нийлүүлэх хэмээн нэрлэдэг бөгөөд энэхүү үе шатууд бохир хувцасыг угаалгын машинд хийж угаахтай төстэй байдлаар тайлбарлагддаг.

Нэг дэхь шат бохир хувцасыг угаалгын машинд хийх энэ нь байршуулах буюу placement, хоёр дахь шатанд бохир хувцас машинд угаагдах энэ нь үечлэх буюу layering, гурав дахь шатанд угааж цэвэрлэсэн хувцасыг гаргах энэ нь нийлүүлэх буюу integration⁷⁷ болно гэж тодорхойлсон байдаг. Үүнийг тодруулан авч үзье.

1. *Байршуулах үе шат /placement/*: Гэмт этгээд болон гэмт бүлэглэлүүдийн хувьд гэмт хэрэг үйлдэж олсон орлого хөрөнгө мөнгөө ямар нэгэн байдлаар санхүүгийн болон эдийн засгийн тогтолцоонд байршуулдаг⁷⁸ энэхүү үе шат нь хамгийн хүнд үе шатанд

⁷⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2013 он № 24

⁷⁵ Ergyl Ergin, Karapara Ekonomi ve Aklama Suzu, Ankara, Adalet yayinevi, 2005 он , 5-7-р тал.

⁷⁶ Нормен Инкстер, Гэмт хэргийг танихуй, мөнгө угаах, Канад, 2005 он, 14-р тал.

⁷⁷ Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016, УБ хот 2017 он, 275-р тал.

⁷⁸ Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016, УБ хот 2017 он, 275-р тал.

тооцогддог гэж судлаачид үздэг. Энэ үе шатанд бэлэн мөнгийг хэсэгчлэн хувааж хэд хэдэн төрлийн банкинд хэд хэдэн хүний дансанд хийх, эсхүл мөнгөний хяналт шалгалт харьцангуй сул улс оронд тухайн бохир мөнгийг гаргаж банкинд байршуулах, бохир мөнгийг үнэтэй машин, түүхийн олдвор, уран зураг, үнэт чулуу зэргийг худалдан авахад ашиглах гэх мэтээр байршуулдаг.

Бохир мөнгө дээр дурдсан аргуудаар санхүү, эдийн засгийн тогтолцоонд байршуулагдсанаар бэлэн мөнгөний чанараа алдаж бэлэн бус болох бөгөөд энэ шатанд бохир мөнгөний эх үүсвэрийг олж тогтоогоогүй бол хууль хүчний байгууллагын албан хаагчид дараа дараагийн шатанд мөнгө угаах гэмт хэргийг илрүүлэх явдал тун эдрээ төвөгтэй болох юм⁷⁹.

2. *Үечлэх үе sham /layering/*: Энэ шатанд гэмт хэрэгтэн этгээдүүд бэлэн мөнгөнөөс бэлэн бус хэлбэрт шилжсэн хөрөнгийг хууль хүчний байгууллага олж илрүүлэхэд саад учруулах зорилгоор уг бохир мөнгийг эх үүсвэрээс нь холдуулдаг.

Мөн уг үе шатанд мөнгө угаагч нар тухайн мөнгийг боломжтой бол маш олон тооны данс ашиглан нэгээс нөгөөд нь шилжүүлж байдаг ба энэхүү шилжүүлгийг дэлхий өнцөг булан бүрт үйл ажиллагаагаа явуулж байгаа мэт зохион байгуулсан хуурамч байгууллагуудын дансанд хийж мөн буцаан татах бөгөөд уг ажиллагаанд банк санхүүгийн байгууллагын хэрэглэгчдийн нууцыг хамгаалах чиг үүргийг нь ашигладаг⁸⁰ байна.

Нийлүүлэх үе sham /integration/: Энэ үе шатанд бохир мөнгө угагдсан буюу хууль ёсны үйл ажиллагааны үндсэн дээр бий болсон мөнгөн хөрөнгөний хэлбэрийг өөртөө агуулна, өөрөөр хэлбэл бохир мөнгө тухайн улсын эдийн засгийн тогтолцоонд бүрэн нэгтгэгдсэн гэж ойлгож болно. Энэ шатанд мөнгө угаасан үйлдлийг тогтоох нь өмнөх хоёр шаттай харьцуулахад боломжгүй юм⁸¹.

Дээр дурдсан үе шатууд бүрэн байдлаар хэрэгжсэн тохиолдолд л мөнгө угаалт явагдсан гэж ойлгож болохгүй ба зарим тохиолдолд дээрх үе шатын хоёр нь эсхүл гурав нь нэг үйлдлээр хийгдэж болдог. Энэ нь мөнгө угааж байгаа улс орны /газрын/ нийгэм эдийн засгийн хөгжил, боломж, мөнгө угаагчийн үйл ажиллагаа зэрэгтэй холбоотойгоор өөрчлөгдөж байдаг⁸² байна.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг АНУ хамгийн идэвхтэй явуулдаг⁸³ ба Холбооны мөрдөх товчооны судалгаанаас үзэхэд мөнгө угаах үйлдлийг хориглосон хууль, дүрэм, журам батлагдан гарахаас өмнө жилд дунджаар 300 тэрбум ам долларын бохир мөнгө угаагддаг байсан гэх таамаглал бий.

АНУ-д бохир мөнгө нь ихэнх тохиолдолд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын худалдаа, мөрийтэй тоглоом, зэвсгийн наймаа, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа зэрэг гэмт хэргүүдийн үндсэн дээр бий болдог бөгөөд үүний 60-80 хувийг нь мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын худалдаа бүрдүүлдэг байна.

АНУ 1970 онд "Банкны нууцын тухай хууль"-д */Bank Secrecy Act/* анх мөнгө угаах үйлдлийг хуульчилсан хэдий ч дээрхи үйлдлийг 1986 онд батлагдсан "Мөнгө угаалтыг хянах тухай хуулиар */Money Laundering Control Act/* бие даасан гэмт хэрэг гэж үзэх болсон бөгөөд Эрүүгийн хуулийн */US Code/* 1956, 1957 дугаар зүйлүүдэд мөнгө угаах гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагын талаар тус тус хуульчилсан байна.⁸⁴

Эрүүгийн хуулийн 1956 дугаар зүйлд "Тодорхой хууль бус үйл ажиллагааны */Specified Unlawful Activity/* үндсэн дээр олсон ашиг орлого эсхүл уг ажиллагааны үндсэн дээр бий болсон мөнгөн хөрөнгийг хадгалж буй газар, эх үүсвэр, мөн чанарыг өөрчлөх, уг орлогыг бусдад шилжүүлэх, гадаад худалдаанд оруулах" гэх мэт үйлдлүүдийг мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн гэж үзсэн. Мөн уг зүйл ангид хууль бус үйлдлүүдийг тодорхойлж бусад хууль болон уг хуулийн холбогдох зүйл заалтуудыг ишлэл болгон тусгасан байна⁸⁵.

Хууль бус үйл ажиллагаанд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт, зэвсгийн наймаа, цөмийн зэвсгийн түүхий эдийн наймаа, залилан, хуурамч бичиг

⁷⁹ Zelik, Kozacıra, Gьler, Karapara Aklama, Ankara, Masak yayınları, 2000 он , 75-78-р тал.

⁸⁰ Ergьl Ergin, Karapara Ekonomi ve Aklama Suzu, Ankara, Adalet yayınevi, 2005 он , 9-10-р тал.

⁸¹ İpek Halim, Bir Sorun Karapara ve Karaparanın Aklanması, İstanbul, Beta yayıncılıđı, 2000 он , 18-р тал.

⁸² Zelik, Kozacıra, Gьler, Karapara Aklama, Ankara, Masak yayınları, 2000 он , 75-р тал.

⁸³ İpek Halim, Bir Sorun Karapara ve Karaparanın Aklanması, İstanbul, Beta yayıncılıđı, 2000 он , 65-р тал.

⁸⁴ www.law.cornell.edu/uscode/text/18/part-1/chapter-95.

⁸⁵ www.law.cornell.edu/uscode/text/18/1956.

баримт бүрдүүлэх, сүрдүүлэг, дээрэм гэх мэт нийт 130 төрлийн гэмт хэрэг хамаарах бөгөөд дээрхи гэмт хэргийн талаар мэдэгдвэл зохих байгууллага, албан тушаалтан мэдэгдээгүй тохиолдолд мөн мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхээр хуульчилсан.

Мөн хуулийн 1957 дугаар зүйлд “Хууль бус үйл ажиллагааны үндсэн дээр олсон ашиг орлого гэдгийг мэдсээр байж 10.000 доллараас илүү хэмжээний мөнгөөр гүйлгээ хийх, гүйлгээ хийхийг завдах нь мөнгө угаах гэмт хэрэг болох бөгөөд уг үйлдэлд 10 хүртэл жилийн хорих ял, торгох ялаар шийтгэнэ гэж тусгажээ.⁸⁶ Түүнчлэн, Банкны нууцын тухай хууль, Мөнгө угаалтыг хянах тухай хуулиудад тусгаснаар банкинд хийгдэх гүйлгээ 10.000 доллар түүнээс илүү байх тохиолдолд холбогдох байгууллагууд 15 хоногийн дотор Дотоодын орлого үйлчилгээний төвд /Internal Revenue Service/ мэдэгдэх, сэжигтэй гүйлгээ хийгдсэн бол 30 хоногийн дотор Холбооны мөрдөх товчоонд /FBI/ мэдэгдэх үүрэгтэй гэжээ.

Герман Улсын Эрүүгийн хуульд хамгийн багадаа 1 жил хүртэл хугацаагаар хорих ял оноож болох гэмт хэргийг үйлдэж олсон ашиг орлогын эх үүсвэрийг нуух болон бусад байдлаар гүйлгээнд оруулах нь мөнгө угаах гэмт хэрэг болно гэж үздэг.

Тус улсын Эрүүгийн хууль, Мөнгө угаахтай тэмцэх тухай хуулиар “банк болон банк бус санхүүгийн байгууллагууд нь үйлчлүүлэгчид бичиг баримтанд нарийн шалгалт хийх, сэжигтэй гүйлгээтэй холбоотой мэдээллийг холбогдох байгууллагад мэдэгдэх, уг байгууллагад ажиллагсад мэргэжлийн эрх мэдлээ ашиглаж мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх зэрэг үүргүүдийг олгосон байна. Мөнгө угаахтай холбоотой мэдээ мэдээлэл, сэжиг бүхий гүйлгээг банк болон банк бус санхүүгийн байгууллагууд төрийн байгууллагад мэдэгдэхээс зайлсхийвэл уг байгууллагын үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгохоор хуульчилсан байдаг.

Герман улсын Эрүүгийн хуулийн 73 дугаар зүйл: Гэмт хэргийн шинж чанартай үйлдэл хийж олсон орлого бусад эд зүйлсийг хураана. Хэрэв гэмт хэрэгт холбогдсон этгээд мөрдөн шалгах ажиллагааны үед сураггүй алга болсон эсхүл нас барсан бол тодорхой үйл ажиллагаа хийгдсэний дараагаар орлого, эд хөрөнгийг хураана. Гэмт хэрэг үйлдэж олсон орлого, эд хөрөнгө гуравдагч этгээдэд шилжсэн уг эд хөрөнгийг хууль бус үйл ажиллагааны үндсэн дээр олсон болохыг гуравдагч этгээд мэдэж байгаа бол мөн хураан авна⁸⁷ гэж заажээ.

Турк улс эрх зүйн хүрээнд нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд мөнгө угаах үйл явцтай тэмцэхийн тулд 1996 онд анх Мөнгө угаахтай тэмцэх тухай хуулийг баталж мөн эрүүгийн хуулиндаа мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэг гэж тооцон хуульчилсан байна.

Турк улсын Эрүүгийн хуулийн 282 дугаар зүйлд “Хорих ялын доод хэмжээ нь 1 жил буюу түүнээс илүү хугацаатай гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, мөнгөн хөрөнгийг хилийн чанадад гаргах эсхүл гэмт хэргийн үндсэн дээр бий болсон орлогыг хууль ёсны үйл ажиллагааны үндсэн дээр олсон орлого мэт харуулах зорилгоор төрөл бүрийн үйл ажиллагаа явуулсан бол хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих, хорин мянган өдөртэй тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр торгох ял шийтгэнэ” гээд мөнгө угаах гэмт хэргийг төрийн албан хаагч өөрийн мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад үйлдсэн эсхүл гэмт бүлэглэл, зохион байгуулалттай бүлэг үйлдсэн бол оногдуулах ялын хэмжээг нэг дахин нэмж шийтгэнэ⁸⁸ гэж хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр заажээ.

Дээрхи улс орнуудад ямар үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэгт тооцох эсэх асуудал харилцан адилгүй өөр өөр байна.

Монгол Улс 2006 онд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийг баталсан бөгөөд уг хуулийг 2013 онд шинэчлэн баталсан.

2002 оны Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлд 2008 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийг нэг жилийн дараа 2009 онд хүчингүй болгосон. 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд дахин “мөнгө угаах” гэмт хэргийг хуульчлан оруулсан зэрэг эдгээр эрх зүйн зохицуулалтууд нь Монгол улс мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хийж буй үйл ажиллагаануудын нэгээхэн хэсэг нь юм.

⁸⁶ www.law.cornell.edu/uscode/text/18/1957.

⁸⁷ Erman, R. Barış Almanya'da ve Avustralya'da Organize Suçlulukla Mьcadele Kapsamında Kabul Edilen Malvarlıgıyla İlgili Cezai Yaptırmalar, İstanbul, 1999 он, 268-271-р тал.

⁸⁸ www.tbmm.gov.tr/kanunlar/k5237.html

2002 оны Эрүүгийн хуулийн 268¹ дугаар зүйлд “Зэвсэг, хар тамхи, хүн худалдаалах эсхүл хуурамч мөнгөн тэмдэгт үйлдвэрлэж олсон орлого, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, терроризмыг санхүүжүүлэх зорилготой илт хууль бус эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж эх үүсвэрийг нь халхавчлах буюу нуун далдлах, эсхүл уг эд хөрөнгийг хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж мөнгө угаах гэмт хэргийн бүрэлдэхүүний халдлагын зүйл, объектив талын шинж, гэм буруугийн хэлбэр, гэмт хэргийн зорилго, хүлээлгэх хариуцлагын талаар маш тодорхой хуульчилсан бөгөөд энэ зүйлийг 2009 оны 12 сарын 24-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон байдаг.

Түүнчлэн, 2009 оны мөн өдрийн Эрүүгийн хуульд орсон нэмэлтээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166^{1.1} дүгээр зүйлд мөнгө угаах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжийг “Хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор 166 дугаар зүйлд зааснаас бусад хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, мөнгийг санаатайгаар хүлээн авсан, хадгалсан, ашигласан, шилжүүлсэн, хувиргасан бол” гэж шинэлэг байдлаар тодорхойлсон байдаг.

2015 оны Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл, 18.6.1-д “мөнгө угаах” гэмт хэргийн үндсэн шинжийг тодорхойлохдоо “Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заажээ.

Энэхүү гэмт хэргийн үндсэн шинжид дүн шинжилгээ хийж үзвэл 2002 оны эрүүгийн хуулийн 155 дугаар зүйлд заасан “гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийн диспозици харагдах бөгөөд Эрүүгийн хуулийн 155 дугаар зүйл, 155.1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан, хадгалсан, борлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ” гэжээ.

Мөнгө угаах гэмт хэргийг нь төрийн болон төрийн бус байгууллагын өндөр эрх мэдэл бүхий албан тушаалтан оролцон байж мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын худалдаа, мөрийтэй тоглоом, зэвсэг, хүний эд эрхтэний наймаа, хүн худалдаалах зэрэг хууль бус үйл ажиллагааны үндсэн дээр бий болсон бохир мөнгийг ямар нэгэн байдлаар санхүүгийн болон эдийн засгийн тогтолцоонд байршуулсан үйлдэл бөгөөд энэ нь Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдалд хохирол учруулсан, учруулахуйц байдлыг бий болгосон байдаг.

Эдийн засгийн аюулгүй байдал⁸⁹ гэдэг нь дотоод нөөц бололцоогоо ашиглан нөхөн үйлдвэрлэл явуулах, ард түмнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлаа бэхжүүлэх, эдийн засгийн чадавхитай байх, шаардлагатай нөхцөлд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бүтэц бүрдсэн байдлыг хэлнэ.

Амьдралд өдөр тутам үйлдэгдэн гарч буй бусдын өмчийг хулгайлах тодруулбал авто машины эд анги, гар утас, цахилгаан бараа, мал зэргийг хулгайлсан этгээдүүдээс хулгайн эд зүйл гэдгийг мэдсээр байж худалдан авалт хийж байгаа хүмүүсийн үйлдэл нь бусдын өмчлөх эрхэнд халдаж түүнд гэм хор учруулсан үйлдэл бөгөөд тэдэнд мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн гэж ял оноож байгаа байдал нь “мөнгө угаах” гэдэг нэршилтэй тохирохгүй байгаа тул эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 18.6.1-д заасан гэмт хэргийг “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүлэг” оруулан хуульчлах шаардлагатай байгаа нь гадаад улс орнуудын эрүүгийн хуулийн холбогдох зүйл ангиудад хийсэн дүн шинжилгээнээс харагдаж байна.

⁸⁹ Улсын Их Хурлын 2010.07.15-ны өдрийн №48 тоот тогтоол. “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”. 3.2 дах хэсэг

Эрүүгийн хуулийн шинэчлэл өөрчлөлт нь Монгол Улсын язгуур эрх ашиг, ард түмний үндэсний соёл, ёс заншил, нийгмийн амьдралын хэв маягтай нийцээгүй байгаа нь 2002 оны Эрүүгийн хуульд тусгагдсан гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд өөр өөр шинжүүдийг агуулсан 2 өөр төрлийн гэмт хэргийг нэгтгэсэн хуулийн оновчгүй зохицуулалтаас тодорхой харагдаж байна.

Энэ нь Эрүүгийн хуульд заасан “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй” гэсэн Хууль ёсны зарчим, “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэсэн Шударга ёсны зарчмыг зөрчсөн үйлдэл болох нь хууль хэрэглээний явцад олон арван баримтаар илрэн гарч байна.

Дүгнэлт

Ямар төрлийн хууль бус үйл ажиллагааг явуулж олсон мөнгө нь бохир мөнгө гэдгийг тодорхойлох явдал улс орон бүрийн онцлогоос шалтгаалж харилцан адилгүй байх нь ойлгомжтой. Ихэнх улс орнуудад мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдсэн гэдгийг илтгэх анхдагч гэмт хэргүүдийг зааж өгсөн байдаг бөгөөд зарим улсад гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөн хөрөнгийг бохир мөнгө гэж үзэж байгаа бол нөгөө хэсэгт нь үйлдэгдсэн гэмт хэргийн оногдуулах хорих ялын хэмжээг заан уг гэмт хэргийг үйлдэж олсон мөнгөн хөрөнгө нь бохир мөнгө болохыг тодорхойлсон байна.

Бохир мөнгийг бий болгодог хууль бус үйлдэлүүдийг чухалчлан авч үзэхэд мансууруулах, сэтгэцэд нөлөөтэй бодисын хууль бус эргэлт, зэвсгийн наймаа, хүний наймаа, эд эрхтэний наймаа гэх мэт болох бөгөөд уг гэмт хэргүүдийг илрүүлж нотлох нь мөнгө угаах гэмт хэргийг үйлдэж буй этгээд, гэмт бүлэглэлүүдийг илрүүлэх, хариуцлага тооцох үндэслэл болдог.

Мөнгө угаах гэмт хэргийн онцлог нь улс орны эдийн засгийн орчинд хохирол учруулаад зогсохгүй нийгэм, олон нийтийн санаа бодолд хохирол учруулах боломжтой хор хөнөөл ихтэй гэмт хэрэг юм.

Өндөр эрх мэдэл бүхий албан тушаалтан хахуульд автах, хууль шүүхийн байгууллагын хараат бус байдал алдагдах, ард иргэд нь ёс суртахуун, оюун санааны доройтолд орох зэрэг нөхцөл байдал нь мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэн гарах шалтгааныг бий болгодог.

Гадаад улс оронд мөнгө угаах гэмт хэргийг ихэвчлэн улс төр, албан тушаалын өндөр хүрээлэлд багтах хүмүүс болон зохион байгуулалттай гэмт бүлэглэл үйлддэг гэж үзэн уг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хууль бус үйлдлийг илрүүлэн ялыг оноож байдаг бол Монгол улсад бусдын өмч болох авто машины эд анги, гар утас, цахилгаан бараа, мал зэрэг зүйлийг хулгайлсан хүнээс хулгайн эд зүйл гэдгийг мэдсээр байж худалдан авч ашигласан хүмүүсийн үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн гэж үзэн ял оногдуулж байна.

Энэ нь эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 18.6.1-д заасан мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж буй субъект нь эрх мэдэлтэн, элитийн хүрээний бизнес эрхлэгч зэрэг хүмүүс бус жижиг хэмжээний хулгайн эд зүйлийг худалдаж авдаг, худалдан авсан эд зүйлийн үнийн зөрүүгээс өчүүхэн ашиг олж амьдралаа залгуулдаг жирийн иргэн байгаа явдалд анхаарч дээрхи үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэгт бус өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт тооцон хариуцлага хүлээлгэх нь шударга ёсны зарчимд нийцнэ.

Санал

1. Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан, хадгалсан, борлуулсан гэх үйлдлийг учруулсан хохирлын нийгмийн хор аюулын шинжийг харгалзан тухайн хэрэгт оногдуулах хорих ялын дээд хэмжээг 5 жилээс доош хугацаагаар тогтоосон хэргийг хөнгөн гэмт хэргийн ангилалд хамааруулан үзэж уг үйлдэлд мөнгө угаах гэмт хэрэг бус өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэн хариуцлага тооцох.
2. Бага хэмжээний хохиролтой эд зүйлийг авсан, хадгалсан, борлуулсан үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлд зааснаар хариуцлага тооцох

Ном зүй

- Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. Монгол улс дахь гэмт хэргийн цагаан ном-2016, УБ хот 2017 он
- Нормен Инкстер, *Гэмт хэргийг танихуй, мөнөө угаах*, Канад, 2005 он.
- Süleyman Aydın, *Karapara Aklama İle Mücadelede Uluslararası Boyut Suçu*, Ankara, 2008 он.
- Başak Ramazan, *50 Soruda Karapara ve Karaparanın Aklanmasının Önlenmesi*, Ankara.
- Çelik, Koçağra, Güler, *Karapara Aklama*, Ankara, Masak yayınları, 2000 он.
- Ergül Ergin, *Karapara Ekonomi ve Aklama Suçu*, Ankara, Adalet yayınevi, 2005 он.
- Ergül Ergin, *Karapara Ekonomi ve Aklama Suçu*, Ankara, Adalet yayınevi, 2001 он.
- Erman, R. Barış *Almanya'da ve Avustralya'da Organize Suçlulukla Mücadele Kapsamında Kabul Edilen Malvarlığıyla İlgili Cezai Yaptırımlar*, İstanbul, 1999 он.
- İpek Halim, *Bir Sorun Karapara ve Karaparanın Aklanması*, İstanbul, Beta yayıncılığı, 2000 он.
- Türkiye Bankalar Birliği yayın, 2000 он.
- www.legalinfo.mn/law/details/1239?lawid=1239
- www.finsa.fi/en/Supervision/Money_laundering/Pages/Definitions.aspx.
- en.wikipedia.org/wiki/Strasbourg
- www.legalinfo.mn/law/details/9242?lawid=9242
- www.law.cornell.edu/uscode/text/18/part-I/chapter-95.
- www.law.cornell.edu/uscode/text/18/1956.
- www.law.cornell.edu/uscode/text/18/1957.
- www.tbmm.gov.tr/kanunlar/k5237.html.

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ОБ ОСНОВАНИЯХ АРЕСТА ПОДОЗРЕВАЕМОГО ПО УПК МОНГОЛИИ 2017 ГОДА

Даш Тамир
Адъюнкт адъюнктуры
Омской академии МВД России
капитан полиции

Аннотация: автор проводит анализ оснований ареста подозреваемого в совершении преступления по УПК Монголии 2017 года. Рассматривает виды оснований ареста подозреваемого, их содержание.

Ключевые слова: арест подозреваемого, основания ареста подозреваемого.

Новый УПК Монголии (далее УПК) был утвержден Великим Государственным Хуралом Монголии в мае 2017 года. Он вступил в действие с первого июля 2017 года⁹⁰. Арест подозреваемого, предусмотренный УПК Монголии 2002 года претерпел значительные изменения. В проекте нового УПК Монголии, опубликованном 13 мая 2016 года, такая мера процессуального принуждения, как арест подозреваемого вообще отсутствовала. Однако, данный проект не был принят Парламентом⁹¹.

Основания ареста подозреваемого по УПК Монголии 2002 года были установлены ст. 58 УПК Монголии. В соответствии с ней подозреваемый подлежит аресту, если он попытался скрыться, либо есть достаточные доказательства подозревать его в совершении тяжкого или особо тяжкого преступления⁹². Новый УПК более подробно регламентирует основания ареста подозреваемого. Нормы об этом были помещены в часть шестую УПК «Дознание и предварительное следствие» в главу 31 УПК «Предварительное следствие». Предусматривается два вида оснований: основания ареста подозреваемого с разрешения суда (ст. 31.4 УПК) и без разрешения суда (ст. 31.5 УПК). Они регулируются самостоятельными статьями. В каждой из них законодатель предусматривает перечень сведений, которые необходимо установить для обоснования принятия соответствующего решения.

Согласно ст. 31.4 УПК детектив вправе арестовать лицо с разрешения суда, при наличии одного из следующих оснований:

- в случае неявки по письменному уведомлению прокурора без уважительных причин подозреваемого для ознакомления с постановлением о возбуждении уголовного дела и привлечении в качестве обвиняемого, либо уклонения от получения письменного уведомления прокурора;

Первое основание следует понимать таким образом: лицо уже предприняло действия к уклонению от прокурора, а именно: скрывается, не является по вызову, уклоняется от получения письменного уведомления прокурора.

- подозреваемый скрылся от органов расследования, либо есть основания полагать, что он может не явиться по вызову прокурора;

⁹⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль // Төрийн мэдээлэл. 2017. №23. // УПК Монголии // Государственная информация. 2017. №23.

⁹¹ Монгол Улсын Засгийн газрын албан ёсны веб хуудас // Официальный сайт Парламента Монголии URL: www.parliament.mn (дата обращения: 07.03.2018).

⁹² См. более подробно: Даш Т. Соотношение ареста подозреваемого по УПК Монголии с задержанием подозреваемого в порядке ст. 91 УПК РФ // Научный вестник Омской академии МВД России. 2017. №3(66). С. 25-26.

Понятие «попытался скрыться» следует рассматривать в двух аспектах. Первый – лицо уже предприняло действия к уклонению от детектива и прокурора, а именно: не является по вызову, скрылось с места происшествия, во время доставления, из служебного кабинета, оказало активное сопротивление при аресте.

Второй – имеется высокая степень вероятности того, что подозреваемый может уклониться от органов расследования и суда. Об этом могут свидетельствовать отсутствие гражданства, постоянного места жительства, наличие судимостей, внезапное увольнение с работы, снятие с регистрационного и военного учетов, продажа имущества, покупка билетов на выезд за границу и т.д.⁹³.

- в отношении детектива, прокурора, судьи, потерпевшего, свидетеля и соучастника в совершении преступления имеется угроза их жизни и здоровью, оказание давления на этих лиц;

Под угрозами покушения на жизнь и здоровье понимаются активные действия подозреваемого, запрещённые УК Монголии. Об этом может свидетельствовать отправление писем, содержащих угрозы покушения на жизнь и здоровье, шантаж и т.д.

- наличие достаточных оснований, указывающих на совершение преступления, возможность продолжить преступную деятельность, либо закончить начатое преступление;

Под достаточностью доказательств можно понимать сведения, относящиеся к делу, полученные на основании и по правилам, установленным настоящим законом. Сведения, имеющие значение для рассмотрения и разрешения дела, устанавливаются показаниями свидетелей, потерпевших, подозреваемого, обвиняемого или подсудимого, заключениями и показаниями эксперта, вещественными доказательствами, протоколами следствия и судебных заседаний (ч. 1 и 2 ст. 16.1 УПК).

- выявлены достаточные основания, указывающие на уничтожение, изменение и подделку доказательств; либо незаконное воздействие в отношении потерпевшего, свидетеля и соучастника в совершении преступления.

Под устранением, изменением и подделкой доказательств можно понимать любые активные действия подозреваемого по уничтожению или сокрытию доказательств и иным путем воспрепятствование производству по уголовному делу.

Согласно ст. 31.5 УПК детектив вправе арестовать лицо по подозрению в совершении преступления, без разрешения суда, при наличии одного из следующих оснований:

- когда лицо застигнуто при совершении преступления или непосредственно после его совершения;

Первое основание следует понимать таким образом: лицо застигнуто непосредственно на месте совершения преступления, в момент выполнения преступных действий, сразу после их окончания либо при попытке бегства с места происшествия. Лицо может быть застигнуто при указанных обстоятельствах сотрудниками полиции, других правоохранительных органов, а также гражданами.

- в случаях не терпящих отлагательств, предусмотренных настоящим кодексом (см.: п. 1.26 ч. 1 ст. 1.4 УПК);

В соответствии части 1 статьи 1.4 пунктом 1.26 УПК под не терпящими отлагательств понимаются обстоятельства, имеющие реальную опасность для жизни и здоровья человека; уничтожение и повреждение имущества, перемещение, сокрытие подозреваемым и обвиняемым следов преступления: попытка скрыться от органов расследования и суда.

- когда потерпевшие или свидетели укажут на данное лицо как на совершившее преступление;

Под прямыми указаниями свидетелей понимаются показания одного или нескольких свидетелей, которые прямо и уверенно, указывают на лицо, совершившее преступление (п.1.3 ч.1 ст.31.5 УПК). Потерпевший может прямо указать на лицо, совершившее в отношении него

⁹³ См. более подробно: Даш Т. Арест подозреваемого по УПК Монголии. Подходы к решению проблем законотворчества и правоприменения // Сб. науч. тр. адъюнктов и соискателей. - Омск: Омская академия МВД России, 2016. - Вып. 23. С. 64-65.

преступление, в случае визуального контакта с этим лицом во время совершения преступления.

- когда на этом лице или его одежде, при нем или в его жилище, или в транспортном средстве будут обнаружены явные следы преступления.

Явными следами преступления являются такие следы, которые непосредственно образовались в результате совершения преступления. Они могут быть обнаружены как на самом подозреваемом, так и на его одежде, при нем или в его жилище, или в транспортном средстве (пятна крови, порезы, царапины, другие последствия воздействия на человека)⁹⁴.

Подводя итог изложенному выше можно констатировать, что основаниями ареста подозреваемого являются имеющиеся в уголовном деле доказательства, которые свидетельствуют о том, что подозреваемый и обвиняемый может скрыться от предварительного следствия или суда, может продолжать заниматься преступной деятельностью, угрожать свидетелям, иным участникам уголовного судопроизводства, уничтожить доказательства либо иным путем воспрепятствовать производству по уголовному делу.

⁹⁴ См. более подробно: Уголовный процесс. В 2 ч. Часть 1: учебник для вузов / под ред. Б.Б. Булатова, А.М. Баранова. - 6-е изд., перераб. и доп. - М.: Издательство Юрайт, 2017. С. 142-143.

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИЙН ДУНДАЖ НАСЛАЛТ, ТҮҮНД ХИЙСЭН СУДАЛГАА

Б.Энхболд
ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй,
Криминологийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), цагдаагийн хошууч
Э. Уянга
Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн
Мөрдөн байцаах тасгийн мөрдөгч, цагдаагийн ахмад

Удиртгал

Хүний хөгжлийн индексийн үндсэн үзүүлэлтүүдийн нэг болох хүн амын дундаж наслалтаар Монгол улс дунд зэргийн хөгжилтэй орны тоонд ордог⁹⁵. Үндэсний статистикийн хорооноос 2013 онд гаргасан тооцооллоор манай улсын хүн амын дундаж наслалт 69.1, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 75, эрчүүдийн дундаж наслалт 65.4 байна.⁹⁶

Монгол улс 1992 оноос эхлэн хүн амын дуудлаарх үндэсний стратегийг гаргаж ирсэн бөгөөд тухайн онд дундаж наслалт 62.8 байсан бол 2013 онд дундаж наслалт 6.3 жилээр нэмэгдсэн үзүүлэлттэй болжээ.

Дээрх үзүүлэлтийг Монгол Улсын Засгийн газраас хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажилласны үр дүн гэж дүгнэж болно. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 130 дугаар тогтоолоор “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөр”, 2009 оны 156 тоот тогтоолоор “Монгол Улсын хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратеги”, тус стратегийг хэрэгжүүлэх хүрээнд засгийн газрын 2013 оны 416 дугаар тогтоолоор “эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж байна.

Тус стратеги нь хүн амыг насжилтын үйл явцад бэлтгэх, ахмад настны аж байдлыг сайжруулах талаар 2030 он хүртэл баримтлах урт хугацааны бодлогын баримт бичиг бөгөөд хүн амын насны бүтцэд гарч буй өөрчлөлт, хандлагад тулгуурлан төлөвлөлтийг ойрын ирээдүйн болон жил бүрээр боловсруулан нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, холбогдох яамд, байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөх замаар хэрэгжүүлэхийг заасан. Цаашид тус стратегийн хэрэгжилтийг хангахад салбарын хэмжээнд үйл ажиллагааг зохион байгуулах үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Улсад цагдаагийн байгууллага, эсхүл аль нэг төрөл мэргэжлийн албан хаагчдын наслалтын талаар нарийвчилсан судалгааны ажил хийгдээгүй, энэ талаар хэрэгжүүлж буй тодорхой арга хэмжээ өнөөг хүртэл байхгүй нь энэ чиглэлээр судлах шаардлагатайг харуулж байна.

Энэ судалгааны ажлын хүрээнд Монгол улс дахь цагдаагийн алба хаагчдын дундаж наслалт, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, наслалтыг нэмэгдүүлэх нийгэм, эдийн засгийн баталгаа бүрдүүлэх арга замыг эрэлхийлсэн санал дүгнэлт боловсруулахад оршино.

Судалгааны ажлын хүрээнд цагдаагийн албанд ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан алба хаагчид, тэдний дундаас 2012-2017 онд нас барсан 94 алба хаагчдын насны бүтэц, бусад хувийн мэдээлэлд тулгуурлан цагдаагийн алба хаагчийн дундаж наслалтыг Монгол хүний

⁹⁵ Үндэсний статистикийн хороо “Монгол улсын хүний хөгжлийн индекс-2013”, УБ., 2014

⁹⁶ С.Туяа. “Насжилт, ахмад настны нийгмийн хамгаалал”, Нийгмийн ажил сэтгүүл УБ., 2016

дундаж наслалттай харьцуулах, алба хаагчдын ажиллаж байсан алба, ажилласан жил, цол, хүйс зэрэг нь цагдаагийн алба хаагчдын наслалтад хэрхэн нөлөөлж байгаад харьцуулалтын аргаар дүн шинжилгээ хийсэн.


Цагдаагийн алба хаагчдын дундаж наслалтад хийсэн судалгаа

Судалгааны ажлын хүрээнд цагдаагийн алба хаагчийн наслалтын байдлыг судлах үүднээс 2012-2017 оны хооронд буюу сүүлийн 5 жилийн байдлаар Цагдаагийн албанд ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан нийт 417 алба хаагч дотроос нас барсан 94 алба хаагчдын мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн болно. Нас барсан нийт 94 алба хаагчийг хүйсээр нь авч үзвэл, Эрэгтэй алба хаагч -87, Эмэгтэй алба хаагч- 7 байна.

График -1



Алба хаагчдын сүүлийн 3 жилд ажиллаж байсан албаар нь харьцуулан авч үзвэл, Хэв журам хамгаалах албанд ажиллаж байсан алба хаагч 52 буюу 55.3 хувь, Захиргаа удирдлагын албанд ажиллаж байсан алба хаагч 21 буюу 22.3 хувь, Гэмт хэрэгтэй тэмцэх албанд ажиллаж байсан алба хаагч 21 буюу 22.3 хувийг тус тус эзэлж байна.




Цэргийн байнгын тэтгэвэрт гараад нас барсан алба хаагчдыг цагдаагийн цолоор нь ангилан авч үзвэл, 31 буюу 32.9 хувь нь ахлах офицер, 25 буюу 26.5 хувь нь дунд офицер, 38

буюу 40.4 хувь нь ахлагч цолтой алба хаагчид байжээ. Дээрх цолны байдлаар авч үзэл судалгаанд ашигласан алба хаагчдын материал шаардлага хангаж байна.

Цагдаагийн байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гараад нас барсан нийт 94 алба хаагчийн дундаж наслалт 66.5 байна. Үүнээс эрэгтэй алба хаагчдын дундаж наслалт нь 67.5, эмэгтэй алба хаагчийн дундаж 70 нас гэсэн үзүүлэлттэй байна⁹⁷. Монгол улсын хүн амын хөгжлийн судалгаанаас үзэхэд монгол хүний дундаж наслалт 69.6, эрэгтэй хүний дундаж нас 65.6, эмэгтэй хүний дундаж наслалт 75.1 гэсэн үзүүлэлттэй байна. Дээрх судалгаанаас үзвэл цагдаагийн байгууллагад ажиллаж байсан хүн монгол хүний дундаж наслалтаас 3.1 жилээр богино насалдаг бол эрэгтэй алба хаагчид 1.9 жил илүү насалдаг байна. Харин эмэгтэй алба хаагч монгол эмэгтэй хүнтэй харьцуулахад 5.1 жилээр богино насалдаг байна. (График №1)


График №4 Монгол Улсын хүн амын дундаж наслалт ба цагдаагийн албан хаагчийн насны харьцуулалт, хүйсээр



Дээрх судалгаанаас үзэхэд цагдаагийн албанд ажиллаж байсан эрэгтэй алба хаагч монгол хүний дундаж наслалтаас дээгүүр насалдаг болох нь харагдаж байна.

Дээрх судалгааг нарийвчлан авч үзэх үүднээс цагдаагийн алба хаагчдыг ажиллаж байсан албаар нь харьцуулан авч үзсэн болно. (График №5)

График №5. Албаар нь харьцуулсан судалгаа




⁹⁷ Үндэсний статистикийн хороо. "Монгол хүний хөгжлийн индекс" судалгааны тайлан. УБ., 2017 он

Судалгаанаас үзэхэд гэмт хэрэгтэй тэмцэх албанд ажиллаж байсан алба хаагчийн дундаж наслалт 63.3 буюу цагдаагийн алба хаагчийн дундаж наслалтаас 3.2 жилээр богино насалж байгаа бол хэв журмын албанд ажилласан алба хаагчийн дундаж наслалт 67.5 буюу 1 жилээр урт насалж байна.

Харин захиргаа удирдлагын албанд ажиллаж байсан алба хаагч 70.8 насалж байгаа нь цагдаагийн алба хаагчийн дундаж наслалтаас 4.3 жилээр урт насалж байна. Эдгээр албанд ажиллаж байсан алба хаагчдын дундаж наслалтыг улсын дундаж наслалттай харьцуулан график №6-т үзүүлэв.

График №6 Албыг цагдаагийн дундаж наслалт болон улсын дундажтай харьцуулсан судалгаа



Дээрх судалгаанаас үзэхэд гэмт хэрэгтэй тэмцэх албанд ажиллаж байсан алба хаагч монгол хүний дундаж наслалтаас 6.6 жил, хэв журмын албанд ажиллаж байсан алба хаагч 2.1 жилээр тус тус богино насалж байгаа бол захиргаа удирдлагын алба хаагчид 1.2 жилээр урт насалж байна. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах чиг үүрэг гүйцэтгэдэг алба хаагчид нь ажлын ачаалал их, стресс, эрүүл мэндийн нөхцөл байдлаас шалтгаалан богино насалдаг байж болох талтай.

Цагдаагийн албанд ажиллаж байгаад нас барсан алба хаагчдыг цолны ангиллаар нь харьцуулан үзвэл ахлах офицерийн дундаж наслалт 66, дунд офицер дундаж наслалт 71, цагдаагийн ахлагч буюу цагдаагийн ахлах ахлагч цолтой алба хаагч нарын дундаж наслалт 67.8 гэсэн судалгаа гарч байна. График №7


График №7 Наслалтыг албан хаагчийн цолоор харьцуулсан судалгаа



Дээрх судалгаанаас харахад дунд офицер ахлах офицeroос 5 жилээр, ахлагчаас 3.2 жилээр урт насалдаг байна. Эдгээр насралтын шалтгаан нь дунд офицер байхдаа байхдаа тэтгэвэрт гарсан алба хаагчдын цагдаагийн албанд ажилласан жил нь ахлах офицер, ахлагчтай харьцуулахад харьцангуй бага байна. Өөрөөр хэлбэл албаны онцлогтой холбоотой сөрөг нөлөөлөлд өртөх эрсдэл бага байна.

Цагдаагийн албанд ажилласан жил, насралтад хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэх зорилгоор ажилласан жил, тэтгэвэрт гарснаас хойш амьдарсан хугацааг харьцуулан үзсэн болно. Цагдаагийн албанд 25 жил ажилласан алба хаагч тэтгэвэрт гарснаас хойш дунджаар 17.3 жил амьдраад нас барж байна. Энэ монгол хүний дундажтай харьцуулахад 1.2 жилээр богино гэсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлтийг хүйсийн байдлаар нь харьцуулан авч үзвэл 25 жил ажилласан эрэгтэй алба хаагч тэтгэвэрт гарснаас хойш 19.2 жил амьдардаг бол 22.4 жил ажилласан эмэгтэй алба хаагч тэтгэвэрт гарснаас хойш 23.1 жил амьдарч байгаа нь эрэгтэй хүнтэй харьцуулахад 3.9 жилээр урт насалж байна. Эндээс дүгнэхэд цагдаагийн албанд урт ажиллах тусам амьдрах хугацаа богиносдог гэсэн дүгнэлтэд хүрч болно. Гэхдээ өөр хүчин зүйлс нөлөөлдөг гэдгийг үгүйсгэх аргагүй юм. График № 8

График №8 Тэтгэвэрт гарснаас хойш амьдарсан хугацааг ажилласан жилтэй харьцуулсан судалгаа



Дээрх судалгааг цагдаагийн төрөл албадаар харьцуулан авч үзвэл захиргаа удирдлагын албанд ажиллаж байсан алба хаагч тэтгэвэрт гарснаас хойш хамгийн урт амьдарсан байна. График №9

График №9 тэтгэвэрт гарснаас хойш амьдарсан хугацааг ажилласан жилтэй харьцуулсан судалгаа, албаар




Дээрх судалгаанаас харахад гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам хамгаалах албанд ажилласан алба хаагчийн ажилласан жил нэмэгдэх тусам тэтгэвэрт гарснаас хойш амьдрах хугацаа богиносж байна. Харин захиргаа удирдлагын чиглэлээр ажилласан алба хаагч тэтгэвэрт гарснаас хойш хамгийн удаан буюу 20.6 жил насалж байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх албанд ажилласан алба хаагчтай харьцуулахад 2.9 жил, хэв журмын алба хаагчтай харьцуулахад 3.5 жилээр урт насалж байна.

Харин бидний судалгаанд хамрагдсан нас барсан алба хаагчдын дунд хэв журмын албанд ажиллаж байсан алба хаагч олон байсантай холбоотойгоор дээрх хүснэгтэд хэв журмын алба, гэмт хэрэгтэй тэмцэх албаны алба хаагчдын тэтгэвэрт гарснаас хойш амьдарсан хугацааг харьцуулахад гэмт хэрэгтэй тэмцэх алба урт насалсан мэт харагдаж байна. Үүнийг шалгах зорилгоор хэрэв гэмт хэрэгтэй тэмцэх албанд 25.7 жил ажилласан бол тухайн алба хаагч хэд насалж болох талаар тооцоолол хийж үзэхэд 17.1 жил амьдрахаар байна. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгтэй тэмцэх албанд 1 жил ажиллах тутамд 4 сараар амьдрах хугацаа богиносж байна.

Алба хаагчдын наслалтад цол хэрхэн нөлөөлж байгааг тогтоох зорилгоор тэтгэвэрт гарснаас хойш амьдарсан хугацааг цолоор харьцуулан үзлээ. График №10.

График №10. Цагдаагийн алба хаагчдын дундаж наслалт түүнд хийсэн судалгаа /2013-2017/



Судалгаанаас үзэхэд ажилласан жилтэй нь харьцуулахад ахлах офицер тэтгэвэрт гарснаас хойш хамгийн богино хугацаанд амьдарч байна. Мөн дунд офицер тэтгэвэрт гарснаас илүү урт насалж байгаа бол ахлагч бүрэлдэхүүн 17.8 жил насалж байна. Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүнд ажиллаж байгаа алба хаагч нарыг хийсэн судалгаан дээрээс дүгнэхэд Цагдаагийн байгууллагад ажилласан жил нь дунд офицер бүрэлдэхүүнийг бодвол дунджаар 7 сараар их буюу 24 жил ажиллаж байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх албанд ажиллаж байгаа алба хаагч нараас их дасгал хөдөлгөөн ихтэй, байнгын дарамт, стресс бухимдалд ордоггүй, эрүүл мэндээ анхаарах цаг зав ихтэй зэргээс нөлөөлж байгаа нь харагдаж байна. Мөн тэтгэвэрт гарснаас хойш амьдарсан хугацааг нь харахад Хэв ахлах офицер бүрэлдэхүүнээс дунджаар 3 сараар амьдрах хугацаа нь өндөр байгаа нь ахлагч бүрэлдэхүүнд залуу насны алба хаагч нар ажилдагаараа ялгагдаж байна.

Цагдаагийн дунд офицертой, ахлагч бүрэлдэхүүний тэтгэвэрт гарснаас хойш амьдарсан хугацааг нь харьцуулан үзэхэд дунджаар 4 жил 7 сараар ахлагч бүрэлдэхүүн бага амьдарч байгаа нь харагдаж байгаагаас үзэхэд ахлагч бүрэлдэхүүн нь хөдөлмөрийн хүнд нөхцөлд байдалтайгаар ажилладаг нь нөлөөлж байна гэж үзэж байна.



Цагдаагийн ахмад настны 80 орчим хувь нь амьжиргааны дунд зэрэг, нэн ядуу түвшиний хүмүүс байгаа нь тэдний насжилтийн байдалд нөлөөлөх тул цагдаагийн байгууллагаас тэднийг нийгмийн халамжид хамрагдах байдлыг судлах, дэмжлэг үзүүлэх, байгууллагын зүгээс мөнгөн ба материаллаг зүйлээр дэмжиж туслах, ар гэрийн хүмүүсийг нь ажилд ороход туслалцаа үзүүлэх зэргээр амьжиргааны түвшинг нь дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авахад анхаарах шаардлагатайг харуулж байна.

Ахмад настны тэтгэврийн байдлын судалгаанаас үзэхэд тэтгэвэр авагчдын 90 хувь нь бүрэн тэтгэврийн доод хэмжээтэй болон доод хэмжээнээс дээгүүр байгаа бөгөөд 10 хувь нь 250,0 төгрөгөөс дээш тэтгэвэр авч байгаа бол үлдэх 90 хувь нь энэ хэмжээнээс доогуур тэтгэвэр авч байгаа нь харагдаж байна. Энэ нь өргөн хэрэглээний барааны үнийн өнөөгийн байдалтай харьцуулахад амьжиргааны хэрэгцээг нь хангах боломжгүй байгааг харуулж байна.

Дүгнэлт

Судалгааны ажлын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтэд хүрсэн. Үүнд

1. Цагдаагийн алба хаагч, ялангуяа гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй эрэгтэй алба хаагчид хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд хөдөлмөрийн хуулийн зохицуулалтад хамаарахгүй, ажлын ачаалал, түүнээсээ үүдэн стресс өвчлөлд өртөх, эрүүл мэндийн туслалцаа үзлэг, оношилгоонд хамрагдах боломж хомсдолтой улмаас Монгол хүний дундаж наслалтын түвшинд хүрэхгүй байна.
2. Цагдаагийн алба хаагчийн дундаж наслалт 66.5 гэсэн үзүүлэлттэй байгаа бол эрэгтэй алба хаагчдын дундаж наслалт 60, эмэгтэй алба хаагчийн дундаж наслалт 70 гэсэн судалгаа гарч байна. Цагдаагийн алба хаагчдын дотроос “Гэмт хэрэгтэй тэмцэх албанд ажиллаж байсан алба хаагчдын наслалт 63.3 гэсэн үзүүлэлттэй байгаа нь цагдаагийн алба хаагчдаас 3.2 жил, улсын дунджаас 6.3 жилээр богино насалж байна.
3. Цагдаагийн албанд 25 жил ажилласан алба хаагч тэтгэвэрт гарснаас хойш дунджаар 17.3 жил амьдраад нас барж байна. Энэ монгол хүний дундажтай харьцуулахад 1.2 жилээр богино гэсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлтийг хүйсийн байдлаар нь харьцуулан авч үзвэл 25 жил ажилласан эрэгтэй алба хаагч тэтгэвэрт гарснаас хойш 19.2 жил амьдардаг бол 22.4 жил ажилласан эмэгтэй алба хаагч тэтгэвэрт гарснаас хойш 23.1 жил амьдарч байгаа нь эрэгтэй хүнтэй харьцуулахад 3.9 жилээр урт насалж байна.
4. Гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам хамгаалах албанд ажилласан алба хаагчийн ажилласан жил нэмэгдэх тусам тэтгэвэрт гарснаас хойш амьдрах хугацаа богиносож байна. Харин захиргаа удирдлагын чиглэлээр ажилласан алба хаагч тэтгэвэрт гарснаас хойш хамгийн удаан буюу 20.6 жил насалж байгаа нь гэмт хэрэгтэй тэмцэх албанд

- ажилласан алба хаагчтай харьцуулахад 2.9 жил, хэв журмын алба хаагчтай харьцуулахад 3.5 жилээр урт насалж байна.
5. Гэмт хэрэгтэй тэмцэх албанд ажиллаж байсан хүмүүсийн нас барсан шалтгааныг авч үзвэл бөөрний үрэвсэл, ходоодны архаг үрэвсэл, элэгний вирусийн гаралтай үрэвсэл, хатуурал, зүрхний судасны нарийсал, даралт ихсэх зэрэг хууч өвчнөөс үүсэлтэй эмгэгээр нас баржээ.
 6. Цагдаагийн албан хаагчийн наслалтад ажлын байрны нөхцөл, хэт удаан цагаар амралтгүй ажиллах, нийгмийн сэтгэхүйн нөлөөлөл өөрөөр хэлбэл ажлын нөхцөл байдлаас стресс, дарамтад орох зэрэг нь сөргөөр нөлөөлж буй хүчин зүйл гэдгийг судалгаан дээр үндэслэн гаргалаа.
 7. Цагдаагийн албан хаагчийн наслалтын байдалд нөлөөлөх хүчин зүйлийн чухал хэсэг нь албан хаагчийн нийгмийн баталгааг хэрхэн хангаж чадаж байгаатай салшгүй холбоотой байдаг байна. Цагдаагийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг шинэчлэх талаар төрөөс бодлогын шинжтэй алхмуудыг хийж анхаарал хандуулж байгаа боловч хууль тогтоомжийг боловсронгуй болгох, үйл ажиллагааг шинэчлэн үр дүнг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг хийх шаардлагатай байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.
 8. Дундаж наслалтаараа тэргүүлэгч хөгжингүй орны иргэд чанартай хоол хүнс хэрэглэхийн зэрэгцээ, амьдралын зөв хэвшлийг баримталж, эрүүл мэндийн өндөр түвшний тусламж үйлчилгээг цаг алдалгүй авч чаддаг нь урт наслах үндэс болдог. Харин энэхүү урт наслах амьдралын хэв маягт өндөр орлого бүхий хуримтлалаас бүрдсэн санхүүгийн тогтвортой, баталгаатай байдал чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Харин манай улсын хувьд цагдаагийн алба хаагчид санхүүгийн тогтвортой байдал бүрдээгүй, ажиллах нөхцөл, амьдралын зөв хэв маяг тогтоогүй зэрэг нөхцөл байдал судалгаагаар тогтоогдож байна. Тухайлбал “Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээ-2017” судалгааны дүнгээс үзэхэд “цагдаагийн алба хаагчийн цалин, төрөөс үзүүлж буй дэмжлэг нь амьдрал ахуйд хүрэлцэхүйц байдаг” гэсэн асуултад алба хаагч сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлсэн бол ажлын ачаалал их стресс ихтэй, орон тоо хүрэлцээгүй гэдэг дээр мөн сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлжээ⁹⁸.

Санал

1. Улсын хэмжээнд цагдаагийн алба хаагчийн дундаж наслалтын судалгааг жил бүр явуулж, нэгдсэн санг Цагдаагийн Ерөнхий Газрын хүний нөөцийн хэлтэст төвлөрүүлж байх;
2. Цагдаагийн алба хаагчийн дундаж наслалтыг тооцохдоо тэтгэвэрт гарснаас хойш тухайн алба хаагчийн амьдарсан хугацааг харгалзан тооцох аргачлалыг ашиглаж, улсын дундажтай харьцуулж байх;
3. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын дундаж наслалтыг Монгол Улсын хүн амын дундаж наслалтаас доогуур байгааг харгалзан “алба хаагчдын эрүүл мэнд, нийгэм хамгааллыг дэмжих хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох;
4. Алба хаагчдын хөдөлмөрлөх нөхцөлийн аюулгүй байдал, эрүүл ахуй гэдэг ойлголтыг цагдаагийн албаны онцлогт нийцүүлэн оновчтой томъёолж, Цагдаагийн байгууллагын хэмжээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, эрсдэл бүхий ажлын байрыг илрүүлэн хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах;
5. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340 дүгээр тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж хэвшүүлэх. Уг тушаалын хоёрдугаар хэсрэлтээр батлагдсан ажил, мэргэжлээс хамааран эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалтын дагуу гадаа гүйцэтгэдэг ажил, галт зэвсэгтэй харьцаж ажилладаг ажил, цэрэгжүүлсэн албаны алба хаагчдын эрүүл мэндийн үзлэгийн хуудсыг бэлтгэж, үзлэгт хамруулах ажлын зохион байгуулж байх.

⁹⁸ Нээлттэй нийгэм Форум. “Цагдаагийн байгууллага: хэрэглэгчийн үнэлгээ-2017” судалгааны ажлын тайлан, 191 дэх тал

- Эрүүл мэндийн хуудсыг хувийн хэрэгт хадгалах. Алба хаагчдыг үзлэгт хамруулсан талаар тайлан бичиж, цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж хэвших;
6. Тэтгэвэрт гарах алба хаагчдыг нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, тэтгэвэрт гарах сэтгэл зүйн бэлтгэлийн зөвлөгөө өгөх журмыг боловсруулан мөрдөх, тэтгэвэрт гарсан алба хаагчидтай эргэх холбоотой ажиллах эрх зүйн зохицуулалтыг цагдаагийн албаны тухай хуульд тусгах;
 7. Алба хаагчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл мэндтэй холбогдон гарах зардлыг тооцож, жил бүрийн төсөв тусгуулах.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ХӨТЛӨХ ЗӨРЧЛИЙН СТАТИСТИК, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Г.Гэрэлсүрэн

Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн мэдээлэл судалгааны
мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч, магистр

Удиртгал

Аливаа салбарын хөгжлийг хэмжих эцсийн шалгуур бол тухайн салбарын статистикийн судалгаа, мэдээ, мэдээллийн үнэн бодит байдал байдаг. Манай орны хувьд ч мэдээллийн эрин зуунд хүн төрөлхтөнтэй хөл нийлүүлэн алхаж дэлхийн чиг хандлага руу явж шинэ нөхцөл байдалд зохицон амьдрах хүмүүсийн ухамсарт төлөвшилийг мэдрэн зөрчлийн үнэн бодит тоо мэдээлэл дээр тулгуурлан цогц байдлаар судлах шаардлага улам бүр нэмэгдэж байгаа юм. Олон улсын түвшинд гэмт хэрэг, зөрчлийн статистикийг хамтад нь хөгжүүлж, боловсронгуй болгох асуудлыг онол, практикийн хүрээнд судалж ирсэн байна. Иргэд, олон нийтийн амгалан тайван байдал, аюулгүй байдлыг хангахад зөвхөн гэмт хэргийн талаар авч үзэх биш зөрчлийг давхар авч үзэх нь гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх цогц бодлого болох юм. Иймд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн бодлогыг тодорхойлоход Цагдаагийн байгууллагаас хөтлөх зөрчлийн статистикийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа тул Цагдаагийн байгууллагаас хөтлөх Зөрчлийн статистикийн талаар судалж өөрийн санал дүгнэлтийг судалгааны ажилд тусгалаа.

1.Цагдаагийн байгууллагаас хөтлөх зөрчлийн статистик

Монгол Улсын их хурлаас 2017 оны 2 дугаар сарын 9-нд баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн”⁹⁹ гэж тодорхойлсон.

Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх хэсэгт Цагдаагийн байгууллага нь нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд “Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хуулиар харьяалуулсан зөрчлийг шалган шийдвэрлэх, байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах”¹⁰⁰, мөн хуулийн 14.2.3-т “энэ хуулийн 61.1-д заасан мэдээллийн сан үүсгэх, ашиглах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах”, 14.2.4-д “Гэмт хэрэг, зөрчлийн гаралтын түвшин, хэв журмын нөхцөл байдлын талаар мэдээлэл боловсруулах, цагдаагийн байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах” гэж заасан нь цагдаагийн байгууллагаас зөрчил шалган шийдвэрлэх, олон нийтэд мэдээлэх, зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зөрчлийн мэдээг ашиглах эрх зүйн үндэс гэж үзэж болно.

Дээрх зохицуулалтаас үзэхэд цагдаагийн байгууллагаас зөрчилтэй тэмцэх ажиллагаа нь дараах 3 ажиллагаанаас бүрдэж байна. Үүнд:

1. Хуулиар харьяалуулсан зөрчлийг шалган шийдвэрлэх;
2. Зөрчлийн мэдээллийг хүлээн авах, бүртгэх;
3. Байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах зэрэг болно.

Хуулиар харьяалуулсан зөрчлийг шалган шийдвэрлэх гэж зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дах хэсэгт зааснаар цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагчаас тус хуульд заасан үндэслэл, журмын дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг ойлгоно¹⁰¹.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар эрх бүхий 28 албан тушаалтны зөрчил шалган шийдвэрлэх харьяаллыг тогтоосон. Харьяаллын дагуу Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч нь Зөрчлийн тухай хуульд заасан 71 зөрчлийг шалган шийдвэрлэхээр хуульчилсан байна.¹⁰² Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалалын

⁹⁹ Цагдаагийн албаны тухай хууль-Төрийн мэдээлэл УБ.,2017 №8

¹⁰⁰ Мөн хуулийн 11 дүгээр зүйл

¹⁰¹ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль-Төрийн мэдээлэл УБ.,2017. №24

¹⁰² Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль-Төрийн мэдээлэл УБ.,2017. №24

дагуу хамгийн олон зөрчил шалган шийдвэрлэхээр заасан эрх бүхий албан тушаалтныг эрэмблэн график 1-д үзүүлэв.

График 1. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан, харьяалах зөрчлийн тоогоор



Тайлбар: 10 ба түүнээс дээш зөрчил шалган шийдвэрлэх субъектын жагсаалтыг харуулсан.

Дээрх судалгаанаас үзэхэд зөрчлийн тухай хуульд заасан 436 зөрчлөөс 95 зөрчил буюу 21.7 хувийг Мэргэжлийн хяналтын улсын байцаагч, 71 зөрчил буюу 16.2 хувийг Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, 33 зөрчил буюу 7.56 хувийг Гаалийн улсын байцаагч шалган шийдвэрлэхээр зааснаас цагдаагийн байгууллага зөрчил шалган шийдвэрлэх тоогоороо 2 дугаарт орж байна.

Түүнчлэн 1.8 дугаар зүйлийн 1.8.7 дахь хэсэгт Эрүүгийн хэргийн шүүх Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг 8.6, 8.7, 10.5 дугаар зүйл, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.3, 15.4, 15.5, 15.7, 15.12 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулна. Мөн зүйлийн 9 дахь хэсэгт “Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу шүүгч харьяалан шийдвэрлэх зөрчлийн хэрэг бүртгэлтийг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ”¹⁰³ гэж заасан нь дээр дурьдсан 71 зөрчлөөс гадна 13 зөрчил, нийт 84 зөрчлийн статистик хөтлөх шаардлагыг бий болгож байна.

Дээрх эрх бүхий албан тушаалтнууд захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах үйл ажиллагаа явуулдаг хэдий ч зөрчил үйлдсэн этгээдийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй, тухайн зөрчил үйлдсэн этгээд хаана, хэдэн удаа зөрчил үйлдэж байгааг хянах боломжгүй юм. Өнөөдрийн байдлаар зөрчлийн шинж, чанар, зөрчил үйлдэгчийн талаарх судалгааг цагдаагийн байгууллагын нэгдсэн тоо бүртгэлээс авч судалгаа хийгдэж байгаа нь зөрчил, цаашилбал гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэстэй явуулах боломжгүйд хүрч байна.

ЦЕГ-ын даргын 2018 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн А/45 дугаар тушаалаар эрх олгох тухай заахдаа нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны ахлах байцаагч, байцаагч, эрүүлжүүлэх, саатуулах байрны дарга, эмч, хэсгийн

¹⁰³ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль/Төрийн мэдээлэл УБ.,2017.№24

байцаагч, эргүүлийн офицер, сум, баг, хорооны цагдаа, шуурхай удирдлагын алба /жижүүр/-ны жижүүрийн ахлах офицер, офицер болон урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах байцаагч, байцаагчид Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр бүлэгт заасан зөрчлөөс бусад зөрчилд, Замын цагдаагийн албаны үнэлгээ, хяналт шалгалт хариуцсан алба хаагч, зохицуулагчид мөн хуулийн 14 дүгээр бүлэгт заасан зөрчлийг, эрүүгийн мөрдөгч/ сум хариуцсан/-д зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.8 дахь заалтад заасан зөрчлийг шалган шийдвэрлэх эрх/ ердийн болон тусгай журмаар хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах/-ийг олгосон байдаг.

Зөрчил шалган шийдвэрлэх гэж зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих прокурорын хяналт, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг хэлнэ.

Төв, орон нутгийн цагдаагийн байгууллагууд, замын цагдаагийн алба, нийтийн хэв журам хамгаалах газар, олон нийтийн аюулгүй байдлыг хангах газар, Нийслэлийн цагдаагийн газрын (ХОХГХТХэлтэс, ХГХТХэлтэс, ХЖХХэлтэс, УСХэлтэс, ХХГХТТасаг), иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс, төмөр замын цагдаагийн хэлтсүүд зөрчил шалган шийдвэрлэсэн мэдээгээ нэгтгэдэг байна. Гэвч одоо Нийслэлийн цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх хэлтэс, нийтийн хэв журам хамгаалах хэлтэс, Хяналт шалгалт, үнэлгээ, ёс журмын хэлтэс, хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсүүд зөрчил шалган шийдвэрлэж байна¹⁰⁴.

Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагчийн шалган шийдвэрлэх зөрчлийг Зөрчлийн тухай хуульд заасан бүлэг тус бүрээр¹⁰⁵ нь үзвэл:

График 2. Зөрчлийн тухай хуульд зааснаар цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагчийн шалган шийдвэрлэх зөрчил



Дээрхээс үзэхэд Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагчийн шалган шийдвэрлэх зөрчлөөс нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил 35.2 хувь, нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэндийн эсрэг зөрчил 23.9 хувь, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчил 19.7 хувь тус тус эзэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Зөрчлийн мэдээллийг хүлээн авах гэж цагдаагийн байгууллага, алба хаагч нь иргэн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авах үйл ажиллагааг ойлгоно.

Зөрчлийн мэлээллийг бүртгэх гэж хүлээн авсан зөрчлийн тухай мэдээллийг тусгай бүртгэлийн маягтад бүртгэхийг ойлгоно.

¹⁰⁴ С.Энхбаатар “Гэмт явдлын статистик, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь: Цагдаагийн байгууллагын жишээн дээр” УБ. 2017 он

¹⁰⁵ Зөрчлийн тухай хууль// Төрийн мэдээлэл, УБ № 24

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд (хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг) заасан эрх бүхий албан тушаалтан дараахь тохиолдолд прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг эхлүүлнэ. Үүнд:

-хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад энэ хуулиар шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлсэн;

-хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас зөрчлийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн;

- зөрчил үйлдсэн хүн өөрийгөө илчилж ирсэн;


-байгууллага, албан тушаалтнаас харьяаллын дагуу зөрчлийн талаархи холбогдох баримтыг шилжүүлэн ирүүлсэн зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийг хүлээн авсан эрх бүхий алба хаагч ажлын 3 хоногийн дотор шалгаж харъяаллын дагуу шилжүүлэх, хүлээн авахаас татгалзах, хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх, зөрчлийн хэрэг нээх шийдвэрүүдийн аль нэгийг гаргасан даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.

Байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах гэж төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн удирдах ажилтан, алба хаагчдыг шаардлагатай мэдээлэл, лавлагаагаар хангах ажиллагаа юм. Зөвхөн цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн тоо мэдээг авч үзвэл:

Улсын хэмжээнд 2015 онд 1423088 зөрчил, 2016 онд 1038050 зөрчил, 2017 онд 1327017 зөрчил бүртгэгдсэн байна.¹⁰⁶ 2017 онд нийт 1327017 зөрчлийн мэдээлэл хүлээн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 288967 зөрчил буюу 27.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Зөрчлийн бүртгэлд авагдаж, шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан 1289466 иргэн, 44 албан тушаалтан, 823 аж ахуйн нэгж байгууллагад нийт 40.3 тэрбум төгрөгөөр торгож, 11345 хүнд баривчлах шийтгэл, торгож, эрх хассан 25316, баривчилж, эрх хассан шийтгэл 23-г ногдуулсан байна. Шийтгэл ногдуулсан 1314831 буюу 99.1 хувьд цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, 12186 буюу 6.3 хувьд шүүгч шийтгэл ногдуулсан байна. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 86497 хүн саатуулагдснаас 5521 буюу 6.3 хувь нь эмэгтэй, 271 буюу 0.3 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байна. Сайн дурын эмчилгээнд 2668 хүнийг хамруулсан байна. Цагдаагийн байгууллагад зөрчлийн статистик мэдээг хэрхэн цуглуулж, боловсруулж, ашиглах үе шатыг зураг №2-т үзүүлэв.

Зураг№2.Гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээг хэрхэн цуглуулж, боловсруулж, ашиглах үе шат

¹⁰⁶ Цагдаагийн ерөнхий газар, "Гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, 2016", УБ, 2017



Албан хаагийн шивж оруулсан мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд эсэхэд тасгийн дарга хяналт тавина. Баталгаажсан мэдээлэл цагдаагийн байгууллагын нэгдсэн санд төвлөрнө.

Цагдаагийн байгууллагын харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил нь дараах онцлог шинжтэй байна. Үүнд:

- Гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан нийгмийн хор аюулаар ялимгүй зөрчил

- Давтан үйлдсэн тохиолдолд гэмт хэргийн шинжийг агуулж болох зөрчил /хулгайлах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/

1. Цагдаагийн байгууллагын хөтлөх зөрчлийн статистик ба бусад байгууллагуудад хөтлөгдөх статистик мэдээллээс ялгагдах шинж

Прокурорын байгууллага хөтлөх зөрчлийн статистик нь гомдол мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгах ажиллагаанд тавих, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажиллагаанд тавих, зөрчил шалгах тодорхой ажиллагаанд тавих, зөрчил шалгах ажиллагааг дуусгах ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг агуулж байна¹⁰⁷.

Шинэчлэн батлагдсан хуулиудад нийцүүлэн Монгол улсын Ерөнхий прокурорын 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдөр №А/54 дугаар “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийн жагсаалт, загварыг батлах тухай” тушаалын хавсралтаар эрх бүхий албан тушаалтнаас үйлдэх 7 тэмдэглэл, 11 тогтоол, 5 санал, хүсэлт, тайлбар, баталгаа, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтнаас үйлдэх 6 тогтоол, Зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон эрх бүхий албан тушаалтны тогтоолыг хүчингүй болгож, нэмэлт ажиллагаа хийлгүүлэх тухай тогтоол /ЗШША-34/ зэргийн 39 зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны маягуудыг байгууллага дотроо батлан бүртгэж байна.

Мөн 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/66 дугаар “Зөрчил шалгаж шийдвэрлэх ажиллагаанд прокурор хяналт тавих харьяалал тогтоох тухай” тушаал, тушаалын хавсралтаар

¹⁰⁷ Б.Мөнхдорж “Прокурорын байгууллагын гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ” Гэмт хэргийн статистикийн онол, практикийн тулгамдсан асуудал эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, УБ., 2017, 192 дахь тал

харьяалалыг тогтоон холбогдох төв, орон нутгийн эрх бүхий албан тушаалтан, байгууллагаас маягтуудын дагуу мэдээ тайлан гаргадаг байна.

Түүнчлэн бүртгэлийн загвар батлах тухай ерөнхий прокурорын тушаалын дагуу Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тавьсан хяналтын бүртгэл /ЗХБ-1/, Зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад авсан эрх хязгаарлах арга хэмжээний бүртгэл /ЗХБ-3/ зэрэг зөрчлийн хэрэг бүртгэлийн маягтууд бүртгэгддэг. Дээрх маягтуудын дагуу бүртгэгдсэн зөрчлийн мэдээ нь Улсын ерөнхий прокурорын газарт нэгтгэгдэж, статистик мэдээлэл боловсруулан гаргадаг байна.

Харин *шүүхийн байгууллагаас хөтлөх зөрчлийн статистикийн онцлог* нь зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан зөрчлийг харьяалан шийдвэрлэж, хууль, хэм хэмжээний актыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд оногдуулсан зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийн цогц үзүүлэлтийг нэгдсэн аргачлалаар цуглуулж, боловсруулахад чиглэгддэг. Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлөөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолоор баталсан Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журам /ШЕЗ-ийн 2008 оны 17дугаар тогтоол/-ын дагуу 13 төрлийн мэдээний маягтаас зөвхөн 1 захиргааны хэргийн маягт хамаардаг байна¹⁰⁸.

Шүүх байгууллага дахь захиргааны зөрчлийн үзүүлэлтэд, зөрчилд арга хэмжээ авахуулахаар ирсэн хэрэг, зөрчилд арга хэмжээ авсан тоо, шийдвэрлэлтийн төрөл, хуулийн этгээд, эмэгтэй, 18 насанд хүрээгүй хүн, албадлагын арга хэмжээ хэрэглэсэн, хүнийг саатуулах арга хэмжээ авсан, барьцаагаар сольсон тоо, давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн үзүүлэлтээр шүүхийн байгууллагын зөрчлийн статистикийн тоон мэдээг хөтөлдөг байна.

Харин Цагдаагийн байгууллагаас хөтлөх зөрчлийн үзүүлэлтэд зөрчлийн нийт тоо, төрөл, шийдвэрлэлтийн төрөл, шалгасан зөрчил түүний шийдвэрлэлт, шийдвэрлэсэн байгууллага, газар, өдөр, цаг, нийгмийн байдал, нас, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, гэр бүлийн хамаарал, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн тоо, гэр бүлийн хамаарал, зөрчил гаргасан хуулийн этгээдийн тоо, зөрчлийн улмаас хохирсон хүн, гэр бүлийн хүчирхийлэлд хохирсон хүн, зөрчлийн улмаас хохирсон хуулийн этгээд, учирсан хохирол гэсэн үзүүлэлтээр зөрчлийн статистик мэдээг гаргадаг байгаад шинэчлэгдсэн зөрчлийн тухай хуульд нийцүүлэн өгөгдлүүдийг нэмж ердийн журмаар шийдвэрлэсэн, зөрчлийн шийдвэрлэлтийг зөрчлийн тухай хуулийн зүйл заалт бүрээр, хялбаршуулан шалгах журмаар шийдвэрлэсэн, зөрчлийн хэрэг үүсгэн шалгасан зөрчлийг нэмэгдэл шийтгэл ногдуулсан хэлбэр бүрээр нь, гадаадын иргэн, албан тушаалтан, байгууллага, аж ахуйн нэгжийн гаргасан зөрчил түүний шийдвэрлэлт, шийтгэврээр шийтгэл ногдуулсан хүн, зөрчил гаргагчийн онцлог зэрэг зүүлэлтүүдийг нэмж 33 үзүүлэлтээр гаргаж байна¹⁰⁹.

Дээрх зөрчлийн үзүүлэлтүүдийг харьцуулан нийтлэг болон ялгаатай талыг харвал: *Нийтлэг тал*: Улсын хэмжээнд дүн мэдээ нэгтгэгддэг бөгөөд шийдвэрлэлтийн төрлөөр гардаг. *Ялгаатай тал*: Зөрчлийн бүртгэл нь цагдаагийн байгууллагаас эхлэлтэй боловч шийдвэрлэлтийн хувьд цагдаагийн байгууллагаас гадна шүүхээс шийдвэрлэдэг тул цагдаагийн байгууллагын статистикт шийдвэрлэсэн байгууллагаараа тус тусдаа үзүүлэлт болон гардаг бол шүүх байгууллагад зөвхөн шүүхээс шийдвэрлэсэн зөрчлийн тоо үзүүлэлтээр гардаг.

Цагдаагийн байгууллагын онцлог, өөрийн чиг үүрэгтэй холбоотойгоор зөрчлийн шийдвэрлэлтийн задаргаа болсон үзүүлэлт нь зөрчил үйлдэгдсэн газар, цаг, гараг, нийгмийн байдал, нас, боловсрол, гэр бүлийн хамаарал болон хуулийн зүйл хэсэг бүрээр задарсан байна. Энэ нь Цагдаагийн байгууллагаас хөтлөх статистикийн онцлог шинж юм.

Харин Шүүхийн байгууллагын зөрчлийн статистикт цагдаагийн байгууллагын статистикт заасан энэхүү онцлог үзүүлэлтэд зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан зүйл заалт нэг бүрээр нь үзүүлэлт болгон гаргахаар тусгасан бөгөөд шүүхийн

¹⁰⁸ Г.Уянга. “Шүүхийн байгууллага дахь гэмт хэргийн статистикт хийсэн дүн шинжилгээ” Гэмт хэргийн статистикийн онол, практикийн тулгамдсан асуудал эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, УБ., 2017, 41 дахь тал

¹⁰⁹ Г.Отгонзул “Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистикийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ”, Гэмт хэргийн статистикийн онол, практикийн тулгамдсан асуудал эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, УБ., 2017, 129 дахь тал

үйл ажиллагааны онцлогоос хамаараад давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн зөрчлийн тоо, түүний шийдвэрлэлтийн үзүүлэлт гаргадаг онцлогтой байна.

Цагдаагийн байгууллагаас хөтлөх зөрчлийн статистик мэдээллийг нөхөх зааварт тухайн мэдээллийн давтамж хийгээд мэдээллийг хаана хүргэх, мөр болон баганын үзүүлэлт тус бүрт ямар мэдээллийг хамруулж дэлгэрэнгүй байдлаар бүртгэл хийх, бүртгэгдсэн мэдээллийг үнэн зөв, бодит байдлыг шалгах зорилгоор балансын задаргааг тус тус багтаасан байдаг.

Зөрчил, түүний шийдвэрлэлтийн мэдээллийг зөрчлийн хэрэг бүртгэлийн маягт Б-3-3100, Зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийн бүртгэлийн маягт Б-3-3112, Зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон бүртгэлийн маягт Б-3-3113, Торгуулийн хуудсаар торгох шийтгэл ногдуулсан бүртгэлийн Б-3-3100, Зөрчлийн улмаас хохирсон хүн хуулийн этгээдийн бүртгэлийн маягт Б-3-3102-д үндэслэн боловсруулдаг. Маягт нөхөх зааварт зааснаар зөрчил-бүгд, тухайн сард бүртгэгдсэн зөрчил, шийдвэрлэсэн зөрчил-бүгд, ердийн журмаар шийдвэрлэсэн, зөрчлийн хэрэг үүсгэн шалгасан зөрчил, цагдаагийн алба хаагчийн шийдвэрлэсэн зөрчил, шүүгчийн шийдвэрлэсэн зөрчил, зөрчил үйлдэгдсэн газар, гараг, цаг, зөрчил үйлдэгдэх үеийн байдал, зөрчил гаргасан хүн бүгд, хөдөлмөр эрхлэлтийн байдал, боловсрол, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, зөрчил гаргасан хуулийн этгээд бүгд, зөрчлийн улмаас хохирсон хүн бүгд, хохирсон хүний байдал, хохирсон хуулийн этгээд бүгд, учирсан хохирол, нөхөн төлүүлэлтийн хувь” гэсэн үзүүлэлтүүдээр зөрчлийн мэдээг гаргахаар заасан байдаг.

Дүгнэлт

1.Дэлхийн олонх улсад “жигжиг гэмт хэрэг” буюу зөрчил хэмээн тодорхойлдог эрүүгийн эрх зүйн ухагдахууныг манай улс олон салбар эрх зүйн зангилаан дээр олон хуулиар салангид зохицуулж байсан. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг нэг стандартад оруулах зорилгоор хүчин төгөлдөр үйлчилж байгаа 230 гаруй хуульд заасан зөрчлийг төрөлжүүлэн нэгтгэж 625 төрлийн зөрчлийг хуульчилсан Зөрчлийн тухай хууль батлагдсан нь цаашид зөрчлийн статистикийг нарийвчлан судлахад чухал ач холбогдолтой болсон.

2.Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль нь хоёр өөр зохицуулалтаар шийдвэрлэгдэж байгаа тул зөрчил судлалыг Монгол улсад бие даасан байдлаар хөгжүүлсэнээр зөрчлийн шинж чанар, зөрчил үйлдэгчийн зан байдлыг судалсаны дүнд зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой зохион байгуулах боломжтой юм. Түүнчлэн зөрчлөөс үр нөлөөтэй урьдчилан сэргийлж чадсанаар гэмт хэргийн гаралт буурч, иргэдийн амар тайван амьдрах нөхцөл бүрдэх юм.

Иймд зөрчил үйлдэж байгаа этгээд, иргэдийн үйлдсэн зөрчлийн шинж чанарыг судалж, тухайн зөрчлөөс урьдчилан сэргийлэх оновчтой арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай байгаа тул Зөрчил судлалыг хөгжүүлэх нь зүйтэй юм.

3.Цагдаагийн байгууллага нь зөрчлийн тоо бүртгэл хөтөлдөг бусад байгууллагатай жишиж үзвэл мэдээллийн сангийн бүрдүүлэлт, суурь бааз сайн, хууль сахиулах байгууллагын зөрчлийн нэгдсэн санг үүсгэх, зөрчил үйлдэж шалгагдсан эсэх лавлагаа авах боломжтой болох нь харагдаж байна. Харин мэргэшсэн чиглэлээр ажиллаж байгаа алба хаагчд цөөн, мэдээллийн сангийн ачаалал, сүлжээний хурднаас шалтгаалан мэдээ, мэдээлэл боловсруулах үйл явц удаашралтай, цагдаагийн байгууллагаас хөтлөх зөрчлийн бодит статистик үзүүлэлт гаргахад нөлөөлж болзошгүй зарим эрсдэл байна.

4.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулинд заасан зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын хамтарсан тушаал, шийдвэр байдаггүйгээс Улсын прокуророос олгож байгаа зөрчлийн хэргийн дугаар цагдаагийн байгууллагын өөрийн авсан дугаараас бусад нь мэдээллийн санд ордоггүй байна.

5.Зөрчлийн статистикийн хувьд төдийлөн ач холбогдол өгдөггүй дүн мэдээ нэгтгэгдэн гардаг боловч зөрчлийн мэдээг Үндэсний статистикийн хорооны мэдээнд хэвлэгддэггүй, нийтэд хүртээмжтэй байдлаар дэлгэрэнгүй мэдээлэл нийтлэгддэггүй.

Санал

1. Зөрчлийн статистикийг хөгжүүлэхэд шинэчлэн батлагдсан хуулиудын зарим заалтууд дээр дээд шүүхийн болон шинжлэх ухааны тайлбарыг даруй хийх, зөрчлийн статистикийг боловсронгуй болгоход судлаач, практик ажилтнуудын анхаарлыг хандуулах;
2. Зөрчлийн мэдээллийн сангийн үзүүлэлтийг дэлгэрэнгүй байдлаар улам боловсронгуй болгох, Зөрчлийн тухай хуульд нийцүүлэн боловсруулах;
3. Завхан аймаг дахь Цагдаагийн газрын Тосонцэнгэл дэх цагдаагийн хэлтэс, Ховд аймаг дахь Цагдаагийн газрын Булган сум дахь цагдаагийн хэлтэс, Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын Бор-өндөр дэх цагдаагийн хэлтсүүд, нийслэлийн Багахангай дүүрэг дэх цагдаагийн тасаг, Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэст мэдээлэл судалгааны чиглэлээр ажиллах алба хаагчийн орон тоо бий болгох;
4. Орон нутгийн цагдаагийн газар хэлтсийн зөрчлийн тоо бүргэгчийг офицер орон тоотой болгох;
5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулинд заасан зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын дарга нарын хамтарсан тушаал, шийдвэр гарган хэрэгжилтийг хангаж, Улсын хэмжээнд бүртгэгдсэн зөрчлийн нийт мэдээг уялдаа холбоотойгоор нэгтгэн боловсруулдаг цогц тогтолцоотой болох.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Ц.Очгэрэл

*ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн
профессорын багийн профессор, доктор (Ph.D), хурандаа*

Товч агуулга: Монгол Улсын дотоод аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг, оролцоо бүхий хорих байгууллагын аюулгүй байдлыг хангахад аливаа аюул, эрсдэлийг үнэлэх, улмаар түүнээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг бууруулах асуудал чухал нөлөө үзүүлэх нь зайлшгүй юм. Энэхүү илтгэлээр хорих байгууллагын аюулгүй байдал ба аюул, эрсдэлийг үнэлэх ажиллагааны хамаарлын асуудлыг хөндөн өөрийн байр суурийг илэрхийлэхийг зорилгоо.

Түлхүүр үг: Хорих байгууллага, аюулгүй байдал, аюул, занал, эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, аюулгүй байдлыг хангах ажиллагаа.

Төрийн эрүүгийн бодлогын салшгүй нэг хэсэг болох эрүүгийн ялын хэрэгжилтийн талаар судалдаг хэн бүхний өмнө нийгэм, улс төр, эдийн засаг, олон улсын харилцааны өвөрмөц нөхцөл байдал бүхий өнөө цагт олон талаас нь судлан шинжилвэл зохих, мөн чанар, агуулгыг илүү ойлгомжтой болгон онол, практикт нэвтрүүлэх шаардлагатай судлагдахуунууд байсаар байна. Тухайлбал, эрүүгийн ялын шинэчлэгдсэн зорилго, шинэ төрлийн эрүүгийн ялын төрөл, түүний гүйцэтгэл, хорих байгууллагын аюулгүй байдал судлал, бодлого судлал, харьцуулсан судлал, пробацийн үйл ажиллагаа гэх мэт цөөнгүй чиглэлийг дурьдаж болно.

Чухам иймээс судлаачийн зүгээс сүүлийн жилүүдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал дахь чухал судлагдахуун болох хорих байгууллагын аюулгүй байдал, түүний үндсэн ухагдахуун, агуулга, тогтолцоо, бусад судлагдахуунуудтай харилцан хамаарах асуудлуудыг хөндөн судалж байгаа бөгөөд энэ илтгэлээр өөрийн судалгааны ажлын зарим үр дүнг судлаач, эрдэмтэдтэй хуваалцах зорилт тавилаа.

Хорих байгууллагын аюулгүй байдлын талаар судлахын тулд юуны түрүүнд хорих байгууллага хэмээх ухагдахуун түүний хамрах хүрээг тодотгон үзэх зайлшгүй шаардлагатай болдог. Хорих байгууллага гэж юу вэ? Энэ талаар хуулийн томъёоллыг анх 1993 онд батлагдсан “Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай хууль”-д тусгаж өгч түүнд хорих анги, гяндан, эмнэлэг, хугацаагүй хорих, дамжин өнгөрүүлэх болон хорих байгууллагуудыг удирдах газрыг хамааруулан хуульчилсан байдаг¹¹⁰ бөгөөд өнөөдрийг хүртэл дараагийн хуулиудад уламжлагдан батлагдсаар ирсэн байдаг.

Хэдийгээр хууль зүйн талаас авч үзвэл зөвхөн шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ял шийтгэгдсэн хүнийг нийгмээс тусгаарлан хорих чиг үүрэг бүхий газрыг хорих байгууллага хэмээн нэрлэхээр ойлгогдож байгаа хэдий ч судлаачийн зүгээс шүүхийн шийдвэрээр баривчлагдсан, цагдан хоригдсон хүнийг хорих байр ч мөн адил хорих байгууллагад хамаарах зүй тогтолтой гэж үзэж байна. Учир нь цагдан хорих, баривчлах байр нь мөн адил шүүхийн шийдвэрээр хүний чөлөөтэй зорчих болон бусад эрхийг хязгаарлаж, тусгай зориулалт, хяналт, хамгаалалт бүхий байранд тусгаарладаг.

Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлын шаардлага, үндэслэл, хэрэгжүүлж буй субъект, аюулаас хамгаалагдвал зохих объект, аюулгүй байдлыг хангах ажиллагааны зорилго, тогтолцоо, арга, хэрэгсэл, хоригдогч, ялтныг тусгаарлах орчны стандарт, нүүрлэж буй аюул,

¹¹⁰ А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж. УБ., 2014. 120 дахь тал.

занал эрсдэлийн шинж, төрөл зэргийн хувьд адил байх зүй тогтолтой учир хорих байгууллага гэсэн нэгдсэн томъёололд нэгтгэн авч үзэх нь зүйтэй.

Эндээс хорих байгууллагын үйл ажиллагааг хөгжин өөрчлөгдөж буй шинжлэх ухааны чиг хандлага, түүний дотор хүн, нийгэм, төр, байгууллага, хүрээлэн буй орчны зэрэг бүхий л түвшний зүйлсийн хэвийн, аюулгүй оршин тогтнох үндсийг судалдаг аюулгүй байдлын тухай онол, сургаалтай уялдуулан авч үзэж хөгжүүлэх шаардлага хэдийнээ бий болжээ.

Хүн, нийгэм, төр улс болон байгаль, дэлхийн оршин тогтнох зүй тогтол дахь үнэт зүйлсийг хамгаалан хөгжүүлэх шаардлага алхам тутамд тулгарч, түүнд учирч болох аюул, заналын шинж чанар өөрчлөгдөн хувьсаж байна¹¹¹. Үүнээс үүдсэн аюулгүй байдал судлал эрчимтэй хөгжиж байгаа өнөөгийн нөхцөлд нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг нийгмээс тусгаарлан хорих чиг үүрэг бүхий хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах асуудлыг тусгайлан судалж хөгжүүлэх бодит шаардлага бий болоод байна.

Сэжигтэн, яллагдагч, ялтны дундаас албан хаагчийн үүрэг гүйцэтгэлт, улмаар албаны үйл ажиллагаанд нөлөөлөхийг оролдох, өөртөө ашигтай шийдвэр гаргуулахыг эрмэлзэх, албан хаагчийг янз бүрийн аргаар эрхшээлдээ оруулахыг хичээх гэх мэт хорих байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах зорилго бүхий үйлдлийг байнгын буюу тасралтгүй шинжтэйгээр үйлдэх явдал буурахгүй, тасралтгүй үйлдэгдсээр байна. Түүнчлэн хоригдогсод бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдэх, хорих байгууллагаас харуул хамгаалалтын эмзэг байдал, эсхүл тухайн анги, албаны үйл ажиллагааны сул талыг ашиглан хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийг эвдэх, зориулалтын саад, төхөөрөмжийг давж туулах замаар ганцаар болон бүлэглэн оргох гэмт хэргийг үйлдсээр байгаа албан ёсны тоо баримт, судалгаанаас харж болно¹¹².

Судлаачийн зүгээс хорих байгууллагын аюулгүй байдлын тухай ухагдахууныг өөрийн судалгааны ажлын үр дүнд дулдуйдан "хорих байгууллагын аюулгүй байдал нь байгууллагын оршин тогтнох, хөгжих хэрэгцээнд суурилсан, ял эдлүүлэх, баривчлах, цагдан хорих үйл ажиллагаа тасралтгүй, амжилттай хэрэгжих явц, зорилтод сөрөг нөлөөлөл үзүүлэх, улмаар алдагдуулж, ноцтой хор уршиг учруулж болзошгүй аюул, занал, эрсдэлт нөхцөл байдлыг урьдчилан судлах, үнэлэх, хор аюулыг бууруулах, таслан зогсоох, арилгах, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээний үр дүнгээр илэрхийлэгдэнэ" хэмээн үзсэн.

Эндээс хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоог бүрдүүлэгч нэг гол арга хэмжээ нь учирч болзошгүй аюул, занал, эрсдэлт нөхцөл байдлыг урьдчилан судлах, үнэлэх арга хэмжээ байх дүгнэлт гарч байна. Өөрөөр хэлбэл, аюул, эрсдэлийг үнэлэх асуудал нь хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтын үр дүн, аюулаас хамгаалагдах нөхцлийг бий болгох үндсэн арга хэмжээ байх юм.

Аюулгүй байдлыг хангах үндсэн шаардлагын үүднээс авч үзвэл аюул, эрсдэлийг үнэлэх арга хэмжээ нь бусад аюулгүй байдлын арга хэмжээний нэгэн адил харилцан бие биенээ нөхөх, харилцан хамаарах шинжийг агуулсан гол асуудлуудын нэг байдаг. Аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцоог бүрдүүлж буй арга хэмжээнүүд нь өөр хоорондоо харилцан холбоос, хамааралд оршино¹¹³.

Аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцооны энэ шинж нь аюул, заналхийллийг арилгах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, аюул, занал, сорил, эрсдэлийг үнэлэх зэрэг аюулгүй байдлын үндсэн зорилгыг үр дүнд хүрэхэд голлох үүргийг гүйцэтгэх зүй тогтолтой гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлын бүтцийг бүрдүүлэгч субъектүүдийн зүгээс аюулгүй байдлыг хангах арга хэмжээний харилцан ажиллагаа, уялдаа холбоогүй бий болгохгүйгээр оршин тогтнох, зорилтоо хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж болно.

Иймээс хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах дээрх арга хэмжээнүүд нь байнгын уялдаа холбоонд байх зарчмаар хэрэгжих бөгөөд аль нэг арга хэмжээг нөгөөгөөр орлуулж

¹¹¹ Д.Адъяабазар. Байгууллага, албан хаагчийн аюулгүй байдлыг хангахад шинэ хандлага чухал. Сүлд-Инфо. УБ., 2015.№01. 41 дэх тал.

¹¹² Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тогтоол гүйцэтгэх газрын тайлангаас үзвэл 2012-2014 оны хугацаанд хорих анги, цагдан хорих байрнаас 24 ялтан ганцаар болон бүлэглэн оргох гэмт хэрэг үйлджээ.

¹¹³ Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. УБ., 2014. 79 дэх тал.

гүйцэтгэх эсвэл орхигдуулах нь хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, аюулгүй байдлыг хангах үндсэн зорилт хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлтэй. Энэ нь хоригдогч, ялтанд гэмт санаа бодол, үйлдлээ хэрэгжүүлэх, хорих ангийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх боломж олгох, ноцтой гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох боломжгүй болох гэх мэтээр ноцтой үр дагавар учруулж болзошгүй юм.

Хорих байгууллагын аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлс, аюул, занал, сорил, эрсдэлийг үнэлэх ажиллагаа нь хэдийгээр аюулгүй байдлын удирдлагын үйл ажиллагааны нэг хэсэг мэт боловч ач холбогдол, шинж чанарыг харгалзан аргачлал болон онолын дүгнэлтийг нэгтгэн, бие даасан арга хэмжээийг түвшинд судлан, тодорхойлох нь чухамдаа аюулгүй байдлыг хангах ажиллагааг цогц хэлбэрээр, зөв бүрдүүлэх үндсэн хамаарлыг бий болгож байна.

Хорих байгууллагын аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэл гэж юу вэ?. Эрсдэл гэдэг нь хохирол учруулж болох гэнэтийн тохиолдол, алдагдал хүлээж болзошгүй байдал буюу ямар нэг тааламжгүй үйл явдал тохиолдох боломж, үүсэж болзошгүй сөрөг үр дагавартай холбоотой тодорхойгүй байдал, аюул, занал, сорилыг хэлнэ.

Эрсдэл гэдэг нь хүн, нийгэм, байгаль орчинд хохирол учруулж болох бодит хүчин зүйлүүдийн агуулах аюулын хэмжээг тусгасан ойлголт юм¹¹⁴. Эрсдэл нь өөртөө аюулт үйл явдлын үүсэх магадлал, түүнээс учрах хохирлын хэмжээг тусгаж байдаг. Энэ хэмжээс эрсдэлийн объектив тал болдог ба энэ нь тархинд тусаж аюулт нөхцөлд түүний түвшнийг тогтоож, шийдвэр гаргах хүний үйл ажиллагаатай холбоотой субъектив талыг бий болгодог.

Эрсдэлийн үнэлгээний асуудал нь анх байгалийн гамшиг, ослын үнэлгээг хийж, хор хохирол багатайгаар даван гарах зорилготойгоор үүсэн бий болсон гэж судлаачид үздэг. Эрсдэлийн үнэлгээ (risk assesment)-ний арга зүйг 1980-аад онд АНУ-д анх онолын хувьд нэгдмэл сургаал болгон гаргасан байдаг бөгөөд өнөөдрийн байдлаар бүхий л улс оронд түгээмэл ашиглаж байна¹¹⁵. Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд гамшгаас хамгаалах салбараас гадна төр, хувийн хэвшлийн бүхий байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн шинжилгээ¹¹⁶ хийх явдал түгээмэл болж, аюул, заналхийллээс урьдчилан сэргийлэхэд өргөнөөр ашиглах боллоо.

Монгол Улсад төдийгүй бүс нутаг, дэлхийн хэмжээнд байгаль, цаг уурын өөрчлөлт, хүний хүчин зүйлээс үүдэлтэй өөрчлөлтүүд, геополитик, гео эдийн засаг, улс төр, олон улсын харилцаа, технологийн хөгжлөөс үүдэлтэй шинэ төрлийн болон уламжлалт аюул, эрсдэлийн шинж чанар өөрчлөгдсөөр байна. Улмаар эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг шинжлэх асуудлууд эрсдэлийн удирдлага хэмээх өргөн хүрээтэй ойлголт болон хөгжиж байна.

Судлаачдийн зүгээс хорих байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явц нь дараах дараалалтай байна гэж үзжээ. Үүнд:

- Байгууллагын онцлог эрсдэлийг таньж, тодорхойлох;
- Эрсдэлийг хэмжих шалгуурыг тодорхой болгох;
- Тогтоосон шалгуурын дагуу эрсдэлийн нөлөөллийг хэмжих;
- Эрсдэлийн матрикс гаргаж, харилцан хамаарал, тоон ба чанарын шинж чанарыг ялгах, харилцан уялдааг тодорхойлох;
- Тодорхойлсон эрсдэлийн түвшнийг ангилж зэрэглэх;
- Зэрэглэлийн дагуу хариу арга хэмжээг тодорхойлох;
- Мониторинг хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний нөлөөг дүгнэх;
- Дахин эрсдэлээ үнэлэх гэсэн дараалалтай байна¹¹⁷.

Хорих байгууллагын эрсдэлийг үнэлэх асуудал нь урьдчилан сэргийлэх шинж чанартай байхын зэрэгцээ байнгын тасралтгүй үргэлжлэх хэлбэрээр явагдах зүй тогтолтой нь түүний үндсэн зорилго, үйл ажиллагааны онцлог шинжээс шууд шалтгаалдаг.

¹¹⁴ С.Хүрэлсүх, Х.Мягмаржав, Ч.Мэндэлмаа. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний зарим асуудлууд. УБ., 2014. 3 дахь тал.

¹¹⁵ Ш.Паламдорж нар. Гамшгийн эрсдэлийг үнэлэх арга зүй.УБ., 2013. 13 дахь тал.

¹¹⁶ Эрсдэлийн шинжилгээ гэдэг нь хувь хүн, хүн амын бүлэг, сонирхож буй объектууд болон хүрээлэн буй орчинд байх аюулыг илрүүлэн тодотгох, тэдгээрийн эрсдэлийг тогтоох үйл ажиллагааг хэлнэ.

¹¹⁷ Монгол Улсын Хууль зүйн сайдын 2013 оны 12 дугаар сарын 03-ны А/248 дугаар тушаал. Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал.

Хорих байгууллагын аюулгүй байдалд нөлөөлөх аюул, эрсдэлийг тодорхойлох ажиллагаа нь эрсдэлийн үнэлгээ хийх суурь нөхцөл болж өгнө. Эрсдэлийн үнэлгээ гэж үүсэх аюулын тухай тоон өгөгдлүүд, түүний шинж чанар, үүсэх магадлалыг тооцож, статистик шинжилгээний аргаар эрсдэлийн хэмжээг тодорхойлсныг эрсдэлийн үнэлгээ гэнэ¹¹⁸.

Эндээс эрсдэлийн хэмжүүр эрсдэлийг үнэлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь аюулын төрөл, эх сурвалж, түүнд өртөж болзошгүй объектын төрлөөс хамааран өөр өөр байна. Аюулгүй байдалд заналхийлж буй эрсдэл нь байгалийн, нийгмийн, улс төрийн, эдийн засгийн, техникийн, хүний үйл ажиллагааны гэх мэт олон төрөл байх бөгөөд дээр дурдсан эрсдэлийг үнэлэх аргуудаас аль тохирохыг сонгон хэрэглэж болох ба хэмжүүрийг харилцан адилгүй тогтоож болно.

Хорих байгууллагын аюулгүй байдалд нөлөөлөх аюул, эрсдэлийг үнэлэхийн тулд түүнийг тогтоох, зэрэглэх шаардлага гарна. Үүний тулд дараах үндсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ гэж үзэж байна. Үүнд:

- Аюулын хүрээг тогтоох.
- Үүсэх магадлалыг олох.
- Аюулын тухай мэдлэг, магадлалын тооцоо, хангамж, загварчлал, таамаглалд үүсэх тодорхойгүй байдлыг тогтоох.
- Аюул өрнөж байгаа байршлыг тогтоох.
- Үргэлжлэх хугацааг тогтоох.
- Давтагдах, дахих шинж чанарыг тогтоох.
- Мөчлөг нь ямар байхыг тодорхойлох зэргийг ашиглаж болох юм.

Түүнчлэн аюулыг шинжлэх, эрсдэлийг тодорхойлохын зэрэгцээ аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцооны чадавч, чанарт мөн үнэлгээ хийх шаардлага үүсдэг нь практик нөхцөл байдлаас харагдаж байна. Үүнийг судлаачид өртөнгө буюу эмзэг байдал хэмээн тодорхойлдог бөгөөд түүний нөлөөллийг аюул, эрсдэлтэй харьцуулан үнэлгээний аргачлал боловсруулсан байдаг.

Хорих байгууллагын хувьд хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх шинжийг агуулсан аюул, занал, эрсдэл нь бусад төрлийн байгууллагатай харьцуулахад өөрийн гэсэн онцлогийг агуулсан байдаг. Хорих байгууллагын аюулгүй байдлын эсрэг чиглэсэн аюул, эрсдэлийн зарим шинжийг авч үзвэл:

✓ Хүний хүчин зүйл давамгайлсан шинжтэй байх.

Өөрөөр хэлбэл, хоригдогч, ялтны зүгээс өөрийн хэрэгцээнд суурилсан, өөрт ашигтай байдал бий болгох зорилго бүхий идэвхитэй үйлдэл, эс үйлдэхүйг гэнэтийн байдлаар болон урьдаас төлөвлөн үйлдэх, бусдаар үйлдүүлэх, өдөөн хатгах, зохион байгуулах явдал тасралтгүй гарч байдаг. Түүнчлэн тэдгээрийн хань хамсаатан, ашиг сонирхолыг төлөөлөгч хүний зүгээс ч хорих байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчийн шийдвэрт нөлөөлөх оролдлого байсаар байна.

Хүний хүчин зүйлээс үүдэлтэй бас нэг чиглэл нь хорих байгууллагын албан хаагчийн мэргэжлийн чадвар, ёс суртахуун, мэдлэг, дадлага, туршлагаас үүдэлтэй аюул, эрсдэл юм. Хэдийгээр хорих байгууллагын үйл ажиллагаанд техник, технологийн дэвшлийг ашиглан аюулаас хамгаалах, даван туулах нөхцлийг бий болгодог боловч удирдлагын чиг үүргийг болон техникийн, биечилсэн хяналтыг гардан зохион байгуулж ажилтны үйл ажиллагаа нь аюулгүй байдлыг хангах ажиллагааны үр дүнд шууд нөлөөлж байдаг.

Тиймээс хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны явцад аюул, эрсдэлийг үнэлэхдээ чухам хүний хүчин зүйлээс үүдэлтэй аюул, занал, эрсдэлийн хүрээ, цаг хугацаа, давтамж, учирч болох хохирлын хэмжээг ямар шалгуур, хэмжээсээр үнэлэх нь бусад байгууллагаас ялгагдах өөрмөц онцлог байх юм.

✓ Аюул, эрсдэлийг бий болгох үйл явц нь илүү хор аюултай шинжийг агуулдаг.

Хоригдогч, ялтны хувийн шинж байдлаас шалтгаалан тэдгээрийн зүгээс өөрсдийн гэмт санаа бодлыг хэрэгжүүлэх зорилго нь ихэвчлэн урьдаас төлөвлөсөн, тодорхой үе шатыг дамжин хэрэгждэг.

¹¹⁸ С.Хүрэлсүх. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ. УБ., 2008. 22 дахь тал.

Өөрөөр хэлбэл, хоригдогч, ялтны зүгээс үйлдэгдэж болох бүхий л хор аюул бүхий үйлдэл, буюу зөрчил, гэмт хэрэг нь энгийн нөхцөлд үйлдэгдэхээс илүү нарийн төлөвлөгддөг, хэрэгжих нөхцөл, боломжийг урьдчилан судласан, бусадтай үгсэн тохирсон, ашиглах багаж, зэвсэг, цаг хугацаа, орон зайн нөлөөллийг тооцсон, учруулах хор уршгийн субъектив байдлаар төсөөлж, шууд бий болгоход чиглэгдсэн байх гэх мэт шинжийг агуулдагаараа туйлын онцлог байхын зэрэгцээ илүү ноцтой хор уршиг бүхий аюул, заналыг агуулсан эрсдэлийг бий болгож байдаг.

- ✓ Хорих байгууллагын орчны буюу хорих байгууламж, техник хэрэгслийн нөхцөл, стандартын онцлог.

Аливаа байгууллагын аюул, эрсдэлийг үнэлэх арга хэмжээг үр дүнтэй, оновчтой хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх хэмжүүр нь тухайн байгууллагын үйл ажиллагаа явуулж буй орчин, нөхцөл, аюулаас хамгаалах зориулалт бүхий байгууламж, техник хэрэгслийн хүчин чадал, байршил, ашиглалтын горим зэргийг зайлшгүй тооцох шаардлага гарна.

Хорих байгууллагын хувьд үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан тогтоосон хязгаарлалт бүхий орон зайд хоригдогч, ялтныг нийгмээс тусгаарлах зориулалт бүхий амьдралын байр, хамгаалалтын болон үйлдвэрлэлийн бүс, хашаа, хяналтын цэг, техник хэрэгслээс бүрдсэн байгууламжид аюулгүй байдлыг хангах ажиллагааг хэрэгжүүлдэг учир энэ нь эрсдэлийг үнэлэх арга хэмжээний явцад анхаарах нэг үндсэн онцлог болж өгнө.

- ✓ Хорих байгууллагын байршил, дэд бүтцийн онцлог.

Хорих байгууллагад хамаарагдаж буй хорих ангиуд нь байршлийн хувьд төвлөрсөн суурийн газраас алслагдмал, эсхүл тусгаарлагдсан байдлаар байгуулагдсан байдаг бөгөөд энэ нь эрсдэлийг үнэлэхэд харгалзан үзэх нэг үндсэн онцлог болох учиртай. Хорих ангиудын байршлаас шалтгаалан хангамж, дэмжлэг авах хугацаа, бусад аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагатай хамтран ажиллах нөхцөл, удирдлагын үйл ажиллагааны хүртээмж зэрэг олон эрсдэл үүсгэх нөхцлийг бий болгодог.

Хорих анги, баривчлах цагдан хорих байрнуудын хувьд дийлэнх нь цэвэр бохир усны болон халаалтын төвлөрсөн системд холбогдоогүйн зэрэгцээ цахилгааны найдвартай бус шугамын хэрэглэгч байдаг явдал нь бага бус аюул, эрсдэлийг агуулж байдаг бөгөөд мөн аюул, эрсдэлийг үүсгэх томоохон хүчин зүйл болдог гэж үзэж болно.

- ✓ Хүний нөөцийн чадавхи, хүрэлцээ, бодлогын онцлог.

Хорих байгууллагад өнөөдрийн байдлаар аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий ажлын байранд 1500 орчим албан хаагч үүрэг гүйцэтгэж байгаа судалгаа байдаг бөгөөд энэ нь нийт 25 хорих анги, 24 цагдан хорих, баривчлах байр, 6500 орчим ялтан, хоригдогчид харьцуулж үзвэл аюулгүй байдлын шаардлага хангахгүй дүр зургийг харуулж байна. Аюулгүй байдлын үүднээс авч үзвэл хорих байгууллагын хүний нөөцийн бодлого, чадавхи, хүрэлцээний асуудал нь байгууллагын аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл болохын зэрэгцээ өнөөгийн дутагдалтай байдал нь эрсдэлийг үнэлэх арга хэмжээний явцад анхааран үзвэл зохих нэг үндсэн онцлог шинж болж байна.

Дээрх бүгдээс үзвэл чухамдаа хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд эрсдэлийг үнэлэх арга хэмжээ туйлын чухал үүрэг оролцоотой болох нь харагдаж байгаа хэдий ч бодит байдалд бүрэн дүүрэн хэрэгжиж чадахгүй байгаагийн зэрэгцээ хорих байгууллагын үйл ажиллагааны онцлогийг зайлшгүй харгалзан тасралтгүй хэрэгжүүлэх шаардлага байсаар байна.

Нэг талаас хорих байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон эрсдэлийн үнэлгээний арга зүй дутагдалтай, нөгөө талаас аюулгүй байдал судлал тодорхой түвшинд хөгжөөгүй, энэ чиглэлийн мэргэшсэн судлаачид хангалттай бус байгаа нь нөлөөлж байна гэж үзэж болох юм.

Судлаачийн зүгээс хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаан дахь эрсдэлийн үнэлгээний үүрэг, оролцоо, ач холбогдлыг шаардлагын түвшинд хүргэх чиглэлд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хорих байгууллагын аюулгүй байдлын түвшинг тогтоох, эрсдэлийг үнэлэх арга хэмжээний эрх зүйн үндсийг бий болгох зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд тусгах, хорих байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн эрсдэлийн үнлэгээний аргачлалыг шинээр боловсруулан хэрэгжүүлэх.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагад аюул, эрсдэлийг үнэлэх, аюулгүй байдлын түвшнийг тогтоох чиглэлээр мэргэшсэн бүтэц бий болгох.

3. Хорих байгууллагын албан хаагчдын аюулгүй байдлын мэдлэгийг дээшлүүлэх, эрсдэлийг таних, илрүүлэх, үнэлэх арга зүйд чиглүүлсэн сургалт, сурталчилгаа, чадавхижуулах ажлыг байнга зохион байгуулах.

4. Хорих байгууллагад харьяалагдаж буй нэгжүүдэд тухайн байгууллагын онцлогоос шалтгаалан эрсдэлийг үнэлэх, эрсдэлийн удирлагын үйл ажиллагааг тодорхой давтамжтай, тасралтгүй хийх.

5. Байгууллагын аюулгүй байдлын түвшин, эрсдэлийн үнэлгээ хийх чиглэлээр гадаад улс орны туршлагыг судлах, өөрсдийн хэрэгжүүлж буй ажилд дүн шинжилгээ хийх, энэ чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмолжуулах.

6. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд ашиглагдах, аюул, эрсдэл, үнэлгээ, шинжилгээний төрөлжсөн мэдээллийн санг бий болгон ашиглах зэрэг болно.

Ашигласан материал

1. Д.Адъяабазар. Байгууллага, албан хаагчийн аюулгүй байдлыг хангахад шинэ хандлага чухал. Сүлд-Инфо. УБ., 2015.№01.
2. А.Лхагва. Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж. УБ., 2014.
3. Монгол Улсын Хууль зүйн сайдын 2013 оны 12 дугаар сарын 03-ны А/248 дугаар тушаал. Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал.
4. Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. УБ., 2014.
5. Ш.Паламдорж нар. Гамшгийн эрсдэлийг үнэлэх арга зүй.УБ., 2013.
6. С.Хүрэлсүх. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ. УБ., 2008.
7. С.Хүрэлсүх, Х.Мягмаржав, Ч.Мэндэлмаа. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний зарим асуудлууд. УБ., 2014.

ТАНЫ ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГТ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ БИЧИХЭД АНХААРАХ АСУУДАЛ

С.Гантулга (Ph.D)

Б.Энхболд (Ph.D)

Хууль сахиулахын их сургууль

Хураангуй: Эрдэм шинжилгээний өгүүллийн ойлголт, төрөл, бүтэц, өгүүлэл бичих арга зүй, нийтлүүлэх эрдэм шинжилгээний сэтгүүлийг сонгоход анхаарах асуудлыг талаар дурдсан.

Түлхүүр үг: Эрдэм шинжилгээний өгүүлэл, эрдэм шинжилгээний сэтгүүл, хянан магадлагаа, алхамт загвар.

Эрдэм шинжилгээний зохиолын богино хэмжээний хамгийн нийтлэг хэлбэр нь эрдэм шинжилгээний өгүүлэл юм. Эрдэм шинжилгээний өгүүлэл нь эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж, дүгнэлт өгсөн, шинжлэх ухааны тодорхой мэдээллийг агуулсан бие даасан бичил зохиол юм.

Судлаач бүр эрдэм шинжилгээ, судалгааны ажил, тэр дундаа судалгааны ажлын явцын ба эцсийн үр дүнг тухайн салбарын хэрэглэгчдэд дамжуулах, оюуны бүтээлийг эргэлтэд оруулах зорилгоор эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлэх үүрэгтэй. Нөгөө талаар, олон улсад их, дээд сургуулийн чансааг тодорхойлоход тухайн их, дээд сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилд анхаарч буй байдал, их, дээд сургуулийн эрдэмтэн, судлаачдын туурвисан бүтээл, ялангуяа эрдэм шинжилгээний өгүүллийн чанарыг харгалзан үздэг.

1. Эрдэм шинжилгээний өгүүллийн төрөл:

Эрдэм шинжилгээний өгүүллийг амжилттай бичих эхний алхам бол ямар судалгааны эх сурвалжид тулгуурлан өгүүлээ бичихээс шалтгаалдаг. Иймээс судалгааны эх сурвалжаас нь шалтгаалан эрдэм шинжилгээний өгүүллийг 7 төрөлд ангилдаг.

Тохиолдолд шинжлэх хэлбэрийн өгүүлэл: (Case Study). Тодорхой нэг болон жижиг бүлэг асуудалтай холбогдсон нөхцөл байдал эсвэл түүний онцлог, мөн чанарыг нээн илрүүлэх зорилгоор явуулсан судалгааны үр дүнд үндэслэн бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл. Энэ төрлийн өгүүлэл нь ихэнх тохиолдолд амьдралд бодитойгоор оршин буй юмс үзэгдэлд дүн шинжилгээ хийдэг. Тухайлбал, хүнийг санаатай алах гэмт хэрэгт ял оногдуулахдаа гэмт буруугийн шууд болон шууд бус санааг хэрхэн харгалзаж байгааг тогтоох зорилгоор шүүхээр шийдвэрлэгдсэн ижил төстэй 50 хавтаст хэрэгт дүн шинжилгээ хийх.

Санал асуулгын үр дүнг илтгэх өгүүлэл: (Survey study). Тодорхой үзэгдэл, үйл явдлын талаар олон хүнийг хамарсан судалгааг бичгэн хэлбэрийн санал асуулгын хуудас, эсхүл асуултад хариулаад буцааж илгээх цахим хэлбэрийн санал асуулга болон оролцогчтой шууд ярилцах хэлбэрээр цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар бичсэн өгүүлэл. Энэхүү судалгааны үр дүнгээр тухайн сонирхож буй үзэгдэл, үйл явдлын талаар олон нийтийн хандлага, өмнөх судалгааны ажилтай ижил болон ялгаатай дүгнэлтүүдийг хийж болдог. Тухайлбал, “Монголчуудын цагдаад итгэх хандлага”-ыг тогтоох зорилгоор Улаанбаатар хотын 1000 хүнээс дунд тусгайлан боловсруулсан санал асуулгын хуудсаар 2 сарын хугацаанд судалгаа авч, дүгнэлт хийсэн байна. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо судалгааны арга зүйд тулгуурлан сонгох шаардлагтайг анхаарах шаардлагатай.

Ажиглалтын судалгааны үр дүнг илтгэх өгүүлэл: (Observational research). Ажиглалт нь аливаа юмс үзэгдлийг оршин буй бодит нөхцөл байдалд нь болон лабораторийн нөхцөлд ажиглах гэсэн 2 хэлбэртэй байх бөгөөд аль аль нь судалж буй юмс үзэгдэлд ямар нэгэн өөрчлөлт байгаа эсэх талаар хариулт өгдөг. Ажиглалтын үр дүнг илтгэх өгүүлэл нь зарим тохиолдолд санал асуулгын аргаар бичигдсэн өгүүллийн үр дүнг өөрчилдөг байна. Тухайлбал, Италийн нэрт криминологич, позитивист криминологийн урсгалыг үндэслэгч


Ч.Ломброзо “Гэмт хэрэгтэн бие хүний онол”-ыг боловсруулахдаа Италийн шоронгийн хоригдлуудын дунд 17 жилийн турш ажиглалтын аргаар судалгаа явуулсан байна.

Харилцаа хамаарлын үр дүнг илтгэх өгүүлэл: (Correlational research). Харилцаа хамаарлыг тогтооход чиглэгдсэн өгүүлэл нь нийгэмд бодитоор оршин тогтнож буй хоёр үзэгдлийн хооронд харилцан хамаарал байгаа эсэх, түүний хамаарлын хүч ямар түвшинд байгааг тодорхойлохыг оролддог. Тухайлбал, бид “Ажилгүйдэл ба гэмт хэрэг”, “Согуурал ба гэмт хэрэг”, “Авлига ба гэмт хэрэг” гэсэн хоорондоо уялдаа бүхий хоёр үзэгдлүүдийг тогтмол гэмт хэргийн шалтгаан гэж тайлбарлаж ирсэн боловч тэдгээрийн хамаарлыг тогтоосон нарийвчилсан судалгаа хараахан хийгдээгүй байна. Харин 2007 онд АНУ-ын Вашингтоны их сургуулийн эрдэмтэд “Авлига ба гэмт хэргийн төрөл” сэдэвт харьцуулсан судалгааг 50 улсын түвшинд статистикийн коррелляцын аргаар хийсэн байна. Судалгааны үр дүн нь Авлигын түвшин өндөр улс оронд ахуйн хүрээнд үйлдэгддэг хүч хэрэглэсэн болон өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн түвшин өндөр байгааг харуулсан байна. Харин авлигын түвшин буурах тусам дээрх төрлийн гэмт хэргийн гаралт буурч, эсрэгээрээ албан тушаалын гэмт хэргийн тоо ихсэж байгааг тогтоосон байна.

Тайлбарласан өгүүлэл: (Descriptive study). Тодорхой асуудлыг тайлбарлах, эсхүл ямар нэгэн ойлголтын талаар мэдээлэл олж авах, бусдад түгээхэд чиглэгдсэн ерөнхий болон өвөрмөц нөхцөл байдлыг тодорхойлон тайлбарласан өгүүлэл юм. Ийм хэлбэрийн өгүүлэл нь ихэвчлэн ямар нэгэн бүтэц, загварт баригддаггүй бөгөөд олон улсын эрдэм шинжилгээний хурлын үндсэн илтгэл, үлс хоорондын харилцан ажиллагааны үед өөрийн талын байр суурийг илэрхийлэх болон бусад бодлогын шинжтэй хурал, зөвлөгөөнд түгээмэл хэрэглэгддэг. Түүнээс гадна зарим нэр томъёо, онолын маргаантай ойлголтыг тайлбарлан нэг мөр хэрэглэх зорилгоор энэ хэлбэрийн өгүүллийг бичдэг байна. Өгүүллийн үр дүн нь ихэвчлэн тулгамдсан асуудал байгаа эсэхийг илрүүлэх, тухайн салбар, нөхцөл байдлын талаар мэдээлэл, мэдлэгтэй болгох, эсхүл цаашид хийх судалгааны ажлын чиг хандлагыг тодорхойлох болон тодорхой таамаглалуудыг бий болгодог байна. Тухайлбал, 2013 онд Хууль сахиулахын их сургуулиас зохион байгуулсан “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд профессор С.Жанцан агсаны хэлэлцүүлсэн “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын мөн чанар, бодит байдал, чиг хандлага” илтгэлийг дурдаж болно.

Туршилтын үр дүнг илтгэх өгүүлэл: (Experimental research). Туршилтын судалгаанд тулгуурласан өгүүлэл нь хэд хэдэн хамаарах хувьсагчууд нь (dependent variable) сонгож авсан үл хамаарах хувьсагчид (independent variable) хэрхэн нөлөөлж байгааг математик, статистикийн аргачлалаар шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нарийвчлан тайлбарлах хэлбэрээр бичигддэг. Тухайлбал, доктор (Ph.D) Б.Энхболд “Уугуул Монголчууд ба БНСУ-д оршин суугаа Монголчуудын цагдаад итгэх хандлагын харьцуулсан судалгаа: инструментал болон экспрессив загварчлалаар шалгах нь” сэдэвт эрдмийн зэрэг горилсон бүтээлдээ энэ хэлбэрийг ашигласан байна. Загвар 1-т үзүүлснээр судлаач үл хамаарах хувьсагчаар “Цагдаад итгэх олон нийтийн хандлага” гэсэн 1 хувьсагч, түүнд нөлөөлж болох хамаарах хувьсагчуудаар дараах 10 хувьсагчийг сонгон шалгалт хийж монголчуудын цагдаад итгэх хандлагыг тодорхойлсон байна. Үүнд: 1) гэмт хэргийн чиг хандлага, 2) гэмт хэрэгт хохирох явдал, 3) гэмт хэргээс айх хандлага, 4) нийгмийн эмх замбараагүй байдал, 5) нийгмийн гишүүдийн хоорондын харилцаа, 6) албан бус нийгмийн хяналт, 7) оршин суугчийн статус, 8) Солонгос хэлний мэдлэгийн түвшин, 9) Солонгосын соёлд ууссан байдал, 10) найз нөхдийн холбоо зэрэг болно.

Загвар-1. Монголчуудын цагдаад итгэх хандлагыг шалгах загвар



Соёлын ялгаатай үндэстэн, улс хоорондын түвшинд явуулсан судалгааны үр дүнг илтгэх өгүүлэл: (Cross-Cultural reaserch). Нэг улсын хүн амын дунд суурьшсан соёлын хувьд ялгаатай жижиг үндэстэн, угсаатны зүгээс ямар нэгэн нийгмийн үзэгдэлд хандах хандлага болон судлан буй үзэгдлийн хувьд өөр өөр улс хоорондын соёл, онцлогт хадгалагдах ялгаатай болон нийтлэг шинжийг илрүүлэхэд чиглэгдсэн өгүүлэл хамаарна. Энэ хэлбэрийн илтгэлийг ихэвчлэн санал асуулга болон ажиглалтын аргаар явуулсан судалгаанд тулгуурлан бичдэг. Тухайлбал, өөр хоорондоо ялгаатай улсуудын эрх зүйн зохицуулалт, гэмт хэрэг үйлдэж буй хүмүүсийг шашны онцлогоор нь харьцуулан судлах зэрэг өгүүлэл байна.

2.Эрдэм шинжилгээний өгүүллийн бүтцийн шаардлага

Судлаачид өөрийн судалгааны үр дүн, ололт, нээлтийг бусадтай хуваалцахын тулд өгүүлэл хэлбэрээр олон нийтэд түгээх шаардлагатай болдог. Тиймээс олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлд судлаачдын өгүүлэл, судалгааны ажлыг хүлээн авахдаа хэлбэр, бүтцийн хэд хэдэн шаардлага тавьдаг. Өөрөөр хэлбэл, судлаачид өөрсдийн бичсэн өгүүллийг тухайн сэтгүүлийн шалгуурт нийцүүлэх зайлшгүй шаардлагатай болдог. Тэдгээр нийтлэг шалгуурууд нь зөвхөн сэтгүүлүүдийн хүрээнд яригдах бус судлаачид зайлшгүй эзэмшсэн байх ёстой мэдлэг, чадвар, ёс суртахууны тухай цогц ойлголт юм. Учир нь мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх өгүүлэл нь тусгай загвар, баримталдаг журамтай, түүгээр дамжуулж эрдэм шинжилгээ, судалгааны орчинд мөрдөгдөх дэг жаягийг бий болгодог. Судлаачид эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж гүйцэтгэхийн зэрэгцээ өөрийн орчинд эрдэм шинжилгээний ажлын соёлыг бий болгож, түүнийг бусад судлаач, суралцагчдад дамжуулж байдаг.

Эрдэм шинжилгээний өгүүллийн бүтцэд дараах элементийг ерөнхий болон дэд шалгуур үзүүлэлт болгон авч үздэг байна. Үүнд: Өгүүллийн нэр, хураангуй, түлхүүр үг, удиртгал, судлагдсан байдал, үндсэн хэсэг, хэлэлцүүлэг, дүгнэлт, санал, ашигласан материалын жагсаалт, зохиогчийн тухай мэдээлэл зэрэг болон өгүүллийн чанарт зайлшгүй харгалзах зүйл болох ишлэл авсан байдал, бичиглэл зэргийг үнэлгээний ерөнхий шалгуур- үзүүлэлтээр авч, эдгээр шалгуурын илрэх шинжийг дэд үзүүлэлт болгон авсан. Эдгээр дэд үзүүлэлт нь үнэлгээний хэмжилт хийх шинжүүд юм. Эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах 11 шалгуур-ерөнхий үзүүлэлт, 24 дэд үзүүлэлтийг хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт №1

Эрдэм шинжилгээний өгүүллийн чанарт тавигдах ерөнхий ба дэд шалгуур үзүүлэлт	
Үнэлгээний ерөнхий үзүүлэлт (Эрдэм шинжилгээний өгүүллийн бүтэц)	Үнэлгээний дэд үзүүлэлтүүд
1. Өгүүллийн нэр Title (Өгүүллийн нэр нь сэдэв, агуулга, үр дүнгийн мөн чанарыг, илэрхийлэхийн зэрэгцээ, уншигчийн хэрэгцээ, сонирхол татахуйц байх)	1.1.Өгүүллийн нэр нь өгүүллийн агуулгыг оновчтой илэрхийлэхүйц судалгааны мөн чанарыг тусгасан цөөн үгээр илэрхийлсэн байх; (10 хүртэл үг) 1.2.Өгүүлбэр зүй, Монгол хэлний зөв бичих дүрмийн алдаагүй байх.
2. Хураангуй Abstract (Юу хийсэн?) (Хураангуй нь өгүүллийн нэрийн өргөтгөсөн хувилбар буюу тухайн өгүүллийн талаар зохиогчоос хийсэн тодорхойлолт юм.)	2.1.Судалгаанд ямар сэдвийг, ямар үндэслэлээр сонгон судалснаа товч тодорхойлох; (Ямар асуудлыг, яагаад сонгон судалсан?) 2.2.Судалгаагаанд ямар асуудлыг, яаж шийдвэрлэсэн; (Юуе, яаж хийсэн?) 2.3.Судалгааны үр дүн нь бусад судлаачдын төстэй судалгааны үр дүнгээс ямар ялгаатай. (Юуе шинээр батлан тогтоосон буюу шинэчлэн сайжруулсан?) 2.4.Хураангуйгаас өгүүллийн талаар ерөнхий ойлголт авах боломжтой эсэх, зохих хэмжээндээ бичигдсэн байх (250 үгэнд багтсан байх).
3. Түлхүүр үгс Keywords	3.1.Түлхүүр үгийг сонгож хэрэглэсэн байдал (Өгүүллийн үндсэн утга санааг төлөөлөхүйц 5 хүртэл үгийг нэрлэхийн тийн ялгалын ганц тоонд бичих, гарчигны үг оруулж болно)
4. Удиртгал хэсэг (Оршил) Introduction	4.1.Судалгааны объект, зорилго, зорилтоо тодорхойлж, таамаглал дэвшүүлсэн байдал; 4.2.Тухайн судалгаатай холбоотой өмнөх эх сурвалжийн судалгаа, ишлэл авсан байдал; 4.3.Судалгааны ажлын шийдвэрлэвэл зохих тулгамдсан чухал асуудал болохыг илэрхийлсэн байдал.
5. Судлагдсан байдал Literature review	5.1.Судалгааны объектыг бусад судлаачид судалсан байдал, тэдний арга, аргачлал
6. Үндсэн хэсэг	6.1.Онолын үндэслэл 6.2.Таамаглал дэвшүүлсэн байдал (Hypothesis) 6.3.Дэвшүүлсэн таамаглалыг шалгах судалгааны арга, аргачлал (Судалгаанд хэрэглэсэн арга, аргачлал, хэрэглэгдэхүүн, туршилт, хугацаа, түүвэр, хамарсан хүрээ, үр дүнгийн боловсруулалт) Уг судалгааг тухайн арга, аргачлалаар өөр судлаач давтан хийхэд боломжтой, ойлгомжтой байх; 6.4.Судалгааны үр дүнг илэрхийлсэн байдал (Оршилд дэвшүүлсэн таамаглал хэрхэн батлагдсан, үр дүнгийн баталгаа, бодит байдал).

7. Хэлэлцүүлэг Discussion	7.1.Судалгааны ач холбогдол, түүний үр дүнг практикт хэрхэн хэрэглэх; 7.2.Бусад судлаачдын судалгааны үр дүнтэй харьцуулан дүн шинжилгээ хийж, зөвлөмж, санал дэвшүүлсэн байдал; 7.3.Судалгааны цаашдын чиглэл, алхам юу байх.
8. Дүгнэлт, санал Conclusion, recommendation (Ямар үр дүнд хүрэв?)	8.1.Дэвшүүлсэн зорилго, таамаглалтай холбож, судалгааны үр дүнгээс дүгнэлт гаргасан байдал; (Дүгнэлт нь онол, практикийн ач холбогдолтой цөөн 3-5 заалтыг тезис хэлбэрээр бичсэн, дүгнэлт нь хураангуйтай давхцахгүй байх) 8.2.Дэвшүүлсэн санал бодитой, судалгаагаар нотлогдсон, практикт хэрэгжих, үр дүнд хүрэх боломжтой эсэх.
9. Ашигласан материал Reference	9.1.Ашигласан материалыг Их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стандартыг баримтлан бичсэн байдал.
10. Бичлэгийн стандарт, зааврыг баримталсан байдал	10.1.Олон Улсын болон Их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стандартыг баримталсан байдал; (Энэ нь эрдэм шинжилгээний өгүүлэл бичих олон улсын нийтлэг жишигт хэрхэн нийцэж байгаа) 10.2.Монгол хэлний зөв бичих дүрэм, техникийн алдаагүй байх.
11.Ишлэл авсан байдал	11.1.Ишлэлийг олон улсад мөрдөж байгаа журамд нийцүүлэн хийсэн байдал (APA, MLA болон бусад)

3.Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, хэвлүүлэх алхамт загвар¹¹⁹

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зөвхөн эрдэмтэд хийдэг байсан цаг үе нэгэнт ард хоцорч одоо судалгааны ажил хийх хүсэлтэй хүмүүс хүссэн чиглэлээрээ судалгаа хийх боломжтой болоод байна.

Эрдэм судлалын ажлын тайлагнах хэлбэрүүдийн нэг болсон эрдэм шинжилгээний өгүүлэл бичих процессыг системийн онолд тулгуурлан алхамт загварын аргачлалаар тайлбарлая.

А.Өгүүлэл бичих арга зүй

Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих арга зүйн тухай хэлэлцэхийн өмнө судалгаа, шинжилгээний ажлыг хийх шаардлага болоод хэрхэн судалгааны ажил хийх талаар товчхон авч үзье. Ч.Авдай, Д.Энхтуяа (2007) “Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй” номондоо тодорхойлсныг иш татвал: Аливаа судалгаа шинжилгээний ажил нь тодорхой зорилго, төлөвлөгөө, үе шаттай явагдана. Судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ дараах дэс дарааллыг баримтлана. Үүнд:

- Судалгаа шинжилгээний ажлын сэдвийг сонгож зорилгоо тогтоох;
- Судлах гэж байгаа зүйлийнхээ одоогийн байдлыг судалж зохих дүгнэлт өгсөн байх;
- Энэхүү дүгнэлт дээрээ үндэслээд уг объектын хувьд чухам юуг ялган авч судлах гэж байгаа, өөрөөр хэлбэл зорилтоо тодорхойлох;
- Судалгааны аргачлал боловсруулах;
- Судалгаа явуулах;
- Судалгааны үр дүнг боловсруулж дүн шинжилгээ хийх;
- Судалгааны үр дүнгээр дүгнэлт, зөвлөмж гаргах;

¹¹⁹ Т.Уранчимэг. “Судалгааны өгүүлэл бичих, хэвлүүлэх алхамт загвар” судалгааны өгүүлэл. “Эрдэм шинжилгээний өгүүллийн чанарыг сайжруулахад тулгамдаж буй зарим асуудал” сэдэвт сипозиумийн илтгэлийн эмхтгэл. Дээд боловсрол судлалын Монголын Нийгэмлэг. УБ., 2016. 25-28 дахь тал

- Судалгааны үр дүнг бичлэгийн хэлбэрт оруулах гэсэн алхамууд багтаж байна.

Б.Цогбадрах өөрийн илтгэлдээ эрдэм шинжилгээний өгүүлэл бичих дарааллыг тодорхойлжээ. Түүний бичсэнээр:

- Бэлтгэл үе
- Тухайн сэдэвтэй холбоотой ном, зохиол, судалгааны материал цуглуулах үе
- Бичилтийн үе
- Хянах, нягтлах, шалгах үе гэсэн үе шаттай байна.

Улмаар Б.Цогбадрах өөрийн илтгэлдээ шинжлэх ухааны сэтгүүлд бие даан хийсэн судалгааны өгүүлэл гаргах судалгааны өгүүллийн бүтцүүдийн нэг болох IMRAD (Introduction, Method, Results, and Discussion) бүтцийн талаар дурдсан байна. IMRAD бүтэц дээр тулгуурлан өгүүллийн бүтэц ямар байхыг:

- Удиртгал (5%)
- Арга, хэрэглэгдэхүүн (10-15%)
- Үрдүн (50-60%)
- Хэлцэмж (20-30%)
- Иш татсан ном хэвлэлийн жагсаалт
- Товчлол, түлхүүр үгс
- Хавсралт гэсэн байдлаар тодорхойлдог. Энэ мэтээр олон тооны судалгааны өгүүллийг түүвэрлэн анализ хийж болно. Эрдэм шинжилгээний өгүүллийн бүтцийн шаардлагын өмнө авч үзсэн тул эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, хэвлүүлэх алхамт загварт дурдаагүй болно.

Б.Алхамт загвар

Бидний үзэж байгаагаар, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих нь судлаач бүрийн заавал эзэмшвэл зохих нэгэн чадвар юм. Аливаа чадварыг суралцах арга замаар өөртөө бий болгож болно. Иймд эрдэм шинжилгээний өгүүлэл бичих аргачлал буюу “Алхамт загвар”-ын талаар өгүүлье.

Үндсэн санаа: Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих асуудлыг тогтолцооны онол буюу системийн онолын үүднээс харах шаардлагатай. Системийн ерөнхий онолыг (General systems theory) XX зууны 30-аад онд Австрийн биологич, онолч Людвиг фон Берталанфи боловсруулжээ. Түүний онолоор аливаа зүйлийг тус тусад нь салгаж үзэх биш харин тогтолцоогоор нь буюу бүхлээр нь харах нь зүйтэй.

Энэхүү онолыг эрдэм шинжилгээний өгүүлэл бичих үйлд ашиглах нь зүйтэй хэмээн үзэж доорх санааг дэвшүүлж байна. Үүнд:

- Алхам 1. Судалгааны чиглэлээ тогтоох;
- Алхам 2. Тогтоосон чиглэлээрээ суурь уншлага хийж, уншиж судалсан материалуудаараа системтэй тэмдэглэл үүсгэн мэдээллийн сан бүрдүүлэх;
- Алхам 3. Цуглуулсан сан дээрээ дүгнэлт өгч өөрийн оруулах хувь нэмрийг тодруулах;
- Алхам 4. Эхэлж байгаа судалгааныхаа шинэлэг санааг баталгаажуулах зорилгоор чиглэсэн уншлагуудыг хийх;
- Алхам 5. Санаагаа дүрсжүүлэх;
- Алхам 6. Санаагаа математик аппаратаар томъёолох;
- Алхам 7. Ханан илтгэл хэлэлцүүлэх;
- Алхам 8. Нэг хуудсанд багтаан санаагаа шинжлэх ухааны үндэслэлтэй болгон бичих;
- Алхам 9. 2 хуудас товч өгүүллийг эх хэл дээрээ бичих;
- Алхам 10. Бичсэн өгүүллээ мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлэх;
- Алхам 11. Дотоодын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх;
- Алхам 12. Бүрэн хэмжээний өгүүллийг 4-8 хуудсанд багтаан бичих;
- Алхам 13. Мэргэжлийн сэтгүүлд бүрэн хэмжээний өгүүлэл нийтлүүлэх;
- Алхам 14. Гадаад хэл дээр богино хэмжээний өгүүлэл бичих;

Алхам 15. Олон улсын хуралд богино хэмжээний өгүүлэл илгээх, засварлах давтан илгээх;


Алхам 16. Илтгэлийг хянаж гадаад хэл дээр хэлэлцүүлэх;

Алхам 17. Бүрэн хэмжээний өгүүллийг гадаад хэл дээр бичих;

Алхам 18. Олон улсын хуралд бүрэн хэмжээний өгүүлэл илгээх, засварлах давтан илгээх;

Алхам 19. Олон улсын хуралд аман илтгэл хэлэлцүүлэх;

Алхам 20. Гадаадын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл илгээх, засварлах давтан илгээх, хэвлүүлэх.



Зураг 1. Алхамт загвар

4.Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх мэргэжлийн сэтгүүлийг сонгох асуудал

Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллага, их, дээд сургууль, судалгааны байгууллагуудаас хэд хэдэн сэтгүүлийг тогтмол эрхлэн гаргадаг. Үүнд:

№	Эрхлэн гаргадаг байгууллага	Чиглэл	Сэтгүүлийн нэр
1.	Улсын Дээд Шүүх	Хууль зүй	Монголын төр, эрх зүй
2.	Шүүхийн ерөнхий зөвлөл		Шүүх эрх мэдэл
3.	Үндсэн хуулийн цэц		Үндсэн хуулийн шүүх эрх мэдэл
4.	Хүний эрхийн үндэсний комисс		Хүний эрх
5.	Авлигатай тэмцэх газар		Шударга ёс
6.	Хууль зүйн үндэсний хүрээлэн		Хууль дээдлэх ёс
7.	Монголын Хуульчдын холбоо		Mongolian law review
8.	Монголын өмгөөлөгчдийн холбоо		Өмгөөлөгч
9.	МУИС-ийн Хууль зүйн сургууль		Эрх зүй
10.	Их засаг олон улсын их сургууль		Их засаг
11.	Стратегийн судалгааны хүрээлэн	Стратеги	Стратегийн судалгаа
12.	Олон улсын харилцааны хүрээлэн	Аюулгүй байдал, гадаад бодлого, олон улсын харилцаа	Олон улс судлал
13.	Боловсролын шинжлэх ухааны академи	Сурган, заах арга зүй	Боловсрол судлал
14.	ТЕГ-ын Үндэсний тагнуулын академи	Аюулгүй байдал	Тусгаар тогтнол

15.	МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн сургууль	Түүх-Монгол судлал	Монгол судлалын чуулган
-----	--	--------------------	-------------------------

Хууль сахиулахын их сургуулийн бүрэлдэхүүн сургууль, нэгжээс хэд хэдэн эрдэм шинжилгээний сэтгүүлийг эрхлэн гаргадаг. Үүнд:

№	Эрхлэн гаргаж буй бүрэлдэхүүн сургууль, нэгж	Сэтгүүлийн нэр	Эрхлэн гаргаж эхэлсэн он
1.	Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн	Хууль сахиулахуй	2014
2.	Хэвлэл, редакцийн хэлтэс, Монголын Криминологчдын холбоо	Гэмт явдалтай тэмцэх асуудал	2002
3.	Хууль сахиулахын удирдлагын академи	Хууль сахиулахуйн удирдлага	2014
4.	Цагдаагийн сургууль	Цагдаа судлал	2012
5.	Хилийн сургууль, Монголын хил судлалын үндэсний нийгэмлэг	Хил судлал	1997
6.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал	2011
7.	Онцгой байдлын сургууль	Гамшгийн эрсдэл судлал	2013

1665 онд Францын нийслэл Парис хотноо “*Journal des savants*” сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдэн гарч байсан бол өнөөдөр дэлхий даяар хэдэн арван мянган эрдэм шинжилгээний сэтгүүл хэвлэгдэн гарч, тэдгээрт хэдэн саяар тоологдох эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдэж байна. Зөвхөн 2014 онд Томсон-Ройтерсын индекстэй 287 нийгмийн шинжлэх ухааны сэтгүүлд 22715 өгүүлэл хэвлэгджээ.

Эрдэм шинжилгээний сэтгүүл, өгүүлэл, судлаачдын тоо хэт олширсноос шалтгаалан аливаа нэгэн эрдэм шинжилгээний сэтгүүл, хувь судлаачийн ажлын чансааг өөр нэг сэтгүүл буюу судлаачийн санал, шүүмжлэлээр (реценз) дүгнэхэд улам бүр хүндрэлтэй болж байна. Үүнтэй холбоотойгоор өнгөрсөн зууны дунд үед үндэс суурь нь тавигдсан гэж үздэг сайентометрикийн ухаан сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байна.

Тиймээс дэлхийн нэр хүнд бүхий сэтгүүлүүд ихэнх тохиолдолд нь математик, статистикийн аргачлалаар судалгааны эх сурвалжид боловсруулалт хийсэн эрдэм шинжилгээний өгүүллийг хүлээж авах хандлагатай болсон бөгөөд энэ шалгуураар судалгааны ажлын үр дүн бодит үнэнд нийцсэн эсэхийг дүгнэдэг байна.

Судлаач нь эрдэм шинжилгээний өгүүлээ ямар сэтгүүлд нийтлүүлэх талаар судалгаа хийх шаардлагатай. Сэтгүүлүүдийн нэр хүнд, хамрах хүрээ харилцан адилгүй байх тул сонголтыг зөв хийх хэрэгтэй. Судлаач өөрийн салбарын нэр хүнд бүхий сэтгүүлийн талаар хангалттай мэдээлэлтэй байх нь чухал. Тиймээс эрдэмтэн, судлаачдад эрдэм шинжилгээний өгүүлээ нийтлүүлж болох олон улсад нэр хүнд бүхий мэргэжлийн сэтгүүлүүдийн талаар мэдээлэл хүргэе.

Хууль сахиулах салбарын нэр хүнд бүхий 57 сэтгүүлийн эхний аравт эрэмбэлэгдэж буй сэтгүүлийн жагсаалт (2015 он)

Эрэмбэ	Сэтгүүлийн нэр	Эрхлэн гаргадаг улс
1.	Criminology	АНУ
2.	Crime and Delinquency:	АНУ
3.	Criminal Justice and Behavior	АНУ
4.	Sexual Abuse: A Journal of Research and Treatment:	АНУ
5.	Journal of Criminal Law and Criminology	АНУ
6.	British Journal of Criminology	Их Британи
7.	Journal of Research in Crime and Delinquency	АНУ

8.	Journal of Quantitative Criminology	АНУ
9.	Punishment & Society	АНУ
10.	Journal of Interpersonal Violence	АНУ

Эх сурвалж: <http://libguides.unf.edu/c.php?g=177086&p=1163690>

Хууль сахиулах салбарын нэр хүнд бүхий 57 сэтгүүлийн эхний аравт эрэмбэлэгдээгүй боловч эрдэм шинжилгээний өгүүллээ илгээх боломжтой сэтгүүлийн жагсаалт (2015 он)

Салбар	Сэтгүүлийн нэр	Эрхлэн гаргадаг улс
Цагдаа судлал	<u>Police Practice & Research: An International Journal</u>	АНУ
	<u>Police Quarterly</u>	АНУ
	<u>Policing: An International Journal of Police Strategies & Mangement</u>	АНУ
	<u>Policing & Society</u>	АНУ
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал	<u>Corrections Today</u>	АНУ
	<u>Punishment & Society: The International Journal of Penology</u>	АНУ
Шинжлэн магадлахуй	<u>Journal of Forensic Sciences</u>	АНУ
	<u>Forensic Science Guide to Crime Science Investigation</u>	АНУ

Эх сурвалж: <http://libguides.unf.edu/c.php?g=177086&p=1163690>

Дээрх эрэмбийг олон улсад нэр хүнд бүхий Elsevier өгөгдлийн сангийн мэдээлэлд тулгуурлан жил бүр гаргадаг бөгөөд олон улсын шинжтэй сэтгүүлүүдийг эрэмбэлэдэг. Зөвхөн хууль сахиулах салбарын эхний аравт багтсан болон энэ салбарын эрдэмтэн, судлаачид өгүүллээ илгээх боломжтой сэтгүүлийн жагсаалтыг харууллаа. Эдгээр сэтгүүлүүд нэр хүндтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тул өгүүлэл нийтлүүлэхэд хялбархан биш боловч өгүүлэлд тавигдах шаардлага зэргээс хамаарч судалгааны арга зүй эзэмшихэд олон талын ач холбогдолтой. Ерөнхийдөө сэтгүүлүүд өөрсдийн баримталдаг бодлого, зорилго зэргээс хамаарч өгүүлэл хүлээн авахдаа редакцийн хяналт хатуу тавьдаг. Нөгөө талаас, сэтгүүлүүд нь судлаачийн бүтээлийг агуулгын хувьд өмнө нь дугаарт хэвлэгдэж байсангай төстэй, дэвшүүлж буй санал нь шинэлэг биш, эсхүл дүгэлтүүд нь судалгааны арга зүйд тулгуурлаагүй байна гэж үзсэн тохиолдолд хэвлэхээс татгалздаг. Тиймээс судлаачид мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх зорилгын хүрээнд тухайн сэтгүүлийн талаар мэдээлэл сайтай байх шаардлагатай.

Дүгнэлт

1. Судлаачдын нийтлүүлсэн өгүүлэл нь онолын үндэслэл, судалгааны арга зүйд тулгуурлаагүй, зөвхөн юмс үзэгдлийг тодорхойлон тайлбарласан танин мэдэхүйн шинжтэй байгаа нь тэд судалгааны арга зүйн мэдлэг, чадвар хангалтгүй байгааг илтгэж байна.

2. Олон улсын болон дотоодын сэтгүүлд эрдэм шинжилгээний чанартай өгүүлэл хэрхэн бичих, олон улсын түвшинд эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах наад захын жишиг шаардлага, судалгааны арга зүй болон хууль зүйн салбарын эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авдаг сэтгүүлийн жагсаалт, түүнд бүтээлээ илгээх аргачилсан зөвлөмж дутагдалтай байна.

Санал

1. Багш, судлаачид судалгааны арга зүйн түвшнээ байнга дээшлүүлж, судалгаанд суурилсан олон улсын шаардлагад нийцсэн эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэх, тооноос чанарт анхаарах;

2. Их сургуулийн магистр, докторын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан судалгааны арга зүй хичээлийн агуулга, хэлбэрийг шинэчлэх, бакалаврын сургалтад судалгааны арга зүйн үндэс, гэмт хэргийн статистикийн үндэс хичээлийг заах;
3. Судлаачдад эрдэм шинжилгээний өгүүлэл бичих, илгээх, засварлах нийтлүүлэх талаар онлайн сургалт зохион байгуулах;
4. Гадаад хэлний өндөр мэдлэгтэй судлаачид болон тухайн чиглэлийн эрдэмтэд хамтран салбарын зангилаа асуудлаар бодлогын чанартай эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж, дотоодын болон олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлд нийтлүүлэх, багш судлаач, суралцагч багаар ажилладаг соёлыг нутагшуулах;
5. Мэргэжлийн сэтгүүлийн редакцийн зөвлөл энэхүү өгүүлэлд заасан өгүүллийн бүтцийн шаардлагыг хангасан өгүүллийг хүлээн авч нийтлэх бодлого баримтлах, судлаачдад эрдэм шинжилгээний өгүүллийн чанарыг сайжруулах талаар зөвлөмж өгч ажиллах;
6. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, нийгмийн шинжлэх ухааны салбарт ишлэл авах эрх бүхий импакт, фактор бүхий сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн багшид урамшуулал олгох, хөнгөлөлт үзүүлэх, жил бүр шилдэг эрдэм шинжилгээний өгүүллийг шалгаруулж, грант олгох;
7. Их, дээд сургуулийн профессор багшийн эрдэм шинжилгээний багц цаг тооцох журмыг шинэчилж, зөвхөн эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах олон улсын болон дотоодын стандарт, бүтцийн шаардлага хангасан бүтээлд багц тооцох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх;
8. Эрдэм шинжилгээний өгүүллийн нэгдсэн мэдээллийн сан бий болгох.

Ашигласан материал

Илтгэл, өгүүлэл, тайлан

- Дээд боловсрол судлалын Монголын нийгэмлэг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Монголын их, дээд сургуулиудын консорциум, Монгол Улсын Боловсролын их сургууль. “Эрдэм шинжилгээний өгүүллийн чанарыг сайжруулахад тулгамдаж буй зарим асуудал” симпозиумын илтгэлийн эмхтгэл. УБ., 2016
- Rich R. empirical political analysis; research methods in political science 4th ed., N.Y. Longman. 1995
- Ж.Давааням. "Монгол Улсын их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгааны өнөөгийн байдал" судалгааны тайлан. 2016
- Ц.Мөнхбат (2010), “Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих чадвар” илтгэл,
- П.Нямдаваа (2012), “Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл бичих хэрхэн вэ?” илтгэл
- Б.Цогбадрах (2014), “Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих арга зүй” илтгэл

Эрдэм шинжилгээний сэтгүүл

- Монгол Улсын боловсролын их сургууль. Эрдэм шинжилгээний бичиг. Лавай. №14
- Хууль сахиулахын их сургууль. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл. 2014. №1 (01),
- Хууль сахиулахын их сургууль. “Хууль сахиулахуй” онол, арга зүйн сэтгүүл. 2015. №3, 4 (07, 08)
- Хууль сахиулахын их сургууль, Монголын Криминологичдын холбоо. “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүл. 2016. №1 (55)

Цахим эх сурвалж:

1. <https://www.timeshighereducation.com/world-university-rankings>